

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 оны 12 дугаар сарын 06

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ /ямар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ/	Хэрэгжилтийн явц	Хүрсэн үр дүн
Нэг. “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:			
1.1	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 1,2,3,4,6,7 дугаар зорилго, зорилт-ын хүрээнд:</i></p> <p>Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 3513 объектод 24 хяналтын чиглэлээр 4940 хяналт шалгалтыг хийх</p>	<p>- НМХГ-аас 2019 онд нийт Шилэн хяналтын цахим системд 4700 хяналт шалгалт, 2754 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 2019 онд 4659 (99,1%) хяналт шалгалт, 2590 (94.0%) зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>- Шилэн хяналтын цахим системд бүртгэсэн бусад хяналт шалгалтын гүйцэтгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар НМХГ-ын хэмжээнд 676 объектод тандалт судалгаа, 325 объектод хяналт шинжилгээ, 7982 объектод урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт, 408 объектод баталгаажуулах үйл ажиллагаа, 1277 объектод салбарын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>1.Хүнсний үйлдвэрийн хяналтын чиглэлээр:</p> <p>1.“Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 02-01/79 тоот удирдамжаар 114 хүнсний үйлдвэрийг шалгах агаас 98 үйлдвэр буюу 85.9 хувь нь хамрагдсан. 1.1.1, 1.2.1 кодтой хяналтын хуудасны үнэлгээгээр 2 их, 70 дунд, 26 бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн. Шалгалтаар 251 зөрчил илэрснээс 189 буюу 75.3 хувийг нь арилгуулсан. Зөрчил гаргасан 16 аж ахуйн нэгж, иргэнд 17050.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 240 заалт бүхий 25 албан шаардлага, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 9 албан даалгавар хүргүүлсэн. Шалгалтад хамрагдсан нийт объектын 71 хувь буюу 60 үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт хийхэд биелэлт 74 хувьтай, 7 үйлдвэр их эрсдэлтэйгээс дунд руу, 4 үйлдвэр дунд эрсдэлтэйгээс бага руу шилжин, шалгалтаар эрсдэл үүсэх магадлал 40.4 хувьтай байсныг гүйцэтгэлээр 30.5 буюу 9.8 хувиар бууруулж, хууль сахин мөрдөлтийн түвшинг 60 хувьтай байсныг гүйцэтгэлийн хяналтаар 69.5 хувь буюу 9.5 хувиар нэмэгдүүлсэн дүнтэй байна.</p> <p>Хяналтын 8 чиглэлээр хийгдсэн шалгалтын дүнг нэгтгэж газрын даргын зөвлөлийн 2019.06.26-ны өдрийн 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, МХЕГ-ын ХАБХААХГ-т шалгалтын танилцуулга, дүнг хурлын шийдвэрийн хамт 2019.07.01-ний өдрийн №02-01/2706 тоот албан бичгээр</p>	<p>1.Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг гүйцэтгэлийн хяналтаар 5.7 пунктээр нэмэгдүүлсэн.</p> <p>2.Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 5.1 пунктээр нэмэгдүүлсэн. /албан шаардлага, торгууль, нөхөн төлбөр/</p> <p>3.Зөрчил арилгуулалтын түвшинг 5.7 пунктээр нэмэгдүүлсэн.</p> <p>4.Гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшинг 5 пунктээр нэмэгдүүлсэн.</p> <p>5. Хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 5.3 пунктээр бууруулсан байна.</p> <p>6.Хяналт шалгалтын ажлыг 1135 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, боловсруулж хүргүүлсэн</p> <p>7.Шилэн хяналтын цахим мэдээллийн сангаар гүйцэтгэл,</p>

	<p>хүргүүлсэн. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлт 67.0 хувьтай хэрэгжсэнийг Хууль эрх зүйн хэлтэст гаргаж өгч ажиллалаа.</p> <p>2. Нийслэлийн хэмжээнд “Ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 02-01/101 тоот удирдамжаар гурилан бүтээгдэхүүний 33, согтууруулах ундааны 3, жижиглэн савалгаатай бүтээгдэхүүний 2, нийт 38 үйлдвэрийг зарласнаас 35 үйлдвэр цех буюу 89.7 хувь нь хамрагдаж 5 хяналтын хуудасны үнэлгээгээр 2 их, 24 дунд, 9 бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Шалгалтаар 268 зөрчил илэрснээс 164 буюу 61.6 хувийг нь арилгуулсан. Зөрчил гаргасан 15 аж ахуйн нэгж, иргэнд 14300 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 172 заалт бүхий 17 албан шаардлага, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 9 албан даалгавар хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хяналтыг биелэлт ирүүлсэн 27 үйлдвэр цехэд хийхэд 2 нь их, 16 дунд, 9 нь бага эрсдэлтэй болж эрсдэл буурч хууль сахин мөрдөлт 13 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Төлөвлөгөөт шалгалтын дүнг нэгтгэж танилцуулга гарган, газрын даргын зөвлөлийн 2019.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж МХЕГ-ын ХАБХААХГ-т шалгалтын танилцуулга, дүнг хурлын шийдвэрийн хамт 2019.06.14-ний өдрийн №02-02/2416 тоот албан бичгээр хүргүүлсэн. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлт 69.0 хувьтай хэрэгжсэнийг Хууль эрх зүйн хэлтэст гаргаж өгч ажиллалаа.</p> <p>2.Худалдааны хяналтын чиглэлээр:</p> <p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 02-01/74 тоот “Худалдаа, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 270 хүнсний худалдааны газраас 13 газар үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчилсөн, зогсоосон шалтгаантайгаар хамрагдаагүй, 257 газар буюу 95.1 хувь нь хамруулан “Худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас” /200 м дээш, доош/ -аар шалгахад 87 буюу 32 хувь нь их, 170 буюу 66.1 хувь нь дунд эрсдэлтэй байснаас төлөвлөгөөт шалгалтын үр дүнд 4 буюу 1.5 хувь нь их буюу эрсдэл буураагүй хэвээр, 138 буюу 53.6 хувь нь дунд, 115 буюу 44.7 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, их дунд эрсдэлтэй объектын 32 хувь нь бага дунд эрсдэл рүү шилжиж, дунд эрсдэлтэй объектын тоо 12 хувиар өсч, бага эрдэлтэй объектын тоо 44.0 хувиар өссөн дүнтэй байна.</p> <p>Шалгалтаар 1403 зөрчил илрүүлж, 887 буюу 63.2 хувийг арилгуулж ажиллалаа. Хяналт шалгалтын явцад хялбаршуулсан журмаар 65, зөрчлийн 4 хэрэг нээж, зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 677 заалт бүхий 66 албан шаардлага, 37 албан даалгавар өгч, үр дүнг тооцоход хэрэгжилт 73.2 хувьтай байна. Шалгалтын явцад илэрсэн зөрчил бүхий 64 хуулийн этгээд, хувь хүнд 65.377.5 төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, 62.927.5 төгрөгийг барагдууллаа. Чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, муудсан, хадгалалтын хугацаа</p>	<p>үр дүнг тооцоход 99.1%-тай байна.</p>
--	--	--

дууссан 63 нэр төрлийн 2418 ширхэг, 17кг, 3.960.650 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураах актаар, зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан 29 нэрийн 157 ширхэг, 355.890 төгрөгийн тамхийг улсын орлого болгуулахаар улсын байцаагчийн акт тогтоон, албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах” нийслэлийн зөвлөлд шилжүүлсэн байна. Хаяг шошгын шаардлага хангаагүй 14 нэр төрлийн, 8200 төгрөгийн хүнсний хүнсний сүлжээнээс татан авалт хийлгүүлсэн.

МХЕГ-т хяналт шалгалтын таницуулга, хурлын шийдвэрийг 02-01/2576 тоот албан бичгээр, 07/04 тоот хурлын шийдвэрийг 13 аж ахуйн нэгжийн зах худалдааны төвүүдэд 02-01/2577 тоот албан бичгээр тус тус хүргүүлээ. Тус хурлын шийдвэрийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тус журмыг батлан гаргаж мөрдүүлэх тухай саналыг МХЕГ-аас 2019.11.18-ний өдрийн 02/3638 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3. Хоол үйлдвэрлэлийн хяналтын чиглэлээр:

НМХГ-ын даргын баталсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай”, “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай”, Ерөнхий боловсролын сургууль, Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжуудийн хүрээнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийтийн үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 262, сургуулийн дэргэдэх 17, цэцэрлэгийн 36 гал тогоо зэрэг 310 хоолны газар буюу 98 хувь нь хяналт шалгалтад хамрагдсан, 5 аж ахуйн, нэгж үйл ажиллагааны чиглэл өөрчилсөн, түр буюу бүрмөсөн зогссон байна.

Шалгалтад хамрагдсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг 3 хяналтын хуудсаар дүгнэхэд 41 буюу 13 хувь нь бага, 193 буюу 62 хувь нь дунд, 76 буюу 24 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн.

Шалгалтаар 1518 зөрчил илрүүлж 1180 буюу 77 хувийг арилгуулсан, 74 аж ахуйн нэгж, иргэнд 543 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 59 аж ахуйн нэгж, иргэнд 301 заалт бүхий албан даалгаваар хугацаатай үүрэг өгч, 700 заалт буюу 82.9 хувь нь биелэгдсэн байна.

Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн 9 аж ахуйн нэгж, иргэнд зөрчлийн хэрэг нээн 4 аж ахуйн нэгжид 8000.0 мянган төгрөг, 5 иргэнд 2800.0 мянган төгрөг, 70 аж ахуйн нэгж, иргэнд хялбаршуулсан журмаар хэрэг нээн 19 аж ахуйн нэгжид 17350.0 мянган төгрөг, 51 иргэнд 12200.0 мянган төгрөг, нийт 40350.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдууж, 1 аж ахуйн нэгжийн рестораны үйл ажиллагааг улсын ахлах байцаагчийн актаар түр хугацаагаар зогсоож, 7 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх саналыг Улаанбаатар хотын

Захирагчийн ажлын албанд 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 02-01/2295 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Шалгалтын нэгдсэн танилцуулгыг 2019.06.20-ны өдрийн НМХГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, танилцуулгыг 2019.06.25-ны өдрийн 02-01/2594 албан тоотор МХЕГ-ын ХАБХААХГ-т хүргүүлсэн.

4. Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр:

НМХГ-ын даргын “Малын эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 02-01/126 дугаартай удирдамжийн хүрээнд малын эмийн үйлдвэр 1, эмийн сан 29, эм ханган нийлүүлэх байгууллага 6, нийт 36 ААН зарлагдсанаас 28 эмийн сан, 6 эм ханган нийлүүлэх байгууллага, нийт 34 ААН буюу 94.0 хувь нь хамрагдаж, 1 ААН нь эмийн бодисын нөөцгүй, санхүүжилтгүй, 1 ААН-ийн ажлын байр нь дахин төлөвлөлтөд орсон гэсэн шалтгаанаар 2 газрын үйл ажиллагаа түр зогссон тул хамрагдаагүй. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 1.16.2, 1.16.3 кодтой 2 хяналтын хуудас ашиглан эрсдэлийг үнэлэхэд бага 9, дунд 21, их 4 үнэлэгдсэн бол гүйцэтгэлийн хяналт шалгалтаар бага 16 буюу бага эрсдэлтэй объектын тоо 56.3 хувиар өсч, дунд 11 буюу дунд эрсдэлтэй объектын тоо 52.4 хувиар буурч, их эрсдэлтэй объектын тоо 100 хувь буурсан.

Шалгалтаар 222 зөрчил илрүүлж, 112 зөрчил буюу 50 хувийг арилгуулж, 14 аж ахуйн нэгжид 62 заалттай улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, улсын бүртгэлд бүртгүүлээгүй, шинжилгээ баталгаажилтгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эм, биобэлдмэл худалдан борлуулсан 4 аж ахуйн нэгжийн нийт 14 450 000 төгрөгийн үнэ бүхий 8 нэр 2846 ширхэг малын эм, биобэлдмэлийг улсын байцаагчийн 4 актаар хураан авч, шийдвэрлүүлэхээр албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохиролд нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Нийслэлийн Зөвлөлийн комисст шилжүүлсэн.

Зөрчил гаргасан нийт 16 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 12 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 15 даалгавар хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар дүнг хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэрийг МХЕГ-аар дамжуулан Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 3, МХЕГ-ын ХАБХААХГ-т 5 саналыг 2019.05.20-ны өдрийн 02-02/2067 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.

5. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын чиглэлээр:

НМХГ-ын даргын 02-02/102 “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгчдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай”

удирдамжийн дагуу 88 объектын 84 буюу 94.3 хувь хамрагдлаа. Хяналт шалгалтад хамрагдсан 84 объектод 1.18, 1.28, 1.41 кодтой 3 хяналтын хуудас ашиглан эрсдэлийн үнэлэхэд 6 их, 43 дунд, 35 бага эрсдэлтэй үнэлэгдэж, хуулийн хэрэгжилт 73.4 хувьтай хэрэгжсэн байна. Төлөвлөгөөт шалгалтаар дотоодын хүнсний ногоог гарал үүслийн гэрчилгээгүй хадгалсан, худалдаалсан, агуулахад температур, чийг хэмжигчийг байрлуулж бүртгэл хөтлөөгүй, ул мөрийн бүртгэлгүй, дотоод хяналтын журмын дагуу ажилладаггүй, агуулахын барилга байгууламж, хана, шал, тааз зориулалтын бус зэрэг 25 гаруй төрлийн давхардсан тоогоор 535 зөрчил илрүүлэн үүний 434 буюу 81.1 хувийг арилгуулан, зөрчил бүхий 35 аж ахуйн нэгж, иргэд 231 заалт бүхий хугацаатай албан хүргүүлэн, 3 зөрчлийн хэрэг үүсгэж, 35 хялбаршуулсан, 3 зөрчлийн хэрэг шийдвэрлэн 38 иргэн, аж ахуйн нэгжид 20300.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 100 хувь барагдуулж, 19 эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар хүргүүлж ажиллалаа. Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад 15 гаруй нэрийн хүнсний ногоо, хөрснөөс 103 дээж авч, ХАБҮЛЛ, НМХГ-ын НТЛ-д ургамлын хортон, хими, хор судлал, нян судлалын аюулгүйн үзүүлэлтээр шинжлүүлэхэд шаардлага хангаж байлаа. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн арвандөрөв дүгээр хурлаар хэлэлцүүлж, шалгалтын дүн, хурлын шийдвэрийн тэмдэглэлийн хамт МХЕГ-ын ХАБХААХГазарт 02-02/4133 тоот албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Даргын зөвлөлийн хурлаас аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэх саналыг шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж иргэдэд хүргэж биелэлтэд хяналт тавихад шийдвэр 68.0 хувийн биелэлттэй байлаа.

2. Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр:
Нийт зарлагдсан 525 объектоос 135 (25.1%) объект үйл ажиллагаа явуулаагүй зогссон байна.

Тайлант хугацаанд тус хэлтсийн улсын /ахлах/ байцаагч нар /дүүргийн байцаагч нар орсон/ нийт 13 төлөвлөгөөт хяналт шалгалтыг байгаль орчны хяналтын чиглэлээр 201, геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр 54, газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр 147 нийт 402 объектод хийснээс 64 (18.8%) объект их эрсдэлтэй, 172(40.8%) объект дунд эрсдэлтэй, 169(50.7%) объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн хувь 69.4%, эрсдэл үүсэх магадлал 33%-тай байна.

Байгаль, орчны хяналтын чиглэлээр:
2.1.Мах боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:
Газрын харилцаа, байгаль орчны чиглэлээр нийт 23 аж ахуйн нэгж, байгууллага зарлагдсанаас 7 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй, 16 /69.7%/ аж ахуйн нэгжээс 5 /31%/ бага, 9 /56%/ дунд, 2 /13%/ их эрсдэлтэй үнэлэгдсэн, мөн газрын харилцааны хяналтын чиглэлээр 3 аж ахуйн нэгж хамрагдаж 100% бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Мөн 13 аж ахуйн нэгжид 8830.0 мян төгрөгийн торгууль оногдуулж, зөрчлийн үр дагаврын арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, 7 албан шаардлага хүргүүлж ажилласан бөгөөд үүрэг даалгаврын биелэлт 75%-тай хангагдсан байна.

Шалгалтын дүнг нэгтгэж, ХАБХААХХ-т хүргүүлж, шалгалтын дүнг тус газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар хурлын 02 дугаар асуудлаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулж, МХЕГ-т 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

2.2. Арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:

Нийт байгаль орчны чиглэлээр 16 иргэн, аж ахуйн нэгж зарлагдсанаас 2 үйл ажиллагаа явуулаагүй, 14 /87.5%/ хамрагдаж бүгд /100%/ дунд, эрсдэлийн 69.6%, хууль сахин мөрдөлт 38.5%-тай байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 2 аж ахуйн нэгж дундаас бага руу шилжиж хууль сахин мөрдөлт 40.5% болж нэмэгдсэн. Газрын харилцааны чиглэлээр 8 иргэн, аж ахуйн нэгж зарлагдсанаас /100%/ хамрагдаж 6 /75%/ бага, 2 /25%/ дунд үнэлэгдэн, эрсдэл 37.7%, хууль сахин мөрдөлт 62.3%-тай байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 1 аж ахуйн нэгж дундаас бага эрсдэл рүү шилжиж хууль сахин мөрдөлт 64.3% болж нэмэгдсэн болно.

Улсын ахлах байцаагчийн 02-01-001/10 дугаартай зөвлөмж 16, 02-03/1399 тоот мэдэгдэл 14, 2 албан шаардлага, 13 иргэн, аж ахуйн нэгжид 8900.0 мянган төгрөгийн торгууль, Зөрчлийн үр дагавар арилгах эрх бүхий албан тушаалтны 13 албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Шалгалтын дүнг Газрын даргын дэргэдэх 4 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба танилцуулгыг МХЕГ, хурлын шийдвэр болон холбогдох арга хэмжээг авахуулахаар БОАЖЯ, Нийслэлийн Засаг даргад албан бичгийг тус тус хүргүүлсэн.

2.3. Ноос ноолуур, өлөн боловсруулах үйлдвэрүүд болон бохир ус цэвэрлэх байгууламжид хийсэн хяналт шалгалт:

Нийт 13 объект хамрагдахаас 100% хамрагдсан ба байгаль орчны хяналтын чиглэлээр 9 /100%/ эрсдэлийг үнэлэхэд 8 /88.8%/ дунд, 1 /11.2% / бага үнэлэгдэн, эрсдэл 31%, хууль сахин мөрдөлт 70.8% байна.

Газрын харилцааны чиглэлээр 4 /100%/ объект хамрагдаж, эрсдэлийг үнэлэхэд 3 /75%/ бага, 1 /25%/ дунд үнэлэгдсэн ба эрсдэл 30.9%, хууль сахин мөрдөлт 76.8% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 5 /38.5%/ бага, 8 /61.5%/ дунд эрсдэлтэй үнэлэгдэн 1 нь дундаас бага руу шилжсэн, мөн 8 нь дунд эрсдэлтэй байгаа боловч эрсдэл 29.9%, хууль сахин мөрдөлт 72.3% болж эрсдэлийн хувь 1.1% -иар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 1.5 пунктээр өссөн байна.

Улсын ахлах байцаагчийн 02-01-001/10 дугаартай зөвлөмж 15, улсын байцаагчийн 3 албан шаардлага, 9 аж ахуйн нэгжид 4150.0 мянган төгрөгийн торгууль, 9 даалгаврыг хүргүүлэн ажилласан. Шалгалтын дүнг Газрын даргын дэргэдэх 11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба танилцуулгыг МХЕГ, хурлын шийдвэр болон холбогдох арга хэмжээг авахуулахаар БОАЖЯ, Багануур дүүргийн Засаг даргын тамгын газарт албан бичгийг тус тус хүргүүлсэн.

2.4. Усны үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:

Нийт 23 аж ахуйн нэгж зарлагдсанаас 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй, 18 /78.2%/ аж ахуйн нэгжийг байгаль орчны чиглэлээр шалгахад 6 /33.4%/ бага, 8 /44.4%/, дунд, 4 /22.2%/ их эрсдэлтэй, газрын харилцааны хяналтын чиглэлээр 16 аж ахуйн нэгж зарлагдсан ба хамрагдсан 11 /68.8%/ бүгд /100%/ бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 /66.6%/ хувийг хамруулан хяналт шалгалт явуулахад их эрсдэлтэй ангилалаас дунд эрсдэлтэй ангилалд 4 /33.3%/, дунд эрсдэлтэй ангилалаас 3 /25%/ нь бага эрсдэлтэй үнэлэгдэж нийт шалгалтанд хамрагдсан 18 объектын 7 /58.3%/ эрсдэл нь буурч эрсдлийн үнэлгээ 36%, хууль тогтоомжийн хэрэгжилт 63.6% болж 5 пунктээр нэмэгдүүлээ.

Мөн 11 албан даалгавар, 4 албан шаардлага, 12 аж ахуйн нэгж, байгууллагад 6800.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан.

Мөн шалгалтын хүрээнд Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-аас стандартын зөвшөөгдөх дээд агууламжаас давсан бохирдолтой усыг төвлөрсөн системд нийлүүлсэн аж ахуйн нэгжүүдийг 3/1588 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд нэр бүхий 4 аж ахуйн нэгжид Нийслэлийн Прокурорын газарт Зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэрлэсэн байна.

Шалгалтын явцын дүн мэдээ нэгтгэгдэн НМХГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн 2019.08.29-ны өдрийн 11 дүгээр хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэрийг НЗДТГ, Улаанбаатар хотын УСУГазарт албан бичгээр хүргүүлсэн.

2.5. Аюултай хог хаягдал, 2-догч түүхий эд дахин боловсруулах үйлдвэрүүд хийсэн хяналт шалгалт:

Нийт байгаль орчны чиглэлээр 14 аж ахуйн нэгж зарлагдсанаас 4 үйл ажиллагаа явуулаагүй, 10 /71.4%/ хамрагдаж 2 /20%/ бага, 4 /40%/ дунд, 4 /40 %/ их үнэлэгдэн, эрсдэл 44.2%, хууль сахин мөрдөлт 57.1%-тай байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 1 аж ахуйн нэгж ихээс дунд эрсдэл рүү шилжин хууль сахин мөрдөлт 58.1% болж өссөн.

Газрын харилцааны чиглэлээр 4 аж ахуйн нэгжийг хяналтын хуудсаар үнэлэхэд 2 буюу 50% нь бага, 2 буюу 50% нь дунд эрсдэлтэй үнэлэгдэн эрсдэлийн хувь 30.85, хууль сахин мөрдөлт 66.65%-тай байсан бол

гүйцэтгэлийн шалгалтаар 1 аж ахуйн нэгж дундаас бага эрсдэл рүү шилжин хууль сахин мөрдөлтийн хувь 67.65% болж өссөн байна. Улсын ахлах байцаагчийн 02-01/327 дугаартай мэдэгдэл 10, мөн 8 заалт бүхий улсын байцаагчийн 3 албан шаардлага, 7 аж ахуйн нэгжид 11000.0 мянган төгрөгийн торгууль, албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

Шалгалтын дүнг Газрын даргын дэргэдэх 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба танилцуулгыг МХЕГ, хурлын шийдвэр болон холбогдох арга хэмжээг авахуулахаар БОАЖЯ, Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт албан бичгийг тус тус хүргүүлсэн..

2.6. Байгалийн ургамал ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

Нийт байгаль орчны чиглэлээр 11 аж ахуйн нэгж зарлагдаж 7 /65%/ хамрагдаж, 4 /57.1%/ бага, 3 /42.9%/ дунд, хууль сахин мөрдөлт 82.0%, эрсдэл үүсэх магадлал 19.0%-тай, 4 нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Газрын харилцааны чиглэлээр 5 нэгжээс 4 /80%/-д шалгалт хийхэд бүгд /100%/ бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба 2 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Шалгалтаар 4 ААН-д 4500.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, даалгавар хүргүүлж ажилласан.

Гүйцэтгэлийн шалгалтаар 2 нь дунд эрсдэлтэйгээс бага эрсдэлтэй болж эрсдэл буурсан, 2 нь бага эрсдэл дотроо эрсдлийн хувь буурсан байна. Шалгалтын дүнг тус газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 09 дүгээр хурлын 01 дүгээр асуудлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулан, МХЕГ, БОАЖЯ-нд тус тус санал хүргүүлж ажилласан.

2.7. Амралт, аялал жуулчлалын газруудад хийсэн хяналт шалгалт:

Нийт 74 аж ахуйн нэгж, байгууллагын 74 объект хамрагдахаас 70 нь буюу 94.6% хамрагдсан байна. Газрын харилцааны чиглэлээр 37 аж ахуйн нэгж, байгууллага /объект/ хамрагдахаас 35 /94.6%/ хамрагдсан ба 12 /34.3%/ бага, 22 /62.9%/ дунд, 1 /2.8/ их үнэлэгдэн, эрсдэл 27.8%, хууль сахин мөрдөлтийн 77.5% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 15 /42.9%/ бага, 19 /54,3%/ дунд, 1 /2.8%/ их үнэлэгдсэн ба 4 нь дундаас бага руу шилжсэн, мөн 10 нь дунд эрсдэлтэй байгаа боловч эрсдэл 25.6%, хууль сахин мөрдөлтийн хувь 80.2% болж эрсдэлийн хувь 2.2% -иар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 2.7%-иар өссөн байна.

Байгаль орчны чиглэлээр /44 объект/ хамрагдахаас 42 /95.5%/, хамрагдаж 8 /19.1%/ бага, 28 /66.7%/ дунд, 6/17.6/ их үнэлэгдэн, эрсдэл 42.6%, хууль сахин мөрдөлт 59.3% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 11 /26.2%/

бага, 30 /71.4%/ дунд, 1 /2.4%/ их үнэлэгдсэн ба 3 нь дундаас бага руу, 5 нь ихээс дунд руу шилжсэн, мөн 15 нь дунд эрсдэлтэй байгаа боловч эрсдэлийн хувь буурсан байна.

Мөн эрсдэл 32.9%, хууль сахин мөрдөлт 64.8% болж эрсдэлийн хувь 9.7% -иар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 9.1%-иар өссөн.

Ариун цэврийн байгууламжтай боловч ариун цэврийн шаардлага /стандарт/ хангаагүй 5 нүхэн жорлонг буулган халдваргүйжилт хийлэн дарж, нөхөн сэргээлтийг хийлгэн, стандартын шаардлага хангасан ариун цэврийн бие засах газар 7 объектод, 1 цэвэрлэх байгууламж шинээр хийлгэсэн.

Шалгалтаар нийт 37 аж ахуйн нэгж, байгууллагад хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж 48800.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан бөгөөд зөрчлийн үр дагаварыг арилгах талаар эрх бүхий албан тушаалтны 37 даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж, 106 заалт бүхий 22 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан ба биелэлт 91.1%-тай байна.

Мөн 130 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж, мөн агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч /нам даралтын зуух/ 11 объектод цахилгаан халаагуурт шилжүүлэх талаар 02-01/3881 тоот албан бичгийг хүргүүлээ.

Шалгалтын дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, БЗД, ХУД, Налайх дүүргийн Засаг дарга нарт, БОАЖЯ, НБОГ, БУДЦГХЗ, ГТБЦГХЗ-нд албан бичгээр санал, танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн болно.

2.8 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй томоохон зах худалдааны төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

Нийт 17 объект хамрагдахаас 100% хамрагдсан ба эрсдэлийг үнэлэхэд 11 /65%/ бага, 6 /35%/ дунд үнэлэгдэн эрсдэл 27.9%, хууль сахин мөрдөлт 78.7% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 2 аж ахуйн нэгжийн үнэлгээ нь дундаас бага руу шилжсэн, мөн 9 нь дунд эрсдэлтэй байгаа боловч эрсдэл 26.7%, хууль сахин мөрдөлт 83% болж эрсдэлийн хувь 1.2% -иар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 4.3 пунктээр өссөн байна.

Шалгалтаар нийт 31 зөрчлүүд илрүүлж, 10 хуулийн этгээдэд ажиллагаа явуулж 15400.0 мян төгрөгийн торгууль оногдуулан, зөрчлийг арилгах талаар 10 даалгавар өгч ажилласан болно.

Хяналт шалгалтын танилцуулгыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

- **Геологи, уул, уурхайн хяналтын чиглээр:**

2.9. Нүүрсний тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

Геологи, уул уурхайн чиглэлээр 8 нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 7 /88%/-д шалгалт хийхэд 3 /43%/ бага, 4 /57%/ их эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль сахин мөрдөлт 54%, эрсдэл үүсэх магадлал 47%, 1 үйл ажиллагаа зогссон байна.

Нийт газрын харилцааны чиглэлээр 5 нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 4 /80%/-д шалгалт хийхэд 4 /100%/ бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль сахин мөрдөлт 93%, эрсдэл үүсэх магадлал 5 %, 1 үйл ажиллагаа зогссон байна.

Зөрчилд нийт 35000.0 мян төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, 5 албан шаардлага, тусгай зөвшөөрлийг цуцлах тухай дүгнэлт 21, үйл ажиллагааг зогсоосон 35, зөрчлийн үр дагварыг арилгуулах эрх бүхий албан тушаалтны 3 даалгавар өгч ажилласан.

Шалгалтын нэгдсэн дүн танилцуулгыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан шийдвэрийн дагуу холбогдох байгууллагуудад хурлын шийдвэрийг хүргүүлж ажиллалаа.

Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрээр АМГТГ-т албан бичгээр хүргүүлсэн саналын дагуу тус газрын кадастрын хэлтсийн даргын 2019.05.15-ны өдрийн 249 тоот шийдвэрээр цуцлах дүгнэлт гаргасан 21 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 10–ийг цуцлуулж шийдвэрлэлээ.

2.10. Химийн хорт болон аюултай бодис ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

Нийт 26 аж ахуйн нэгж хамрагдахаас /100%/ хамрагдаж 5 /19%/ их, 12 /46%/ дунд, 9 /30%/ бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба их эрсдэлтэй үнэлэгдсэн 5 аж ахуйн нэгжид зөрчлийн үр дагварыг арилгах албан даалгавар болон улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж ажилласнаар их эрсдэлтэй объектын тоо 15,9% буурч дунд эрсдэлтэй объектын тоонд шилжин эрсдэл үүсэх магадлал 33%-13,8% болон буурч, хууль сахин мөрдөлтийн хэмжээ 65.6%-83.4%-д хүрсэн байна.

Шалгалтаар 2 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан байхад үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байсан зөрчилд 6000.0 мян төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулсан ба 2 даалгавар, 8 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.

Хяналт шалгалтыг дүнг НМХГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гарсан шийдвэрийн саналыг БОАЖЯ, ЦЕГ, МХЕГ-т тус тус албан бичгээр хүргүүлсэн болно.

2.11. Элс, шаврын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт:

Нийт 35 аж ахуйн нэгж зарлагдсан ба 9 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй, 2 аж ахуйн нэгж шүүх дээр хэлэлцэгдэж байгаа, 1 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл шүүхээр цуцлагдсан байна.

	<p>Шалгалтад 23 аж ахуйн нэгж хамрагдаж 11 /47.8%/ их, 6 /26.1%/ дунд, 6 /26.1%/ бага эрсдэлтэй үнэлэгдэж хууль сахин мөрдөлт 55%, эрсдэл үүсэх магадлал 45%, газрын харилцааны чиглэлээр зарлагдсан 20 аж ахуйн нэгжээс 17/85.0%/ хамрагдаж 16 /94.1%/ бага, 1 /5.9%/ дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бөгөөд хууль сахин мөрдөлт 84%, эрсдэл үүсэх магадлал 19% байна.</p> <p>Шалгалтаар газрын харилцааны чиглэлээр 26 аж ахуйн нэгжид 20300.0 мянган төгрөгийн торгууль, албан даалгавар 23, албан шаардлага 7, зөвлөмж, мэдэгдэл 69 хүргүүлсэн.</p> <p>Шалгалтын нэгдсэн дүн танилцуулгыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 15 дугаар хурлаар хэлэлцүүлэн хурлын шийдвэрийн дагуу 2019.10.18-ны өдрийн 02-03/4333 дугаартай албан тоотыг НЗДТГ болон 4 дүүргийн ЗДТГ-т, 2019.10.18-ны өдрийн 02-03/4329 дугаартай албан тоотыг АМГТГ-т, 2019.10.18-ны өдрийн 02-03/4332 дугаартай албан тоотыг НГЗБА болон 4 дүүргийн ГЗА-нд, 02-03/4331 дугаартай албан тоотыг НБОГ-т, х02-03/4330 дугаартай албан тоотыг Үндэсний авто тээврийн төвд, МХЕГ-т шалгалтын танилцуулга болон хурлын шийдвэрийг 2019.11.15-ны өдрийн 02-03/4327 дугаартай албан тоотой хүргүүлсэн болно.</p> <p>2.12. Хайрга, дайрга ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт:</p> <p>Нийт 42 аж ахуйн нэгж хамрагдахаас 18 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй, 14 эвлэрлийн гэрээтэй нийт 24 /57,14%/ хамрагдсан ба 10 /41,7%/ их, 8 /33,3%/ дунд, 6 /25 %/ бага эрсдэлтэй үнэлэгдсэн, хууль сахин мөрдөлт 61.2%, эрсдэл үүсэх магадлал 39,2% байна.</p> <p>Газрын харилцааны чиглэлээр зарлагдсан 42 аж ахуйн нэгжээс 12 нь цуцлагдсан, 10 үйл ажиллагаагүй, 20 /47,6%/ хамрагдсанаас 18 /90%/ бага, 2 /10%/ дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль сахин мөрдөлт 87%, эрсдэл үүсэх магадлал 15% байна.</p> <p>Шалгалтаар 27 ААН-д 17500,0 мян төгрөгийн торгууль ногдуулан, 27 зөрчлийн үр дагавар арилгах албан даалгавар хүргүүлж, 1 албан шаардлага хүргүүлсэн. Мөн эвлэрэлийн гэрээтэй 4 аж ахуйн нэгж гэрээнд заасан үүргээ биелүүлэлгүй олборлолтын үйл ажиллагаа явуулсан тул эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.</p> <p>Шалгалтын нэгдсэн дүн танилцуулгыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэрийг холбогдох байгууллагуудад албан тоотой хүргүүлж, МХЕГ-т 2019.11.15-ны өдрийн 02-03/4771 дугаартай албан тоотой шалгалтын дүн танилцуулгыг хүргүүллээ.</p> <p>2.13. Барилгын материалын үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:</p>	
--	---	--

Нийт 83 объект зарлагдсанаас 59 аж ахуйн нэгж буюу 71.0%-ийг хамруулсан ба байгаль орчны хяналтын чиглэлээр эрсдэлийг үнэлэхэд 20 /40.0%/ бага, 19 /38.0%/ дунд, 20 /40.0%/ их үнэлэгдэн, эрсдэл 66.1%, хууль сахин мөрдөлт 33.9% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 25 /42.3%/ бага, 24 /40.6%/ дунд, 10 /16.9%/ их үнэлэгдсэн ба 5 нь дундаас бага руу, 10 нь ихээс дунд эрсдэлтэй болж эрсдэл 47.7% буурч хууль сахин мөрдөлт 53.3 % байна.

Газрын харилцааны чиглэлээр эрсдэлийг үнэлэхэд 20 /57.1%/ бага, 10 /28.5%/ дунд, 5 /14.2%/ их үнэлэгдэн эрсдэл 42.8%, хууль сахин мөрдөлт 57.2% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар 25 /71.4%/ бага, 7 /20.0%/ дунд, 2 /5.7%/ их үнэлэгдсэн ба 5 нь дундаас бага руу шилжсэн, мөн 7 нь дунд, эрсдэл 21.6%, хууль сахин мөрдөлт 79.4% байна.

Шалгалтын хүрээнд зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 56 албан даалгавар, албан шаардлага 7, холбогдох хуулийн заалтуудыг үндэслэн 62 аж ахуйн нэгж, байгууллагад 56400.0 мян/төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, үйл ажиллагааг зогсоох эрх бүхий албан тушаалтны 4 албан даалгавар, 2 аж ахуйн нэгжид усны нөөцөд учруулсан хохирол 3667.440 мян/төг ногдуулж ажилласан байна.

Шалгалтын нэгдсэн дүнг мэдээг НМХГ-ын даргын дэргэдэх хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж, Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлийн Байгаль орчны газарт албан бичгээр тус тус хүргүүлсэн болно.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын чиглэлээр:

- **Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр:**

3.1. Барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.1.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/103 тоот Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжаар 183 ААНБ-ын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж 796 зөрчил илрүүлж (60.8 %) буюу 484 зөрчлийг арилгуулан, 56албан даалгавар, 242 заалт бүхий 48 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж (94.0 %) 45 албан шаардлагын биелэлтийг хангуулсан. Зөрчил бүхий 62 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 69350.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч (98.5%) буюу 68350.0 мянган төгрөгийн барагдуулсан. ХБИ иргэн ажиллуулаагүй төлбөрт 5 ААНБ-д 11775.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож бүрэн барагдуулсан. 4.1.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар үнэлэхэд "Их"-5, " Дунд" -91, "Бага" -87, 4.6 "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар "Их" -2, "Дунд" -48, "Бага" -133 үнэлэгдсэн байна.ШХЦС-д 183 ААНБ-ыг бүртгэсэн.

3.2.Барилгын материал үйлдвэрлэлийн үйлчилгээг эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.2.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/223 тоот Барилгын материалын үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх удирдамжаар 64 ААНБ-д шалгалт хийсэн. Шалгалтаар 185 зөрчил илрүүлж (72.4%) буюу 134 зөрчлийг арилгуулан, зөрчил арилгуулахаар 105 заалт бүхий 20 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 13 албан даалгаврыг хүргүүлсэн. Албан шаардлага (95.0%) буюу 19 албан шаардлага, албан даалгавар (100.0%) гүйцэтгэлтэй байна. Зөрчил бүхий 17 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 21000.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан. 4.1.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдэлийн үнэлэхэд "Их" -5, " Дунд" -20, "Бага" -20, 4.6 "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар "Дунд" -12, "Бага"-33,4.1.1"Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас"-аар "Их" -1, Дунд" -3, "Бага"-1, үнэлэгдсэн байна. ШХЦС-д 64 ААНБ-ыг бүртгэсэн.

3.3. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.3.1. НМХГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 4ААНБ-д хяналт шалгалт хийж 87 зөрчил илрүүлж (14.0 %) буюу 7 зөрчлийг арилгуулан, зөрчил арилгуулахаар 47 заалт бүхий 4 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 1 албан даалгаврыг хүргүүлэн биелэлтийг 100.0% хангуулсан. Зөрчил бүхий 1 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 1000,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулсан. 4.1.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдэлийг үнэлэхэд "Их" -1, "Дунд" -2,"Бага"-1, 4.6 "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар "Дунд"-2 "Бага"-2 үнэлэгдсэн. ШХЦС-д 4 ААНБ-ыг бүртгэсэн.

3.4. Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй 40 аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.4.1. "Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд" төвөлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд 337 ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 416 (68.0 %) буюу 286 зөрчлийг арилгуулан, 111 заалт бүхий 16 улсын/ахлах/ байцаагчийн албан шаардлага, 8 албан даалгавар хүргүүлсэн. 11 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 6900,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулсан. "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдэлийг үнэлэхэд дунд эрсдэлтэй 1, бага эрсдэлтэй 17, "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар их эрсдэлтэй 19, дунд эрсдэлтэй 37, бага эрсдэлтэй 37 үнэлэгдсэн.

3.5. Дотоодын Цэргийн 2 ангид хийсэн хяналт шалгалт:

3.5.1. МХЕГ-ын даргын баталсан 01/104 тоот удирдамжийн дагуу Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги салбарын үйл ажиллагаанд тусгай хяналтын чиглэлээр хамтарсан шалгалт хийж гүйцэтгэн 8 зөрчил илрүүлэн шалгалтын хугацаанд

арилгуулсан. “Зэвсэгт хүчний анги салбаруудын бэлэн байдлыг шалгах хяналт”-ын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд бага эрсдэлтэй 2 үнэлэгдсэн байна.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:

3.6. Хүнсний үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

3.6.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/101 тоот удирдамжтай шалгалтыг 74ААНБ-д хийж, 310 зөрчил илрүүлж (43.0 %) буюу 135 зөрчлийг арилгуулан, 131 заалт бүхий 31 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 15албан даалгаврыг хүргүүлсэн. Албан шаардлага (97.0 %), албан даалгавар (100.0%) гүйцэтгэлтэй. Зөрчил бүхий 23 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 19400.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авчбүрэн барагдуулсан. ХБИ иргэн ажиллуулаагүй төлбөрт 1 ААНБ-д 1120.0 мянган төгрөг, НДШ дутуу тооцсонд 778.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож барагдуулсан. 4.1.2 “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд “Их” -3, “Дунд” -11, “Бага” -17, 4.6 “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”-аар “Дунд” -11, “Бага” -20, 4.2 “Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар “Дунд” -7, “Бага” -36 үнэлэгдсэн.. ШХЦС-д 73 ААНБ бүртгэсэн.

3.7.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.7.1. “НМХГ-ын даргын баталсан 02-01/68 тоот Хоол үйлдвэрлэл, үйлчилээний газруудад хяналт шалгалт хийх удирдамжаар 81 ААНБ-ын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж 265 зөрчил илрүүлж (64. 0%) буюу 171 зөрчлийг арилгуулан, 107 заалт бүхий 35 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага 14 албан даалгавар хүргүүлэн, НДТХ-ийн холбогдох заалтын дагуу 4 ААНБ-д 155604.0 мянган төгрөгийг НД-ийн санд нөхөн төлүүлэх акт тогтоож,Зөрчил бүхий 23 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 23022.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч тус тус 100.0% барагдуулсан. 4.1.2 “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд,”Дунд”-1, 4.6 “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”-аар “Дунд” -1,4.2 “Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд “Дунд”-6, “Бага”-72 үнэлэгдсэн. ШХЦС-д 81 ААНБ бүртгэсэн.

3.8. Худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагад хийсэн хяналт шалгалт:

3.8.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/74 тоот удирдамжаар54 ААНБ-д хамтарсан шалгалт хийж 205 зөрчил илрүүлж (55.0%) буюу 113 зөрчлийг арилгуулан, 98 заалт бүхий 17 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж (96.0%) биелэлттэй, 8 албан даалгавар

хүргүүлж(100.0%) хангуулсан. ХБИ ажиллуулаагүй нөхөн төлбөрт 1 ААНБ- 1440.0 мянган төгрөгийн акт тогтоож 100.0% барагдуулсан, Зөрчил бүхий 14 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 10700.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан. 4.1.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдэлийг үнэлэхэд "Их" -1,"Дунд" -25, "Бага" -24, 4.6 "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар "Их"-1, "Дунд" -17, "Бага"-30, 4.2 "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар "Бага"-5 үнэлэгдсэн.

3.9. Малын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

3.9.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/79 тоот удирдамжаар 151 ААНБ-ын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж 918 зөрчил илрүүлж (52.5 %) буюу 482 зөрчлийг арилгуулан, 364 заалт бүхий 69 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 34 албан даалгавар хүргүүлж, Зөрчил бүхий 1 ААНБ-д ХБИ иргэн ажиллуулаагүй төлбөрт 3328.0 мянган төгрөгийн, НД-ийн шимтгэлийг дутуу тооцсон 1ААНБ-д 572.9 мянган төгрөгийн нийт 3900.9 мянган төгрөгийг 100% барагдуулсан. Зөрчил бүхий 42 ААНБ-д 43200,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч (97.4.0%) буюу 42100.0 мянган төгрөгийг барагдуулсан. Ажлын байрны хэмжилт шинжилгээний дүгнэлт 14 үйлдсэн. 4.1.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдэлийг үнэлэхэд "Их" -8, "Дунд" -44, "Бага" -29, 4.6 "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар "Их"-3, "Дунд" -35, "Бага"-44, 4.1.1 "Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас"-аар "Их" -3, "Дунд" -18, "Бага"-12, 4.2 "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар "Дунд" -1, "Бага"-39 үнэлэгдсэн.

3.10. Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, сувилалд үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

3.10.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/77 тоот Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжаар 31 ААНБ-ын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж 177 зөрчил илрүүлж (49.0 %) буюу 83 зөрчлийг арилгуулан, 94 заалт бүхий 13 улсын/ахлах/ байцаагчийн албан шаардлага, 5 албан даалгавар хүргүүлсэн. ЭМД, НДТХ-ийн холбогдох заалтын дагуу 8 ААНБ-д 10424.0 мянган төгрөгийн акт,3 ААНБ-д ЗТХ-ийн 10.17.1-д зааснаар 5000,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулсан.4.2 кодтой хяналтын хуудасаар эрсдэлийг үнэлэхэд "Дунд" -2, "Бага" -14, 4.8 кодтой хяналтын хуудасаар "Дунд" -1, "Бага"-11 үнэлэгдсэн.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:

3.11. Хөнгөн үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эрхэлж буй 114 аж ахуйн нэгжид хийсэн хяналт шалгалт:

3.11.1. “НМХГ-ын даргын баталсан 02-01/100 тоот Хөнгөн үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжаар 144 ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 285 зөрчлийг илрүүлж (48.4 %) буюу 138 зөрчлийг арилгуулан, 147 заалт бүхий 26 улсын/ахлах/байцаагчийн албан шаардлага, 18 албан даалгавар хүргүүлсэн. 34 ААНБ-д ЗТХ-ийн дагуу 19550,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч (95,0%) буюу 18550.0 мянган төгрөгийг, ХБИ ажиллуулаагүй нөхөн төлбөрт 1 ААНБ-д 1664.0 мянган төгрөгийн акт тогтоож бүрэн барагдуулсан.Ажлын байрны хэмжилт шинжилгээний дүгнэлт 1 үйлдсэн.

4.1.2 “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд “Их” -1, “ Дунд” -29, “Бага”-39, 4.6 “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”-аар “Дунд”-19, “Бага”-31,4.2 кодтой хяналтын хуудасаар “Дунд”-5, “Бага”-45, 4.1.1 “Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд “Дунд”-13, “Бага”-10 үнэлэгдсэн.

4. Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын чиглэлээр:
Эмчилгээний хяналтын чиглэлээр:
4.1. Эрүүл мэндийн байгууллагуудад хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалт:
4.1.1. “Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 227 эмнэлэгийг хяналт шалгалтад хамрууллаа. Тус шалгалтад төрөлжсөн мэргэшлийн 11, дүүргийн нэгдсэн 4, дүүргүүдийн эрүүл мэндийн төв 9, амаржих 3, хувийн хэвшлийн ор бүхий 59, клиник 83, өрхийн эрүүл мэндийн төв 35, сувилал 17, тосгоны эрүүл мэндийн төв 1, нийслэлийн түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааг 6 төрлийн хяналтын хуудсаар үнэллээ. Үүнд:
Улсын болон хувийн ор бүхий 91 эмнэлгийг хяналтын хуудсаар үнэлэхэд 1 (1.09%) нь их эрсдэлтэй, 36 (39.6%) нь дунд эрсдэлтэй, 54 (59,3%) нь бага эрсдэлтэй,
Оргүй /үүдэн/ 83 эмнэлэгийг хяналтын хуудсаар үнэлэхэд 4 (4.8%) нь их эрсдэлтэй, 39 (47%) нь дунд эрсдэлтэй, 40 (48.2%) нь бага эрсдэлтэй, 17 сувилалыг хяналтын хуудсаар үнэлэхэд 8 (47%) нь дунд эрсдэлтэй, 9 (53%) нь бага эрсдэлтэй, 35 өрхийн эрүүл мэндийн төвийг хяналтын хуудсаар үнэлэхэд 1 (2.9%) нь их эрсдэлтэй, 26 (74,3%) нь дунд эрсдэлтэй, 8 (22.8%) нь бага эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн.
Хяналт шалгалтаар 152 эмнэлэгт 958 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг үндэслэн 51 эмнэлэгт зөрчлийн хуулийн дагуу 41.800.000 төгрөгийн шийтгэвэр, 14 эмнэлгийн албан тушаалтанд 3.500.000, 3 иргэнд 900.000 төгрөгийн шийтгэвэр ноогдуулж, нийт 46.200.000 төгрөгийг барагдуулж ажиллалаа.

4.2. “Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийх тухай” удирдамжийн дагуу 72 эмнэлэгт хяналт шалгалт хийхээс 70 (97%)-ийг хамруулахад 45 (64.5%) нь бага эрсдэлтэй, 19 (27%) нь дунд эрсдэлтэй, 6 (8.5%) нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчын 214 заалттай 18 албан шаардлага хүргүүлэн, Зөрчлийн тухай хуулийн дагуу 8 байгууллага, 3 албан тушаалтанд нийт 5.950.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 5 байгууллагад албан даалгавар хүргүүлэн, 8 нэрийн 23 ширхэг 13010 төгрөгийн эмийг хураан авч орон тооны бус устгалын комисст устгуулахаар шилжүүлсэн.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 4 их эрсдэлтэй, 8 дунд эрсдэлтэй 6, бага эрсдэлтэй байгууллагыг 3.1.2 кодтой хяналтын хуудасны эрсдлийн үнэлэхэд 17 байгууллага бага, 1 байгууллага их эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэл буурсан байна.

Шалгалтад хамрагдсан байгууллагуудад илэрч буй зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудлаар 11 удаагийн сургалтыг 160 гаруй эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан.

4.1.2 “Эмнэлгүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд нийт 72 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 70 эмнэлэг буюу 97%-ийг хяналт шалгалтад хамрууллаа. Шалгалтад хамрагдсан нийт эмнэлгийн 45 /64.5%/ нь “бага” эрсдэлтэй, 19 /27%/ нь “дунд” эрсдэлтэй, 6 /8.5%/ нь “их” эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт 72 хувь, эрсдэл үүсэх магадлалын хувь 27.9 хувьтай байна.

Улсын байцаагчдын хугацаатай хамтарсан 214 заалттай 18 албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Үйлдвэрлэгчийн хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж байсан Тулгат МТМ ХХК-ийн Энэрэхүй, Рефлекс, Анубулган эмнэлэг, АСЭ эмнэлэг, Эмийн хадгалалтын дэглэм зөрчигдсөн, үйлдвэрлэгчийн заасан хэмд хадгалаагүй Болормэлмий, Дунфан найрамдал, Бишрэлт-Од, мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй Авецина, эмийн хаяг шошгонд тавигдах шаардлага зөрчсөн Нууц увидас, эм барих эрхгүй хүнийг эм олгох үйл ажиллагаанд оролцуулсан Чимэжүд, өвчтөнд эмийн зохистой хэрэглээний талаар буруу мэдээлэл өгсөн Алтанхүн эмнэлгүүдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох заалтуудыг үндэслэн /8 байгууллага, 3 албан тушаалтанд/ нийт 5.950.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 5 байгууллагад албан даалгавар хүргүүлсэн бөгөөд 8 нэрийн 23 ширхэг 13010 төгрөгийн эмийг улсын байцаагчийн 7 /3/ актаар хураан, орон тооны бус устгалын комисст устгуулахаар шилжүүлсэн.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд тендерийн гэрээгээр нийлүүлэгдсэн анхдагч болон хоёрдогч савлагаанд үйлдвэрлэгчийн нэр тодорхойгүй, дагалдах анализ сертификат болон савлагаан дээрх үйлдвэрлэгчийн нэр зөрүүтэй, чанарын баталгаажуулалтгүй үзлэгийн бээлийг нийлүүлсэн Чоногол трейд ХХК-д хяналт шалгалт хийн, Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 4.1 дэх заалтаар торгуулийн арга хэмжээ авч, 2.195.740 төгрөгийн хууль бус орлого нөхөн төлүүлсэн.

Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр:

4.2. Эм хангамжийн байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

4.2.1. “Эм хангамжийн байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд нийт 105 эм хангамжийн байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 90 эмийн сан, 1 эмийн үйлдвэр, 8 эм ханган нийлүүлэх байгууллага нийт 99 байгууллагыг хяналт шалгалтад хамрууллаа. Эм ханган нийлүүлэх 8 байгууллагыг 3 эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний хадгалалт, түгээлтийг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд 4 (50%) нь дунд эрсдэлтэй, 4(50%) нь бага эрсдэлтэй, эмийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар 90 эмийн санг шалгахад 3 (2.7%) нь их эрсдэлтэй , 28 (31%) нь дунд эрсдэлтэй, 59 (65%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 3 ААН-ийн эмийн сан ажлын байргүй, 2-ААН-ийн эмийн сан хаяг байршил дээрээ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчдын хамтарсан 218 заалт бүхий 45 албан шаардлага хүргүүлж, 4 эм ханган нийлүүлэх байгууллага, 28 эмийн санд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд албан шаардлагын хэрэгжилт эмийн үйлдвэрүүд83-85%, эм ханган нийлүүлэх байгууллагууд 85-100%, эмийн сангууд 85%-иар бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Зөрчил гаргасан нийт 23 аж ахуйн нэгжид 13.100.000 төгрөг, 2 хүнд 100.000 төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, 1.024.000 төгрөгийн нөхөн төлбөр тооцож улсын орлого болгон, бүрэн барагдуулж, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 12 албан даалгаврыг хүргүүлж ажиллалаа.

4.3. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалт:

4.3.1 “Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийх тухай” удирдамжийн хүрээнд130 эмнэлэгт хяналт шалгалт хийхээс 128 (98.4%)-ийг хяналт шалгалтад хамруулахад 4 (3.1%) нь их, 68 (53.1%) нь дунд, 56 (43,7%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, хяналт шалгалтаар 828 зөрчил илрүүлж, 548 (66.1%)-ийу зөрчлийг арилгуулж, 63 эмнэлэгт 523 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж, 30 аж ахуйн нэгж байгууллага, 5 албан тушаалтан, 3 иргэнд нийт

20.450.000 төгрөгийн шийтгэвэр ногдуулж, 30 байгууллагад албан даалгавраар үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажилласан.

Эрүүл зүйн нян судлалын шинжилгээнд 80 эмнэлэг буюу 66%-ийг хамруулан, нийт 730 арчдас, 121 ариун материал, 188 агаарын дээж, ундны усны шинжилгээнд химийн 30, нян судлалын 33, хүнд металлын 10 дээж, 20 эмнэлгийн эмчилгээний хоолны 67 дээж авч лабораторит шинжлүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн улсын /ахлах/ байцаагчийн 94 дүгнэлт үйлдсэн. Шалгалтын дүнг нэгтгэн, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, МХЕГ-т хүргүүлсэн.

4.3.2. “Эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийх тухай” 02-01/112 тоот удирдамжийн хүрээнд 87 байгууллагад хяналт шалгалт хийхээс 82 /94%/-ийг хамруулахад 50 /61%/ нь бага эрсдэлтэй, 29 /35.4%/ нь дунд эрсдэлтэй, 3/3.6%/ нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтаар нийт 61 зөрчлийг илрүүлэн 48 зөрчлийг арилгуулж, 9 байгууллагад 4,050,0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар 38 байгууллагад албан шаардлага, 9 байгууллагад албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажилласан. Шалгалтын дүнг нэгтгэн, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, МХЕГ-т хүргүүлсэн.

Эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийх тухай удирдамжийн хүрээнд 87 байгууллагад хяналт шалгалт хийхээс 82 (94.2%)-ийг хамруулан төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд 50 (60.9%) нь их, 29 (35.3%) нь дунд, 3 (3.6%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, хяналт шалгалтаар 410 зөрчил илрүүлэн 278 зөрчлийг арилгуулж, 8 байгууллага, 1 иргэнд 4.050,0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаа.

4.3.3. “Зочид буудал, дэн буудлуудад төлөвлөгөөт шалгалт хийх” 02-01/217 тоот удирдамжийн хүрээнд 90 зочид буудал, 39 дэн буудал нийт 129 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ.

Шалгалтад хамрагдсан газруудад “Зочид буудлын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар үнэлгээ өгөхөд 8 (6.2%) нь их, 92 (71.3%) нь дунд, 29 (22.5%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтын явцад зочид буудал, дэн буудлын үйлчилгээний угаалга, цэвэрлэгээний үр дүнд үнэлгээ өгөх зорилгоор эрүүл зүйн нян судлалын шинжилгээнд 500 арчдас авч шинжлүүлэхэд 142 буюу 28.5%-д нь гэдэсний бүлгийн *Enterobacter spp*, *E.coli* савханцар илэрсэн. Зочин хүлээн авах ерөөний цагаан хэрэглэл, алчуур, улавч, аяга таваг зэргээс авсан гадаргуугийн арчдасын бохирдол нь дэн буудлаас авсан дээжинд илүү илэрсэн. Дэн буудлаас авсан нийт арчдасын 39.2%-д нь гэдэсний бүлгийн *Enterobacter spp*, *E.coli* савханцар илэрсэн.

Унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд үнэлгээ өгөх зорилгоор 61 зочид буудал, дэн буудлаас усны 122 дээж авч хими, нян судлалын

үзүүлэлтээр шинжилгээ хийлгэхэд 2 дээжинд нянгийн тоо стандартад заасан нормоос их гарсан тул зочид буудлын усны шүүлтүүрийг шинэчлүүлж, ус хадгалах савыг угаалгаж, халдваргүйжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Усны дээжинд шинжилгээ хийсэн талаар улсын байцаагчийн нийт 61 дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Шалгалтын явцад 393 зөрчил илрүүлэн 348 заалт бүхий 73 албан шаардлага, эрх бүхий албан тушаалтны 49 албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, нийт 51 аж ахуйн нэгж, иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 29600.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ ногдуулсан.

Зочид буудлын мини баранд худалдаалж байсан хадгалалтын хугацаа дууссан 8 төрлийн 43 ширхэг 167500 төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн актаар хурааж, Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хурааж авсан хөрөнгө орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн зөвлөлд шилжүүлсэн. Хяналт шалгалтаар 6 зочид буудал, дэн буудлын зөрчлийн мэдээг НМХГ-ын олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, ард иргэдэд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж бүрд шалгалтын явцад Зөрчлийн тухай, Эрүүл ахуйн тухай, Дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам, холбогдох стандартын талаар сурталчилж ажилласан.

4.3.4. “Үсчин, гоо сайхны газруудад шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Нийслэлийн хэмжээнд нийт 40 үсчин, гоо сайхны газарт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 3-р улирлын байдлаар 34 (85%) объектод хяналт шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар “Үсчний газрын эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийг үнэлэхэд 8 (44.4%) нь дунд эрсдэлтэй, 10 (55.5%) нь их эрсдэлтэй, “Гоёлын гоо заслын газрын эрүүл ахуйн шаардлага, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийг үнэлэхэд 11(68.7%) нь дунд эрсдэлтэй, 5 (45.4%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Хяналт шалгалтын явцад шалгалтад хамрагдсан үсчин, гоо сайхны газруудын ажлын байрны гэрэлтүүлэг, чийглэг, агаарын хөдөлгөөн, дуу шуугианд физик хэмжилт хийж, барилгын шугамын ундны уснаас 24 дээж, үсчин, гоо сайхны газруудын эд материал, тоног төхөөрөмжөөс нийт 222 эрүүл зүйн арчдас, гоо сайхны газрын массажны өрөөнөөс нийт 21 агаарын шинжилгээ авч шинжлүүлэн, дүнг үндэслэн 27 газарт улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт гарган ажиллаа.

Хяналт шалгалтын явцад нийт 747 зөрчил илрүүлж 39.7%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчлийг арилгуулах талаар 40 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан, зөрчил гаргасан 22 газарт зөрчлийн

хэрэг үүсгэн, нийт 2250.0 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ноогдуулж, барагдуулж ажилласан байна. Мөн улсын байцаагчийн дүгнэлт 80-ыг үйлдэж, хяналт шалгалт хийсэн объект бүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

4.4. Хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалт:

4.4.1. “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 247 төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 242 (97.9%) байгууллагад хяналт шалгалт хийж, “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-ны дагуу үнэлгээ хийхэд 61 (25.2%) нь их эрсдэлтэй, 158 (65.3%) нь дунд эрсдэлтэй, 23 (9.5%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэлээ.

Шалгалтаар нийт 1743 зөрчил илрүүлж 1331 (76.4%) -ийг газар дээр нь арилгуулж, 38 аж ахуйн нэгж, иргэнд улсын /ахлах/ байцаагчийн 291 заалт бүхий албан шаардлага, 183 заалттай 69 албан даалгавар хүргүүлж зөрчлийн үр дагаврыг арилгуулж ажиллалаа.

Хяналт шалгалтын явцад хоолны 12, ундны усны 60 дээж авч, хоол үйлдвэрлэлийн газрын угаалга цэвэрлэгээний үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор эрүүл зүй, нян судлалын шинжилгээнд 379 цэгээс арчдас шинжилгээ авч, НМХГ-ын итгэмжлэгдсэн төв лабораторийн шинжилгээнд хамруулахад арчдас шинжилгээний 125 (32,9%) нь E.coli, enterbacter spp илэрсэн байна. Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн хялбаршуулсан журмаар 74, зөрчлийн хэрэг 3, нийт 77 аж ахуй нэгж, иргэд 37 сая 100 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдууллаа.

Шалгалтад хамрагдсан 241 байгууллага, иргэний 801 ажилтанг байгууллагын сургалтанд хамруулан зөвлөмж, материал хүргүүлж ажиллалаа. Шалгалтын танилцуулгыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн хамт МХЕГ-т хүргүүлсэн.

4.4.2 “Худалдаа, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд хүнсний худалдааны 232 газарт хяналт шалгалт хийхээс 226 (97.4%) газрыг хяналт шалгалтад хамрууллаа. Шалгалтаар 6 аж ахуй, нэгж үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн шалтгаанаар хяналт шалгалтад хамрагдаагүй. “Худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар шалгаж, эрсдэлийг үнэлэхэд 6 (2.6%) нь их эрсдэлтэй, 145 (64,1%) нь дунд эрсдэлтэй, 75 (33,1%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар их эрсдэлтэй газар байхгүй, дунд эрсдэлтэй 123, бага эрсдэлтэй 103 болж эрсдэлийн дундаж 11.8 хувиар буурсан.

Шалгалтын явцад нийт 1056 зөрчил илрүүлж, 787 буюу 74.5%-ийг арилгуулж, хяналт шалгалтын явцад хялбаршуулсан журмаар 59, зөрчлийн 5 хэрэг нээж, зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 677 заалт бүхий 66 албан шаардлага, 37 албан даалгавар өгч, үр дүнг тооцоход хэрэгжилт 63.2%-тай байна. Шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй холбогдуулан 64 хуулийн этгээдэд, хувь хүнд 52.550.0 төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, 48.900.0 мянган төгрөг төлөгдсөн барагдуулалт 93.1%-тай байна. Чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, муудсан, хадгалалтын хугацаа дууссан 63 нэр төрлийн 2418 ширхэг, 17кг, 3.960.650 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураах актаар, зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан 29 нэрийн 157 ширхэг, 355.890 төгрөгийн тамхийг улсын орлого болгуулахаар улсын байцаагчийн акт тогтоон, 14 нэр төрлийн, 8200 төгрөгийн хүнсийг сүлжээнээс татан авалт хийлгүүлсэн. Шалгагдсан хүнсний худалдааны газруудад илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдлийг бууруулах зорилгоор нийт 10 удаа, 234 худалдааны газрын 692 ажиллагсдыг хамруулсан байгууллагын сургалтыг зохион байгуулж, “мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажиллалаа. Шалгалтын танилцуулгыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүн мэдээг МХЕГ-т хүргүүлсэн.

4.4.3. “Худалдаа, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 240 газарт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 3-р улирлын байдлаар 234 (97.5%) газрыг хяналт шалгалтад хамрууллаа. Хяналт шалгалтыг худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудсаар шалгаж, эрсдэлийг үнэлэхэд 30(12.8%) нь их эрсдэлтэй, 150 (64.1%) нь дунд эрдэлтэй, 54 (23.1%) нь бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Шалгалтын явцад нийт 1403 зөрчил илрүүлж, 887 буюу 63.2%-ийг арилгуулж, хяналт шалгалтын явцад хялбаршуулсан журмаар 59, зөрчлийн 5 хэрэг нээж, зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 677 заалт бүхий 66 албан шаардлага, 37 албан даалгавар өгч, үр дүнг тооцоход хэрэгжилт 63.2%-тай байна. Шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй холбогдуулан 64 хуулийн этгээдэд, хувь хүнд 52.550.0 төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, 48.900.0 мянган төгрөгийг барагдууллаа. Чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, муудсан, хадгалалтын хугацаа дууссан 63 нэр төрлийн 2418 ширхэг, 17кг, 3.960.650 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураах актаар, зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан 29 нэрийн 157 ширхэг, 355.890 төгрөгийн тамхийг улсын орлого болгуулахаар улсын байцаагчийн акт тогтоон, Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах” нийслэлийн зөвлөлд шилжүүлсэн.

Шалгагдсан хүнсний худалдааны газруудад илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдлийг бууруулах зорилгоор нийт 10 удаа, 234 худалдааны газрын 692 ажиллагсдыг хамруулсан байгууллагын сургалтыг зохион байгуулж, “мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгсөн байна.

4.4.3 “Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 36 үйлдвэрээс 2019 оны төлөвлөгөөт шалгалтад хамруулахаар олон нийтэд зарласнаас 33 үйлдвэр буюу 91.6%-ийг нь хамруулан хяналт, шалгалт хийлээ. Үүнээс 17 нь гурилан бүтээгдэхүүн, 12 нь кремт, кремт бүтээгдэхүүн, архины 3 үйлдвэр байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын чиглэлээр 4 хяналтын хуудасны асуумжийн хүрээнд шалгаж, эрсдэлийн түвшинг тогтооход төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 33 үйлдвэрийн 9 (27.2%) хувь нь их эрсдэлтэй, 19 (57.5%) нь дунд эрсдэлтэй, 5 (15.15%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, гүйцэтгэлийн хяналтаар их эрсдэлтэй 2, дунд эрсдэлтэй 19, бага эрсдэлтэй 11 болж эрсдэлийн дундаж 25.23%-иар буурсан. Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор зөрчил, дутагдал гаргасан аж ахуйн нэгж, иргэнд 82 заалт бүхий 7 албан шаардлага, эрх бүхий албан тушаалтаны 13 албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, объектын 90.9%-д нь буюу нийт 30 үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт хийхэд биелэлт 69-73.3-тай, 6 үйлдвэр их эрсдэлтэйгээс дунд руу, 6 үйлдвэр дунд эрсдэлтэйгээс бага руу шилжин, эрсдэл үүсэх магадлалын хувь дундажаар 12.1%-иар буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт 10.3%-иар дээшилсэн дүнтэй байна.

Гүний худаг, технологийн усны 17 дээжийг лабораторид шинжилгээнд хамруулахад дээжийн 16 (94.1%) нь шинжлэгдсэн үзүүлэлтүүдийн хувьд “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS 0900:2005 стандартын шаардлагыг хангаж байна. Үйлдвэрлэлийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үр дүнд үнэлгээ өгөх зорилгоор 15 үйлдвэр цехийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, тээвэрлэлтийн сав, вандан тавиур болон ажилчдын гар, хормогч зэргээс нийт 99 эрүүл зүйн арчдаст шинжилгээ авахад 14 (14.12%) нь нянгийн бохирдол илэрсэн. Нийт шинжилгээнд хамруулсан 70 бүтээгдэхүүнээс 12 дээжийн сорилтын дүн хүлээгдэж, 59 дээж шинжлэгдсэн үзүүлэлтүүдээр холбогдох техникийн зохицуулалт, техникийн ерөнхий шаардлагын стандартыг хангасан байна. Шалгалтаар нийт 212 зөрчил илрүүлэн, 154 буюу 72.6%-ыг газар дээр нь арилгуулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 13 аж ахуйн нэгж, иргэнд 12 сая 400 мянган төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ногдуулж, бүрэн барагдуулсан.

Зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар 13, улсын/ахлах/ байцаагчийн 82 заалт бүхий 7 албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна. Шалгалтын дүнг нэгтгэж газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын шийдвэрийн хамт МХЕГ-т хүргүүлсэн.

4.4.5. “Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд шалгалт хийх тухай” 02-01/79 дугаартай удирдамжийн хүрээнд 2019 онд 46 үйлдвэрийг шалгах аар зарласнаас 32 буюу 69.5 хувийг хяналт шалгалтад хамруулаад байна. “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд 5 бага эрсдэлтэй, 23 дунд эрсдэлтэй, 4 нь их эрсдэлтэй дүгнэгдэж, шалгалтад хамрагдсан үйлдвэрүүдийн дундаж эрсдэл 40 хувь, хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 60.0 хувь байна. Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 7 үйлдвэрүүдийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үр дүнд үнэлгээ өгөхөөр эрүүл зүйн арчдас шинжилгээг 73 цэгээс авахад 17 буюу 23.28 хувьд нь нянгийн бохирдолт илэрсэн. Шалгалтад хамрагдсан 33 үйлдвэрүүдийн 17 нь төвлөрсөн шугам сүлжээнд холболттой, 15 үйлдвэр нь хэсгийн, 1 үйлдвэр зөөврийн усан хангамжтай, шалгалтын явцад хөндлөнгийн хяналтаар 21 ундны усны дээжийг шинжилгээнд хамруулахад Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторийн сорилтын дүнгээр 1 дээж “Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2005” стандартын нянгийн ерөнхий тооны зөвшөөрөгдөх хэмжээнээс их дүнтэй гарсан.

Шалгалтаар нийт 125 зөрчил илрүүлэн, 55 буюу 44 хувийг газар дээр нь арилгуулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 5 аж ахуйн нэгж, иргэнд 3 сая 300 мянган төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ногдуулж, бүрэн барагдуулсан.Зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтаны албан даалгавар 5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалтын үндэслэн “Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай” улсын/ахлах/ байцаагчийн 60 заалт бүхий 7 албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Гүйцэтгэлийн хяналтыг 14 үйлдвэрт буюу 45.45 хувьд хийж, гүйцэтгэлийн хяналтаар их эрсдэлтэй 2, дунд эрсдэлтэй 24, бага эрсдэлтэй 6 болж, эрсдэлийн дундаж 39 хувь, хууль тогтоомжийн сахин мөрдөлт 65 хувьтай, 6.6 хувиар дээшилсэн байна. Шалгалтын дүнг нэгтгэж газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын шийдвэрийн хамт МХЕГ-т хүргүүлэв.

4.5. Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалт:

4.5.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагуудыг шалгах тухай удирдамжын хүрээнд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр нийт 108 цэцэрлэг шалгалтад хамруулахаар зарласнаас, хяналт шалгалтанд 105 (97.2%)-ийг хамрууллаа. “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар 105 цэцэрлэгийг дүгнэхэд 21 (20.1%) нь “бага” эрсдэлтэй, 69 (65.7%)-нь “дунд” эрсдэлтэй 15 (14.2%) нь “их” эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Шалгалтын явцад нэг хүүхдэд олгогдож байгаа өдрийн хоолноос 45 сорьц, 50 цэцэрлэгийн унд ахуйн уснаас 85 сорьц, 50 цэцэрлэгийн агаараас нян судлалын шинжилгээ, 3 цэцэрлэгийн эдэлбэр газраас хөрсний шинжилгээ, цэцэрлэгт хэрэглэгдэж байгаа тоглоомноос 5 шинжилгээ, халдваргүйтгэлийн бодисоос 4 шинжилгээ, 60 цэцэрлэгээс 359 эрүүл зүйн арчдас шинжилгээ авч НМХГ-ын нэгдсэн төв лабораторит шинжлүүлэн, сорилтын дүнг үндэслэн үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.

Шалгалтын хугацаанд нийт 850 зөрчил илрүүлж 320(37.6%)-ийг шалгалтын явцад арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн үйл ажиллагааг зогсоох тухай акт 1, бүтээгдэхүүн хураах тухай акт 3 –ийг тогтоож, 395 заалттай 51 албан шаардлага, шинжилгээний дүнг үндэслэн 62 дүгнэлт бичиж, нийт 45 байгууллага, албан тушаалтан, иргэнд 22.600.000 төгрөгний шийтгэвэр ногдуулж барагдуулалтанд хяналт тавьж ажилласан. Мөн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, эрүүл ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бүртгэл хяналтын хөтлөлтийн загвараар хангаж ажиллалаа.

4.5.2 “Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, Үдийн цай хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт” хийх удирдамжийн хүрээнд 62 сургууль, тэдгээрт үйл ажиллагаа явуулж буй 54 цайны газрыг хамруулан хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд хамрагдсан 62 сургуулийг “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах” хяналтын хуудсаар шалгахад 1 (1.7%) нь их, 53 (85.4%) нь дунд, 8 (12.9%) нь бага эрсдэлтэй, “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлж буй 54 газрыг 1.10.4 кодтой “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцлийг шалгах” хяналтын хуудсаар шалгахад 3(5.5%) нь их, 44 (81,4%)нь дунд,7 (13.1 %) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

Шалгалтын явцад сургуулийн сургалтын орчны тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэлд тавигдах шаардлагын хэрэгжилтэнд үнэлгээ өгөх зорилгоор эрүүл зүйн шинжилгээг нийт 45

сургуулийн 300 цэгээс, ундны усны 21 дээж, 13 сургуулийн Үдийн цай хөтөлбөрт өгч буй хоолноос 30 дээж авч НМХГ-ын төв лабораторит шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргасан байна

Шалгалтын явцад сорилтын дүнг үндэслэн улсын байцаагчийн 63 дүгнэлт гарган, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 53 сургуульд нийт 385 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, холбогдох хууль тогтоомж зөрчсөн 27 байгууллага, аж ахуйн нэгжид 19.700 мянган төгрөгийн шийтгэвэрийн арга хэмжээ авч ажиллалаа.

4.6. Боловсролын хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалт:

4.6.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/96 тоот удирдамжийн дагуу 114 байгууллага шалгахаас 109 сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 6.1 кодтой “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар хянаж шалгахад 21(18.4%) нь бага, 63(55.2%) нь дунд, 25(21.9 %) нь их эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалтын явцад 1779 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр зөвлөгөө өгч, улсын /ахлах/ байцаагчийн нийт 601 заалт бүхий 64 албан шаардлага, 130 заалт бүхий 30 албан даалгавар хүргүүлж Зөрчлийн тухай хуулийн 9 дүгээрзүйлийг үндэслэн 60 албан тушаалтанд нийт 19.155.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, бүрэн барагдууллаа. Баянгол дүүрэг дэх “Анугийн найзууд” “Унагахан” “Бумбардайн найзууд” Баянзүрх дүүрэг дэх “Эх дэлхийн нөхөрлөл” Хан-Уул дүүрэг дэх “Цэцэн дагина зэрэг нийт 5 цэцэрлэгийг тодорхой шалтгааны улмаас хамрагдсангүй. Шалгалтаар “их” эрсдэлтэй үнэлэгдсэн 25 цэцэрлэг, шалгалтаас зайлсхийсэн төрийн бус өмчийн Баянгол дүүргийн “Унагахан” “Бумбардайн найзууд”, Баянзүрх дүүргийн “ Эх дэлхийн нөхөрлөл” цэцэрлэг /үүсгэн байгуулагч нь нас барсан тул үйл ажиллагаа зогссон/, Хан-Уул дүүргийн “Цэцэн дагина” /үйл ажиллагаа нь зогссон/ цэцэрлэгүүдийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлуулах санал бүхий улсын байцаагчийн дүгнэлт 9-ийг үйлдэж, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. “Их” эрсдэлтэй үнэлэгдсэн Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Чингэлтэй дүүргийн 220 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарт Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн тус газрын 2019 оны 04 сарын 04-ний өдрийн 02-01/1233 тоот арга хэмжээ тооцох санал бүхий албан бичгийг Нийслэлийн Засаг даргад хүргүүллээ. Баянзүрх дүүргийн төрийн бус өмчийн “Эрдмийн чуулган” цэцэрлэгийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2017 оны 12 сарын 26-ны өдөр дууссан байхад нийт 54 хүүхдээр хувьсах зардлыг 2018 оны 01 дүгээр сараас 2019 оны 04 дүгээр сар хүртэл олгосон, “Эрэл” цэцэрлэгийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2017 оны 03 дугаар

сарын 07-ны өдөр дууссан байхад тус тус хяналт тавин ажиллаагүй Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн нарт Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн арга хэмжээ тооцох санал бүхий албан бичгийг Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлж байна. Тус газрын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдахаар зарлагдсан Баянгол дүүрэг дэх “Унагахан”, “Бумбардайн найзууд” цэцэрлэгүүд нь 2019 оны 03 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарыг хүртэл өөрсдийн хүсэлтээр түр зогсоох хүсэлтийг гаргасныг хүлээн авч, түр хугацаагаар буюу хяналт шалгалтын хугацаанд үйл ажиллагаа явуулахгүйгээр шийдвэрлэсэн Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн даргад холбогдох арга хэмжээ авах санал бүхий албан бичгийг хүргүүлэн ажиллав. Цэцэрлэгүүдэд ажиллаж байсан мэргэжлийн бус 73 багшийг чөлөөлүүлэх албан даалгаврыг нэр бүхий 30 цэцэрлэгт хүргүүлэн хяналт шалгалтын явцын талаарх мэдээллийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын вэб сайтаар 28, “Хурд” агентлаг, “Парламент” TV болон бусад мэдээллийн хэрэгслээр нийт 8 удаа мэдээлэн ажиллав. Агаарын тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А-263/А-616 дугаар тушаал, захирамжийн хавсралтаар батлагдсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”, Монгол Улсын “MNS 5043:2016. 4.2 MBt хүртэл хүчин чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 5216:2016. Ахуйн хэрэглээний зуух Техникийн ерөнхий шаардлага” стандартуудын хэрэгжилтэд хяналт хийж, мэдэгдэх хуудсыг 68 байгууллагад хүргүүлэн ажиллав. Хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн хяналтын цахим системд бүрэн оруулсан

4.6.2. НМХГ-ын даргын 02-01/134 тоот Ерөнхий боловсролын сургууль, Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 52 байгууллага шалгахад 6.2 кодтой “Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар хянаж шалгахад 18(31%) нь бага, 33(56.7%) нь дунд, 5(8.6%) нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад нийт 778 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр зөвлөгөө өгч, улсын /ахлах/ байцаагчийн нийт 315 заалт бүхий 41 албан шаардлага, 9 заалт бүхий 16 албан даалгавар хүргүүлээ. Зөрчлийн мөрөөр Зөрчлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн 16 албан тушаалтанд нийт 4 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, бүрэн барагдууллаа. Шалгалтын явцад боловсролын сургалтын байгууллагын удирдлага, багш нарт боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийг мөрдөх талаар байгууллагын сургалтыг зохион байгуулаж, 133 сургуулийн

барилга байгууламжтай холбоотой үүссэн нөхцөл байдал, цаашид болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн 02-01/170 тоот албан бичгийг Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэст, холбогдох Яам, Тамгын газарт уламжлуулахаар хүргүүлэн ажиллалаа.

4.6.3. НМХГ-ын даргын баталсан 02-01/132 дугаартай “Дээд боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд дээд боловсролын 15 байгууллагын үйл ажиллагааг 6.4 кодтой “Дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлж шалгахад 1 сургууль “их”, 7 нь “дунд”, 7 нь “бага”, эрсдэлтэй, мэргэжлийн боловсрол, сургалтын 10 байгууллагын үйл ажиллагааг 6.3 кодтой “Мэргэжлийн боловсролын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлж шалгахад 1 сургууль “их”, 6 сургууль “дунд”, 3 сургууль “бага” эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтын хугацаанд нийт 381 зөрчил илрүүлж, 90 зөрчил буюу 23.6 хувийг шалгалтын явцад арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шалгалтын мөрөөр зохих ажлыг эрчимжүүлэх чиглэлээр улсын /ахлах/ байцаагчийн хамтарсан 128 заалт бүхий 19 албан шаардлага, 10 заалт бүхий 2 албан даалгавар өгч, биелэлтийг тооцон ажиллахаар боллоо. Илэрсэн зөрчлийн мөрөөр Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн нийт 10 хуулийн этгээдэд 3.000.0 мянган төгрөгийн шийтгэлийг оногдуулж, барагдууллаа. Шалгалтаар “Глобал удирдагч” дээд сургуулийн төгсөлтийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн дүнг үндэслэн тус газрын 2019.05.31-ний өдрийн “Хяналт тавьж ажиллах тухай” 02-01/3004 дугаарын албан бичгийг БСШУСЯ-нд, “Сам Юүк” МСҮТ-ийн ажиллагааны тухай улсын байцаагчийн 02-09-087/638 тоот дүгнэлтийг үйлдэн тус газрын 2019.05.31-ний өдрийн 02-01/3003 дугаарын албан бичгүүдээр ХНХЯ-нд хүргүүлж ажиллалаа.

5. Дэд бүтцийн хяналтын чиглэлээр:

НМХГ-ын даргын баталсан 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02-01/103 дугаартай “Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт **432** объектод **11** чиглэлээр хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **405** объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

5.1. Барилга техникийн хяналтын чиглэлээр:

5.1.1. Шинээр баригдаж буй барилгуудын тусгай зөвшөөрөл, барилгын үндсэн хийц бүтээц, техникийн нөхцлийн бүрдүүлэлт, барилгын ажлын

зөвшөөрлийн гэрчилгээ, угсралтын ажлын чанар, зураг төсөл, хууль, норм дүрмийн хэрэгжилтийг байдалд 2019 онд зарлагдсан **194** аж ахуй нэгж, байгууллагыг шалгалтанд хамруулахаас 173 барилга байгууламжийг хамруулж, 5.1, 5.1.2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд бага 81, дунд 68, их 24 дүгнэгдэж, цахим мэдээллийн санд оруулсан.

Авсан арга хэмжээ:

-Шалгалтын хүрээнд 268 зөрчил илрүүлж, 214 зөрчил дутагдлыг арилгуулж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг 5, хялбаршуулсан журмаар 6, нийт 11 хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, ААН-д нийт 48000,0 мян.төгрөгний шийтгэл ногдуулж, хугацаанд нь барагдуулсан.

Тайлангийн хугацаанд 12 заалттай 4 албан шаардлага, улсын ахлах байцаагчийн дүгнэлт 10, 2 нэр төрлийн зөвлөмж, 2 нэр төрлийн сэрэмжлүүлэг тус бүр 173 ААН, байгууллага, СӨХ, өрхийн эмнэлэг, сургуульд хэвлэл мэдээлэл, ТВ-д 2 шалгалтын талаархи мэдээллийг өгсөн. **Үр дүн:** Эрх бүхий албан тушаалтны албан даалгавар 11 гаргаж, биелэлтийг 95 хувь хангуулж ажиллалаа.

Гүйцэтгэл: 89.2 хувь.

5.1.2. Барилгын материалын хяналт:

Тайлант жилд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн **25** объектоос төлөвлөгөөт хяналт шалгалт 5.3 кодтой хяналтын хуудсаар нийт **22** барилгын материалын үйлдвэрт шалгалт хийж, дунд эрсдэлтэй 7, бага эрсдэлтэй 15 үнэлэгдсэн.

-Шалгалтын Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч 1, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтсийн хөдөлмөрийн хяналтын байцаагч 10, хөдөлмөрийн эрүүл ахуйн 5 улсын /ахлах/ байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч 7, Агаарын чанарын хяналтын чиглэлээс 2, бүгд 25 улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Авсан арга хэмжээ:

Шалгалтаар 2 зөрчил илрүүлж, ЗТХ-ийн дагуу 1ААН-д 5000,0 мян.төгрөгний шийтгэл ногдуулсан. Хяналт шалгалт хийсэн 22 үйлдвэрт зөвлөмж өгч ажиллав.

Гүйцэтгэл: 88,0 хувь.

5.1.3. Ус, дулаан хангамжийн хяналтаар:

Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт **29** объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **29** объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Баянгол дүүрэг, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 29 аж ахуйн нэгж, байгууллагын шинээр барьж буй барилга байгууламжийн сантехник /ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, агаар сэлгэлт/-ийн системийн төлөв байдалд шалгалт хийж, зураг төсөл, бичиг баримт, угсралтын ажилд илэрсэн дутагдлуудыг арилгуулахаар зураг төсөл, угсралтын 7 /Гүрт цамхаг ХХК, Хууль зүй дотоод хэргийн яаманд Шинэ яармаг хаусинг прожект ХХК, Дукат ХХК-д, Марч констракшн ХХК-д, Шинэ гэр түншлэл ХХК, Бүрдэнэ булаг ХХК, Жамо ХХК, Их модун ХХК/ аж ахуйн нэгж, байгууллагад улсын ахлах байцаагчийн 35 заалт бүхий 8 албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулж, ажиллалаа.

Барилгын зураг төсөл, бичиг баримтын бүрдэлт дутуу, шугам сүлжээний угсралтын зургийн дагуу хийгээгүй, техникийн нөхцлийг зөрчсөн зэрэг нийт 45 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 3 байгууллагад нийт 11 сая/төг торгууль ноогдуулж, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллав.

Төлөвлөгөөт шалгалтыг шилэн хяналтын цахим системд бүрэн шивж, орууллаа.Шалгалтын үр дүнг Газрын даргын зөвлөлийн 16 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан хэрэгжүүлж ажиллав. Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд өгсөн үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг нийт 8 ААН-д хийхэд холбогдох техникийн нөхцөл авч, зургийн дагуу угсралтыг гүйцэтгэсэн ба нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн дуусгасан, биелэлт 100 хувьтай байв. **Гүйцэтгэл: 100 хувь**

5.1.4. Өргөх механизмын хяналтаар:
Тус газрын даргын батласан 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02-01/97 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт **32** объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **32** объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

Авсан арга хэмжээ:
“Сүү” ХК-ийн лифтний ашиглалт, “Ханбаян констракшн” ХХК, “Сима тек” ХХК, “Гэрэлт урсгал” ХХК, “Бөлинтэ” ХХК, “Ай ти партнерс” ХХК, “Эвэр туурай” ХХК, “Цамхагт кран” ХХК, “Өндөр кран” ХХК-уудын өргөх механизмын угсралт, засвар үйлчилгээний чадамжийн байдалд хяналт шалгалтыг хийж 20 дүгнэлт, 58 заалт бүхий 12 албан шаардлага гаргаж ажилласан байна.

Үр дүн:
Бага эрсдэлтэй 20, дунд эрсдэлтэй 12 байгууллага үнэлэгдсэн.
Гүйцэтгэл: 100%

5.1.5 Хот байгуулалтын хяналтаар:
Нийт **4 төсөлд** хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **3** төслийг хяналт шалгалтад хамрууллаа. /1 төсөл зогссон/

Газрын даргын баталсан 02-01/227 дугаартай удирдамжийн дагуу Гэр хороолол дахин төлөвөлтийн төсөл хэрэгжүүлж буй нийт 4 төслийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалтаар 4 аж ахуйн нэгжийг хамруулахад шалгалтын явцад СХД-ийн 10 дугаар хороонд хэрэгжиж буй “Назу Проперти” ХХК-ийн төсөл зогссон.

“Моннис Урбан Девелопмент” ХХК, “Гранд Лайн” ХХК, “Очирням Проперти” ХХК, “Назу Проперти” ХХК-иудад Зөрчлийн тухай хуулийн 12.6-ийн 2-т заасны дагуу тус бүрд нь зөрчлийн хэрэг нээж 40 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэв.

Гүйцэтгэл: 75,0 хувь

5.2. Эрчим хүчний хяналтын чиглэлээр:

5.2.1. Эрчим хүчний хяналтаар

“Худалдааны, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамж, “Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлэгийн ашиглалт хариуцсан ААН, байгууллагад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын хүрээнд **34** объектод хяналт шалгалт хийхээс 34 объектод хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар дунд эрсдэлтэй-29, бага эрсдэлтэй-5 гзар үнэлэгдсэн.

Авсан арга хэмжээ:

Шалгалтад хамрагдсан ААНБ-уудын худалдааны төвийн цахилгаан хангамжийн ашиглалтын байдлыг 5.29 кодтой “Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийг шалгахад дунд эрсдэлтэй-16, бага эрсдэлтэй-3 үнэлэгдэж, улсын /ахлах/ байцаагчийн 58 заалттай 16 албан шаардлага хүргүүлж, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаагүй “МВС групп” ХХК, “Барс импекс” ХХК, “Саруул групп” ХХК, “Батсервис” ХХК, Эрдэнэбулган ХХК-иудад Зөрчийн тухай хуулийн дагуу 2.500 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, бүрэн барагдуулсан.

Хяналтын хуудсыг шилэн хяналтын системд бүрэн оруулж, шалгалтын дүнг даргын зөвлөлийн 10 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.

Үр дүн: 125 зөрчил илрүүлж, 83 заалт бүхий 24 албан шаардлага, 12 зөвлөмж, 3 албан бичиг явуулж, 12 ААН-д 6600,0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулан, 106 зөрчлийг арилгуулсан.

Хяналтын хуудсыг шилэн хяналтын системд бүрэн оруулж, шалгалтын дүнг даргын зөвлөлийн 10 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.

Гүйцэтгэл 100 хувь.

5.3. Газрын тосны хяналтын чиглэлээр:

5.3.1. НМХГ-ын 2019 оны төлөвлөгөөт шалгалтаар Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний хангамж, худалдаа үйлчилгээ эрхэлдэг **21** аж ахуйн нэгжийн **8** агуулах, **16** ШТС, **10** автомашиныг хийгээр цэнэглэх станц зэрэг нийт **34** объектод хяналтын хуудсаар холбогдох

хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгахад Шинэ соёмбо ХХК-ийн СБД-ийн 15-р хороо Архустай ШТС, М Ойл групп ХХК-ийн СБД-ийн 9-р хороо ШТС, Синчи ойл ХХК-ийн БГД-ийн 23-р хороо Зурагт ШТС, Интер стандарт нефть ХХК-ийн ЧД-ийн 7-р хороо Хувьсгалчдын гудамжинд байрлах ШТС, Шунхлай трейдинг ХХК-ийн ХУД-ийн 3-р хороо Хүүшийн ам ШТС, Шунхлай трейдинг ХХК-ийн ХУД-ийн 3-р хороо ДЦС-3 ШТС, Жаст ойл ХХК-ийн СБД-ийн 12-р хороо ШТС, Тод петролиум ХХК-ийн СХД-ийн 20-р хороо ШТС, Борхуст хайрхан ХХК-ийн СХД-ийн 21-р хороо Жаргалант тосгонд байрлалтай ШТС зэрэг нийт 10 ШТС, Синчи газ ХХК-ийн БГД-ийн 9-р хороо Баянхошуу АХЦС, Дашваанжил ХХК-ийн ЧД-ийн 7-р хороо Зурагт АХЦС-41, СХД-ийн 22-р хороо Тахилтын зам дагуу байрлалтай АХЦС-32, ЧД-ийн 19-р хороо Зунжин АХЦС, НД-ийн 1-р хороо төв зам дагуу байрлах АХЦС, Горгаз ХХК-ийн 20-р хороо АХЦС-2 нийт 6 АХЦС-ууд их эрсдэлтэй үнэлэгдсэн ба дээрх 12 ШТС-д холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн Зөрчлийн тухай хуулийн 7.14-р зүйлийн 2.5 заалтыг үндэслэн нийт 12.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийг арилгуулахаар 12 албан даалгавар өгч үйл ажиллагааг зогсоосон. Мөн жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй хий худалдаалсан Шунхлай трейдинг ХХК-ийн хууль бусаар олсон орлогыг тооцон 3.000.000 төгрөгийг улсын орлого болгосон.

Үр дүн:

-Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Ганг винг ХХК, Хөвсгөл трейд ХХК, Эсэн трейд ХХК, Жаст ойл ХХК, Хөрс авто сервис ХХК, Лекс ойл ХХК, Хүнс трейд ХХК зэрэг 8 агуулахад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 32 заалттай 8 албан шаардлага хүргүүлсэн.

-Содмонгол групп ХХК, Магнай трейд ХХК, Петростар ХХК-иудын 119 ШТС-ын 555 ширхэг шатахуун хадгалах савны ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж 2000 оноос өмнөх, 2000-2010 он хүртэл, 2010-2019 он хүртэлх жилээр насжилтыг үнэлэн судалгаа гаргаж, 10-аас дээш жилээр ашиглаж байгаа саванд техникийн магадлал хийж ашиглалтын аюулгүй ажиллагааг хангуулах тухай 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02-03/2008, 02-03/2009, 02-03/2010, дугаартай албан бичгийг тус газруудад хүргүүлсэн.

Гүйцэтгэл: 100 хувь.

5.4. Автозамын хяналтын чиглэлээр:

5.4.1. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 23 объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс 23 объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

НМХГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын даргын баталсан 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02-01/212 дугаартай “Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажилд хяналт шалгалт хийх тухай удирдамжын дагуу 23 объектод хяналт шалгалтыг

явууллаа. Шалгалтаар 70 зөрчил илрүүлж, 45 заалт бүхий 15 албан шаардлага, 16 дүгнэлт, 5 албан бичгийг холбогдох газарт хүрүүлж, 3 аж ахуйн нэгжид 15000,0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулсан.

Үр дүн: бага эрсдэлтэй-14, дунд-9 эрсдэлтэй үнэлэгдсэн.

Томоохон ажлуудаас дурдвал:

-“СТСЕ мон” ХХК-ний гүйцэтгэж байгаа **Хөшгийн хөндий Улаанбаатар чиглэлийн 32,226 км хурдны авто зам, гүүр, асфальтбетон заводын үйл ажиллагаанд,**

-“Чайна райлвэй твэнти бюро групп корпорэйшн монголия” ХХК-ний гүйцэтгэж байгаа Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа **224.26 у/м, “А” рамп 50 у/м, “D” рамп 276.6 у/м Яармагийн шинэ гүүр, авто замын зураг төсөл, барилга угсралт,**

-Баянзүрх дүүрэг **Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртлэх 20,9 км замын өргөтгөл, шинэчлэлтийн барилга угсралт,**

-Хан-Уул дүүрэг, **Сонсголонгийн 289,4 у/м** төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажлуудыг хамруулсан.

Газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЗТХЯ, НАЗХГ-т “Зураг төслийн хяналтыг сайжруулж, авто зам, замын байгууламжийн борооны ус зайлуулах сувагчлалыг төвлөн гүйцэтгэж байхыг үүрэг болгосон.

Гүйцэтгэл 100 хувь.

5.5. Автотээврийн хяналтын чиглэлээр:

5.5.1. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт **23** объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **23** объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/111 дугаартай удирдамж боловсруулж, батлуулав.

Газрын даргын баталсан “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/111 дугаартай удирдамж болон газрын дарга, Тээврийн Цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу “Автотээврийн Үндэсний төв” ТӨҮГ-ын Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан салбарууд болон Нийтийн тээврийн үйлчилгээний газрын “Техникийн үзлэг, оношлогооны төв”, “Доктор авто сүлжээ” ХХК, “Нива трейд” ХХК, “Монгол терминал” ХХК, “Мөнх ерөөлт интернэйшнл” ХХК-ниудын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн 10 суурин /17 шугам/, 5 явуулын төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тэдгээрийн үйл ажиллагааг 5.20 дугаартай “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг эрхлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар дүгнэхэд 7 нь “бага эрсдэлтэй”, 1 нь “дунд эрсдэлтэй” үнэлэгдлээ.

Үр дүн:

Шалгалтаар 34 төрлийн 65 зөрчлийг илрүүлж, 32 заалттай 7 албан шаардлага гаргаж, 3 байгууллагад 900.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулав. Зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, прокурорын байгууллагаар хянуулав. Шалгалтын дүнгийн тухай 02-01/111 дугаартай танилцуулга бичиж, шалгалтын дүнг 2019.05.23-ны өдөр газрын даргын дэргэдэх зөвлөлийн тавдугаар хурлаар хэлэлцүүлж, хурлаас гаргасан шийдвэрийн дагуу “Шалгалтын дүнгийн тухай” Зам, тээврийн хөгжлийн яаманд 02-03/2119, Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газарт 02-03/2122, Тээврийн Цагдаагийн албанд 02-03/2110, “АТҮТ” ТӨҮГ-т 02-03/2123 дугаартай албан бичиг тус тус хүргүүлэв.

2. “Зориулалтын автомашинаар тээврийн хэрэгсэл зөөн шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/110 дугаартай удирдамж боловсруулж, батлуулав.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга, Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга нарын хамтран баталсан “Зориулалтын автомашинаар тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуудээрх байгууллагуудын ажилтнуудтай хамтран “Бат Зэв” ХХК, “Авто гоулд транс” ХХК, “Юу Эн Пи Эм Жи Эл” ХХК, “Бодь транс” ХХК, “Автохүч” ХХК, “Сидней констракшн” ХХК, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ, “Успех” ХХК, “Энергитикланд” ХХК, “Их тээвэр” ХХК, “Би Икс Юу Ти” ХХК, “Даблю Эйт” ХХК, “Баян хаябуса” ХХК, “Тэнгэрлэг наяд групп” ХХК-ниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Шалгалтаар дээрх аж ахуйн нэгжүүдийн 9 техникийн засвар, үйлчилгээний байр, битүү зогсоол, тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх 61 зориулалтын автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тээвэрлэлтийг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлээгүй, техникийн засвар, үйлчилгээ хийх байргүй, мэргэжлийн инженер техникийн ажилтангүй, тээврийн хэрэгслүүдэд засвар, үйлчилгээ хийх хуваарьгүй, ажил үйлчилгээнд ашиглах дуут болон гэрлэн дохиог суурилуулаагүй, техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцлийг бүрэн хангаагүй зэрэг 224 зөрчлийг илрүүлж, “Зөрчлийг арилгуулах тухай” 168 заалттай 14 албан шаардлага гаргаж, 13 аж ахуйн нэгжид 4200.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэв.

Үр дүн:5.36 кодтой “Тусгай үйлчилгээний авто байгууллага, объектыг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад 5 нь “бага эрсдэлтэй”, 9 нь “дунд эрсдэлтэй” үнэлэгдлээ.

. Шалгалтын дүнг 2019.05.23-ны өдрийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн тавдугаар хурлаар хэлэлцүүлж, хурлаас гаргасан шийдвэрийн

дагуу “Шалгалтын дүнгийн тухай” Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт 02-03/2121, Тээврийн цагдаагийн албанд 02-03/2110 дугаартай албан бичиг тус тус хүргүүлэв.

Гүйцэтгэл: 100 хувь

5.6. Хэмжил зүйн хяналтын чиглэлээр:

5.6.1. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт **28** объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс **28** объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

1.НМХГ-ын даргын баталсан 02-01/74 дугаартай удирдамжийн дагуу 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу 11 аж ахуйн нэгжид хяналт шалгалтын ажлыг хийж, супермаркет, их дэлгүүр 3, хүнсний худалдааны төв 8 хамрагдсан. Нийтдээ 11 дэлгүүр, 8 үйлдвэр, 209 иргэний 270ш хэмжих хэрэгслийг, 5 нэр төрлийн 300 гаруй савласан бүтээгдэхүүний тоон хэмжээг шалгаж, 69 зөрчил илрүүлж хяналт шалгалтын явцад 58 зөрчлийг арилгуулав.

Авсан арга хэмжээ, үр дүн:

Хяналт шалгалтаар “Алтжин бөмбөр, “Юмт бөмбөгөр” худалдааны төв дээр 2 удаа байгууллагын сургалтыг зохион байгуулан гарын авлага 5 боловсруулан гаргаж, телевизэд 2 удаа /Зариг, TV-5/, радиод 2 удаа /Монголын радио Хурд/ мэдээлэл өгсөн.

-5.28.1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 2 аж ахуйн нэгж “Дунд”, 9 аж ахуйн нэгж “Бага” эрсдэлтэй байсан ба 5.28.3 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 5 аж ахуйн нэгж “Дунд”, 6 аж ахуйн “Бага” эрсдэлтэй байлаа. Зөрчил гаргасан 8 аж ахуйн нэгж, 5 иргэнд “Зөрчлийн тухай хуулийн дагуу 5 сая 500 мянган төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, хугацаанд нь барагдуулсан.

Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 18 заалттай 5 албан шаардлага, 10 албан даалгавар гаргаж, биелэлтийг хангуулж ажиллалаа.

Шилэн хяналтын цахим системд шалгалтанд хамрагдсан 11 аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулсан. Газрын дэд даргын Зөвлөлийн хурлаар, үр дүнг даргын Зөвлөлийн хурлаар тус тус оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. 14 аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийсэн.

“Хэмжилзүйн тухай” хуулийн хэрэгжилт 81,2% байна.

2.НМХГ-ын даргын баталсан 02-01/145 дугаартай удирдамжийн дагуу 17 хэмжилзүйн хяналт шалгалт хийж, ААН-ийн 36 ШТС-ыг хамруулан 108ш хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалт, хэмжлийн нэгдмэл байдал, хэмжилзүйн дотоод хяналтыг шалгалаа. Хяналт шалгалтаар 18 зөрчил илэрч, зөрчлийг арилгуулахаар 21 заалттай 7 албан шаардлага хүргүүлэв. “Зөрчлийн тухай” хуулийн дагуу “Нью энерги стар” ХХК-д 500 мянган төгрөгийн торууль ногдуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэв. МХЕГ-аас баталсан 5.28.1 кодтой хяналтын хуудсаар 16 аж

ахуйн нэгжийн эрсдэлийг үнэлэхэд “Дунд” эрсдэлтэй 4, “Бага” эрсдэлтэй 12 аж ахуйн нэгж, шилэн хяналтын цахим системд бүртгэгдсэн. Газрын даргын Зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. 8 аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгээд байна. **“Хэмжил зүйн тухай” хуулийн хэрэгжилт 92.1% байна.**

5.7. Мэдээлэл, холбооны хяналтын чиглэлээр:

5.7.1. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 23 объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс 23 объектыг хяналт шалгалтад хамрууллаа.

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-03/338 дугаартай удирдамж боловсруулж, батлуулав.

Газрын дэд даргын 02-03/338 дугаартай удирдамжийн дагуу зарлагдсан 23 байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тэдгээрийн үйл ажиллагааг 5.25 кодтой “Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний угсралтын ажлыг шалгах хяналтын хуудас”, 5.26 кодтой “Радио, долгион ашиглагч этгээдийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 5.27 кодтой “Шуудангаар үйлчлэгч этгээдийг шалгах хяналтын хуудас”-аар дүгнэхэд 16 нь “бага эрсдэлтэй”, 7 нь “дунд эрсдэлтэй” үнэлэгдлээ.

Үр дүн:

Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд Харилцаа холбооны тухай болон бусад дагалдах хуулиуд, мөн технологийн горим, ашиглалт, байгууллагын дотоод хяналтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Шалгалтаар давхардсан байдлаар 6 төрлийн 47 зөрчлийг илрүүлэн, арилгуулж, 4 чиглэлийн 23 зөвлөмж гарган хүргүүлсэн.

6. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр:

6.1.Рентген оношилгоо, рентген зураг авах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалт:

6.1.1. НМХГ-ын даргын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталсан “Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 02-01/77, 02-01/88 дугаартай удирдамжаар 42 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, давхардсан тоогоор нийт 300 зөрчил илрүүлж, зөрчил дутагдлыг арилгуулахаар 65 заалттай улсын байцаагчийн 18 албан шаардлага, 31 заалттай улсын байцаагчийн 6 хамтарсан албан шаардлага, 140 заалттай эрх бүхий албан тушаалтны 17 албан даалгавар, улсын байцаагчийн 1 акт үйлдэж, 42 аж ахуйн нэгж, байгууллагад тус тус хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Хяналт шалгалтад хамрагдсан 42 аж ахуйн нэгж, байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг 10.2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд бага эрсдэлтэй 32, дунд эрсдэлтэй 8, их эрсдэлтэй 2 объект үнэлэгдлээ. Хяналт шалгалтаар 17 аж ахуйн нэгж, байгууллагад зөрчлийн хэрэг нээж,

зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 6 хуулийн этгээд, 11 хүнд нийт 19 сая 300 000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан, 14 аж ахуйн нэгж байгууллагын 16 рентген аппаратын ашиглалтын үйл ажиллагааг прокурорын тогтоолоор 3 сарын хугацаагаар хэсэгчлэн түр зогсоож, цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлж ажилласан.

- Байгууллагын сургалтыг хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, цацрагийн дотоод хяналтын ажилтан, цацрагтай ажиллагч нийт 77 албан хаагчдад зохион байгуулж, цацрагийн соёлыг хэвшүүлсэн.
- Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 40 аж ахуйн нэгж, байгууллагад хийж төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн 203 зөрчлөөс 183 зөрчлийг бүрэн арилгасан ба эрх бүхий албан тушаалтны албан даалгаварын биелэлт хангагдсан 14 аж ахуйн нэгж, байгууллагын 16 рентген аппаратын ашиглалтын үйл ажиллагааг сэргээсэн.
- Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг НМХГ-ын даргын баталсан календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн НМХГ-ын даргын зөвлөлийн 9 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлж, хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлсэн.
- Эмнэлгийн эмчилгээ оншилгоонд рентген аппарат, тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хийсэн хамтарсан хяналт шалгалтын дүнг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн НМХГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.
- Хурлын шийдвэрийн биелэлтийг тус тус хангуулж ажилласан.

Шилэн хяналтын системд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 42, үйл ажиллагаа зогссон /Цэц энхмаа, Жино-Ач, Тэргэл медиа, Цэгц Алтай/ 4 аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа зогссон төлөвт оруулсан. Мөн гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан 40 аж ахуйн нэгж, байгууллагын хяналт шалгалтын дүнг бүрэн оруулсан.

6.2. Цацраг идэвхт үүсгүүр ашиглаж, хадгалж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

6.2.1. НМХГ-ын газрын даргын баталсан 02-01/82 тоот удирдамжийн дагуу 11 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, цацрагийн аюулгүй ажиллагааг 10.1 кодтой хяналтын хуудсаар давхардсан тоогоор нийт 91 зөрчлийг илрүүлж, эрсдэлийг үнэлэхэд 2 байгууллага их, 9 аж ахуйн нэгж, байгууллага бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

- Хяналт шалгалтаар цацрагийн аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагыг хангаж ажиллаагүй 5 аж ахуйн нэгж /“Геосан” ХХК, “Монкаротаж” ХХК, Цөмийн физикийн судалгааны төв, Насны зам ХХК, Бэрх зараа ХХК /-д зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 2 хуулийн этгээд, 2 хүнд нийт 6 сая 600 000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, 40 ширхэг цацраг идэвхт үүсгүүр, 2 ширхэг

цөмийн хэмжүүр багажийг прокурорын тогтоолоор 3 сарын хугацаагаар хэсэгчлэн түр зогсоон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлж ажилласан.

Дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудад зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 5 албан даалгавар хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Зөрчил гаргасан Цөмийн физикийн судалгааны төвийн захиралд Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4-т заасны дагуу сануулах арга хэмжээ тооцуулж ажилласан.

- Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор нийт 5 заалттай улсын байцаагчийн 5 албан шаардлагыг тус тус хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.
- Байгууллагын сургалтыг хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, цацрагийн дотоод хяналтын ажилтан, цацрагтай ажиллагч нийт 38 албан хаагчдад зохион байгуулж, цацрагийн соёлыг хэвшүүлэх талаар хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан таниулсан.
- Нийслэлийн Авто замын газар нь үйл ажиллагаагаа бүр зогсоож цацраг идэвхт үүсгүүр бүхий цөмийн хэмжүүрийг Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Изотоп конторт 2018 оны 12 сарын 18-ны өдөр шилжүүлсэн учир хяналт шалгалт хийгдээгүй.
- Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 9 аж ахуйн нэгж, байгууллагад хийж төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн 34 зөрчлөөс 31 зөрчлийг бүрэн арилгасан байдлыг үндэслэн 3 аж ахуйн нэгж, байгууллагын 40 ширхэг цацраг идэвхт үүсгүүрийн ашиглалтын үйл ажиллагааг сэргээсэн. Эрх бүхий албан тушаалтны албан даалгавар, улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт нийт 91.2%-тай байна.
- Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг НМХГ-ын даргын баталсан календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн НМХГ-ын даргын зөвлөлийн 8 дугаар хурлаар хэлэлцүүлж, хурлын шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлэн, хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулж ажилласан.
- Шилэн хяналтын системд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 11, гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан 9 аж ахуйн нэгж, байгууллагын хяналт шалгалтын дүнг бүрэн оруулсан.

6.3. Рентген багаж, тоног төхөөрөмж ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн хяналт шалгалт:

Аюулгүйн үзлэг шалгалт, аж үйлдвэрийн салбарт ионжуулагч цацрагийн үүсгүүр ашиглаж буй 22 аж ахуйн нэгж, байгууллагад цацрагийн аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сахин мөрдөж ажиллах тухай НМХГ-ын даргын 02-01/122, 02-01/129 тоот мэдэгдлийг тус тус хүргүүлсэн.

- НМХГ-ын даргын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталсан 02-01/87 дугаартай “Аюулгүйн үзлэг шалгалт, аж үйлдвэрийн салбарт ионжуулагч цацрагийн үүсгүүр ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар 9 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, цацрагийн аюулгүй ажиллагааг 10.1 кодтой, 10.3 кодтой хяналтын хуудсуудаар их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 2, бага эрсдэлтэй 6 байгууллага үнэлэгдэж, давхардсан тоогоор нийт 74 зөрчил илэрсэн.

- Хяналт шалгалтаар цацрагийн үүсгүүрийг ашиглах тусгай зөвшөөрөлгүй, цацрагийн аюулгүй байдлыг хангуулаагүй 4 аж ахуйн нэгж /“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК, Улаанбаатар хот дахь Гаалийн газар, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, “МИАТ” ХК-ийн Агаарын хөлөг засвар үйлчилгээний газар/-д зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчил гаргасан 1 хүнд 300 000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК, Эрчим хүчний хөгжлийн төв, Улаанбаатар хот дахь Гаалийн газар зэрэг 3 аж ахуйн нэгж, байгууллагын рентген багаж, төхөөрөмжийн ашиглалтын үйл ажиллагааг прокурорын тогтоолоор түр, хэсэгчлэн зогсоож, илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 4 албан даалгавар хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Зөрчил гаргасан Улаанбаатар хот дахь Гаалийн газар, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, “МИАТ” ХК-ийн Агаарын хөлөг засвар үйлчилгээний газруудын дээд шатны байгууллагуудад Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4-т заасны дагуу арга хэмжээ тооцууллаа.

- Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу нийт 8 заалттай улсын байцаагчийн 3 албан шаардлага, 1 аж ахуйн нэгж, байгууллагад 4 заалттай улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Эрчим хүчний хөгжлийн төвийн рентген радиографийг цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын байцаагчийн актаар битүүмжилсэн.

- Хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн “Метал тест” ХХК нь үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон тухай албан бичгээр мэдэгдсэн тул шилэн хяналтын системд үйл ажиллагаа зогсоосон төлөвт оруулсан.

- Байгууллагын сургалтыг хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, цацрагийн дотоод хяналтын ажилтан, цацрагтай ажиллагч нийт 43 албан хаагчдад зохион байгуулж, цацрагийн соёлыг хэвшүүлэх талаар хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан таниулсан.

- Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 8 аж ахуйн нэгж, байгууллагад хийж төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн 67 зөрчлөөс 49 зөрчлийг бүрэн арилгасан байна. Эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг бүрэн

биелүүлж, зөрчлөө арилгасан Дулааны 2-р цахилгаан станц, Улаанбаатар хот дахь Гаалийн газрын нийт 2 рентген тоног, төхөөрөмжийн ашиглалтын үйл ажиллагааг сэргээсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг НМХГ-ын даргын баталсан календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн НМХГ-ын даргын зөвлөлийн 6 дугаар хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлсэн. Хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

6.4. 4RAIS системийн дагуу цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэлийг хөтлөх:

6.4.1 Цацрагийн хяналтын “RAIS” мэдээллийн системд 42 аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн мэдээллийг нэмж, мэдээллийн санд баяжуулалт хийсэн. Мөн 2018 онд цацраг идэвхт үүсгүүрийн импортын тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын 49 тусгай зөвшөөрлийн мэдээлэл, 2018, 2019 онд цацрагийн үүсгүүр ашиглах хадгалах 379 тусгай зөвшөөрлийн мэдээллийг шинээр оруулсан. Улсын хэмжээнд цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 11 байгууллагын 23 цацраг идэвхт үүсгүүр, 125 аж ахуйн нэгж байгууллагын 158 рентген аппарат тоног төхөөрөмжийг мэдээллийн санд оруулсан. Мөн цацрагтай ажиллагчдын хувийн тунгийн мэдээлэл, хяналт шалгалт, цацрагийн үүсгүүрийн мэдээллийг оруулсан.

7. Агаарын чанарын хяналтын чиглэлээр:

7.1. Уурын болон 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хяналт шалгалт:

7.1.1. НМХГ-ын даргын баталсан 02-01/59 дугаартай “Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагчдад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн хуулийн этгээдийн уурын болон ус халаах зуухны байгууламжийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 1 иргэн, 99 хуулийн этгээдийн 182 зуух хяналт шалгалтад хамрагдаж 13 зуухны хаягдал утаанд хийн хэмжилт хийж, эрсдэлээр үнэлэхэд 23 /23%/ их, 45 /45.2%/ дунд, 31 /31.8%/ бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Шалгалтаар илэрч буй зөрчлүүдийн шалтгаан нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулдаггүй тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд орсон ажлыг хугацаанд нь хийж хэрэгжүүлдэггүй, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр батлуулан мөрдөж ажилладаггүй, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилладаггүй, хэдийгээр зуухаа сольж, технологийн шинэчлэл хийсэн ч инженер, техникийн мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс зуух ашиглалт буруу, цэвэрлэгээ, үйлчилгээ

хийгдэхгүй, галлагаа буруу хийгддэг, галч тогтвор суурьшилтай ажилладаггүй, манаач галлагаа хийдэг, хөрөнгө мөнгө хангалттай төсөвлөдөггүй зэрэг нийт 368 зөрчил илэрсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар 42,579,000 төгрөгийн шийтгэл ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 129 заалттай 44 албан шаардлага, 108 заалттай 36 эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүллээ. 100 квт-аас дээш хүчин чадалтай зуух ашиглагч төрийн өмчийн 62 ААНБ-д мэдэгдэл, 12 сургууль, цэцэрлэгт зөвлөмж хүргүүлэн, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглагч 68 хуулийн этгээдэд Засгийн газрын 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулсан.

ХУД “Оймон” ХХК, Эртний хүнс ХХК, БГД “Өнө-Орших маргад” ХХК-иуд төвлөрсөн дулаан хангамжид холбогдож, ЧД 155 дугаар цэцэрлэг цахилгаан халаагуурт бүрэн шилжсэн. БЗД “Сtimo” ХХК, “Буянт их буурал” ХХК, “Хоёулаа хүү” ХХК, БГД “Кондитор УБ” ХХК, ЧД “Магнит сервис” ХХК, СХД Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс тус тус төвлөрсөн дулааны шугамд холбогдохоор техникийн нөхцөл авсан, 10 аж ахуйн нэгжийн ус халаах зууханд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар техникийн магадлал хийлгүүлж паспортжуулсан. 30 ажилтныг галчийн мэргэжлийн сургалтад хамруулан зуухны машинчаар ажиллах эрх олгосон. 7 ААН Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн.

Шалгалтын дүнг НМХГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 02-01/2178 дугаартай албан бичгээр БОАЖЯ болон МХЕГ-т, 02-01/2167 дугаартай албан бичгээр НЗД-д, 02-03/2195 дугаартай албан бичгээр дүүргүүдийн Засаг дарга нарт холбогдох саналаа хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардлага, мэдэгдлийн дагуу 21 сургууль, цэцэрлэг цахилгаан болон хийн халаагуурт шилжин, 21 сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 2 байгууллагын 3 объектын халаалтын зуух Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газарт шилжин, 5 объект дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авсан.

13 зөрчлийн хэрэг нээж ажилласан, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 22, зөрчлийн хэрэг нээн татгалзсан 1, улсын байцаагчийн 826 албан шаардлага, 33 эрх бүхий албан тушаалтны даалгавар, 16 төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын 62 объектод мэдэгдэл хүргүүлж, 138 хорооны Засаг дарга, хэсгийн ахлагчдад, 6 дүүргийн МХХ-ийн улсын /ахлах/ байцаагчдад, агаарын бохирдлын томоохон болон эх үүсвэр ашиглагч 68 хуулийн этгээдэд 13 удаагийн сургалт зохион байгуулсан байна.

7.2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хяналт:
7.2.1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 02-01/109 тоот “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн

их багтаамжийн автобусны утааны тортогжилтын хэмжээнд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 17 аж ахуйн нэгж, байгууллагаас 17 /100%/ аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан “Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах” 5.21 дугаартай хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж, Автотээврийн үндэсний төв, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газартай хамтран шугам замд зорчигч тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобусны утааны тортогжилтын хэмжээнд хэмжилт хийхэд 5 (29.5%) дунд эрсдэлтэй, 12 (70.5%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Шугам замын шалгалтанд 224 автобус хамрагдсанаас 161 (71.9%) нь стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж, 63 (28.1%) нь утааны тортогжилтын хэмжээ стандартаас хэтэрсэн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 10 аж ахуйн нэгжид 8.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 10 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 15 заалттай 5 албан шаардлага, 10 эрх бүхий албан тушаалтны даалгавар, 2 зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Шалгалтын дүнг НМХГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 02-01/2168 дугаартай албан бичгээр ЗТХЯ болон МХЕГ-т, 02-01/2169 дугаартай албан бичгээр Тээврийн Цагдаагийн албанд тус тус хүргүүлсэн.

Агаарын чанарын хяналтын хэлтсийн 2019 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гарсан эрх зүйн акт, шийдвэр, Япон улсын агаарын бохирдол бууруулсан туршлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн хаягдал утааны тортогжилтийн хэмжээнд хийсэн хяналт шалгалтын дүнг танилцуулж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нэгдсэн мэдээлэл өгөх зорилгоор ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад нийтийн тээврийн болон сургуулийн хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхлэгч 29 аж ахуйн нэгж, байгууллага, “Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбоо”, МХЕГ, НМХГ-ын 32 улсын байцаагч нийт 69 холбогдох албан тушаалтан хамрагдаж, ном, гарын авлага бэлтгэж тараасан.

7.3. Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, ашиглалт, худалдаа эрхлэгчдэд хийсэн хяналт шалгалт:

7.3.1 НМХГ-ын газрын даргын баталсан 2019.03.25-ны өдрийн 02-01/145 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, хий цэнэглэх станц, шатахуун түгээх станц, автомашиныг хийгээр цэнэглэх станцуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу төлөвлөгөөт

хяналт шалгалтад хамрагдах 8 аж ахуйн нэгжээс 8 /100%/ хамрагдаж газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/-уудын газрын зөвшөөрөл, зориулалт, гэрээ гэрчилгээ, байршил, барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, ашиглалт, газрын тосны бүтээгдэхүүний чанар, хадгалалтын байдалд шалгалт хийхэд 3 (37.5%) их, 2 (25%) дунд, 3 (37.5%) бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Шалгалтаар газрын зориулалт өөрчилсөн, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисст өгөөгүй үйл ажиллагаа явуулсан, газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламж барих газрыг эрх бүхий байгууллагаас олгохдоо “Шатахуун түгээх станц барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” MNS4628:2013 стандарт, “Хийн хангамж” БНБД42-01-04-ийн шаардлагад нийцүүлээгүй, аюулгүйн зай хэмжээг зөрчиж газар олгодог, хэмжилзүйн дотоод хяналтыг байнга хэрэгжүүлдэггүй, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж, дүгнэдэггүй зэрэг 40 зөрчил илрүүлж 15-ыг газар дээр нь арилгууллаа.

Шалгалтаар барилга багууламжийг байнгын ашиглалтад улсын комисст хүлээлгэж өгөөгүй үйл ажиллагаа явуулж байсан Дашваанжил ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд байрлах АХЦС-32, Чингэлтэй дүүргийн 7, 19 дүгээр хороонд байрлах АХЦС-41, АХЦС-Зунжин, Горгаз ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд байрлах АХЦС-2, Бор хуст хайрхан ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн 21 дугаар хороонд байрлах ШТС-уудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож Зөрчлийн тухай хуулийн 7.14 дүгээр зүйлийн 2.5 дахь хэсгийг үндэслэн 4.0 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдууллаа. Мөн шалгалтаар бага дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Монсульт ХХК, Петро хаан ХХК, Жаст ойл ХХК, Лекс ойл ХХК-иудын ШТС, агуулахуудад стандартын хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн 16 заалттай 4 албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн хяналтын цахим системд 100% бүртгэсэн.

7.4. Шахмал түлш үйлдвэрлэгч аж ахуй нэгжид хийсэн хяналт шалгалт:

7.4.1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан “Шахмал түлшний үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх тухай” 02-01/273 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан 12 аж ахуйн нэгжээс 12 (100%) аж ахуйн нэгж хамрагдаж 6 (50%) аж ахуйн нэгж их эрсдэлтэй, 1 (8%) аж ахуйн нэгж дунд эрсдэлтэй үнэлэгдсэн, 5 (42%) аж ахуйн нэгж угаасан нүүрс /мидлинг/-ний нөөцгүй шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй. Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлийн 6-д Улаанбаатар хотын 6 дүүргийн хэрэглэгчдийг зөвхөн Таван толгой түлш

		<p>ХХК-ийн сайжруулсан шахмал түлшээр хангана гэж заасны дагуу дээрх аж ахуйн нэгжүүдэд угаасан нүүрс нийлүүлээгүй тул үйл ажиллагаа явуулаагүй.</p> <p>Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй Таван толгой түлш, МСРТ, Усу коал, Хотын түлш, Ширээтийн хурд, Дэрст тохой, Монгол сайжруулсан түлш ХХК-иудын нүүрсэн шахмал, үртсэн шахмал түлшнүүдээс 28 дээж авч Геологийн төв лаборатори, Ашигт малтмал газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лаборатори, SGS IMME Mongolia лабораториудад шинжлүүлээ. Лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн улсын ахлах байцаагчийн 28 дүгнэлт гаргалаа. Шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй Дэрст тохой, МСРТ, Хотын түлш ХХК-д Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 7500.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэж, эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 02-04-197/295, 296, 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 02-06-037/624 дугаартай албан шаардлагыг Таван толгой түлш ХХК-д тус тус хүргүүллээ.</p>	
1.2	<p>Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 2299 объектод 24 хяналтын чиглэлээр 2837 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх</p>	<p>Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 оны жилийн эцсийн байдлаар 2590 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж шилэн хяналтын цахим системд бүртгэсэн байна.</p> <p>Нийт 2871 ААНБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 351 заалт бүхий 603 зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ бүрэн дуусаагүй байгаа тул шалгуур үзүүлэлтүүд гарах боломжгүй байна. 2. Объектын эрсдэлийн түвшин буурсан. Шилэн хяналтын цахим мэдээллийн сангаар гүйцэтгэл, үр дүнг тооцсон. 1.Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хүртэл пунктээр нэмэгдүүлнэ. 2.Зөвлөмжийн биелэлтийн хувийг 4 пунктээр нэмэгдүүлнэ. 3.Объектын эрсдэлийн түвшин буурсан байна. 4.Шилэн хяналтын цахим мэдээллийн сангаар гүйцэтгэл, үр дүнг тооцно

1.3	<p>Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор, хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйлс байгаа эсэх, түүний шалтгааныг судлан тодорхойлох зорилгоор 30 асуудлаар тандалт судалгаа хийх</p>	<p>Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор, хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйлс байгаа эсэх, түүний шалтгааныг судлан тодорхойлох зорилгоор 7 хяналтын чиглэлээр 29 (96.6%) тандалт судалгааг хийж дууссан, “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS6392:2013 стандартын хэрэгжилт, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагад тандалт судалгаа хийх 1 (3.4%) тандалт судалгаа МХЕГ-т хийгдэхээр болсон. Тандалт судалгаанд нийт 676 объектыг хамрууллаа.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тандалт судалгааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, дүнг 11 удаа дэд даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. 2. Тухайн асуудлаар суурь үзүүлэлт, судалгаа, мэдээллийн сантай үүсгэсэн. 3. Тандалт судалгаанд 522 объектыг хамруулсан. 4. Тандалт судалгаатай холбоотой 4 удаагийн мэдээллийг байгууллагын вэб сайтад байрлуулан, 3 удаагийн мэдээллийг хэвлэл мэдээлийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. 5. Шилэн хяналтын цахим мэдээллийн сангаар үр дүнг тооцон ажилласан.
1.4	<p>Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учруулж буй хор, хөнөөлийг хянах, бууруулах зорилгоор 15 асуудлаар хяналт шинжилгээ хийх</p>	<p>Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учруулж буй хор, хөнөөлийг хянах, бууруулах зорилгоор 5 хяналтын чиглэлээр 15(100%) хяналт шинжилгээг хийж дууссан. Хяналт шинжилгээнд нийт 325 объектыг хамрууллаа.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас бүтээгдэхүүний дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг холбогдох дүрэм журмын хүрээнд явуусан. <p>Шилэн хяналтын цахим системд 125 объектыг бүртгэсэн.</p>
1.5	<p>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 47 асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх</p>	<p>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 8 хяналтын чиглэлээр 46 (97.8%) урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж дууссан. 1(2.2%) урьдчилан сэргийлэх хяналт болох “Уул уурхайн салбарын өргөх байгууламжаас үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” арга хэмжээ МХЕГ-т хамраах тул шалгалт хийгдээгүй.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Шалгуулагч этгээдийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанд 3-р улиралд 26 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. 2. Хяналт шалгалтын явцад шаардлага хангаагүй эсхүл сэжигтэй бараа бүтээгдэхүүн илэрвэл дээж авч, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан.

			<p>3. 26 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж, эрсдэлээс арга хэмжээ авсан.</p> <p>4. Шилэн хяналтын цахим мэдээллийн системд 7508 объектыг бүртгэсэн.</p>
1.6	Үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эхлэхээс өмнөаюул, эрсдэлийг хянах зорилгоор 17 чиглэлээр баталгаажуулах үйл ажиллагаа явуулах	Үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эхлэхээс өмнө аюул, эрсдэлийг хянах зорилгоор 6 хяналтын чиглэлээр 16 (94.1%) баталгаажуулах үйл ажиллагаа явуулсан, байна. Баталгаажуулах үйл ажиллагаанд нийт 408 объектыг хамрууллаа. Боловсролын баримт бичиг баталгаажуулах чиглээр хүсэлт ирээгүй.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдсэн.
1.7	Нийтлэг зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор салбарын 35 сургалтыг зохион байгуулах	Нийтлэг зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор эхний хагас жилийн байдлаар 8 хяналтын чиглэлээр 34(97.1%) салбарын сургалтыг зохион байгуулсан, МХЕГ-т 1 (2.9%) салбарын сургалт хийгдэхээр болсон. Сургалтанд 1277 объект, ААН-ийг хамрууллаа.	<p>1. 30 удаагийн салбарын сургалтыг заасан хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулсан.</p> <p>2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээний сувгуудыг ашиглан давхардсан тоогоор 202 удаагийн сургалтыг олон нийтэд хүртээмжтэй хүргэж сурталчилсан.</p> <p>3. Сургалтаар 482ном, гарын авлага, зөвлөмж хэвлэж түгээсэн.</p> <p>4. Шилэн хяналтын цахим мэдээллийн санд 1138 мэдээллийг бүртгэсэн.</p>
Хоёр. Мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс гүний хяналтын бүсээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, импорт, экспортын барааны аюулгүй байдлыг ханган, гадаад худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:			
2.1	Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 2.1, 2.2; Хил, дамжин халдварлах эрсдэл бүхий мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хилээр нэвтрүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио	Гүний хяналтын бүсээр хил, дамжин халдварлах эрсдэл бүхий мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хилээр нэвтрүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио цээрийн хяналт шалгалт хийж, аюулгүй байдлыг хангуулах зорилтын хүрээнд давхардсан тоогоор нийт 2476 аж ахуйн нэгжийн 62986 тн, 3813937 ширхэг, 30 толгой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд байнгын хяналт шалгалт хийж ажиллалаа. Үүнээс импортын хяналт шалгалтанд 9 улсаас импортолсон 526 аж ахуйн	1.Тус зорилтын хүрээнд гүний хяналтын бүсээр олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх мал, амьтны халдварт өвчин дамжин тархаагүй болно. Мал, амьтны гоц халдварт өвчин хил дамнан халдварлах эрсдэл гарсан үед хариу арга хэмжээг

	<p>цээрийн хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах</p>	<p>нэгжийн, 9816.5 тн, 626916 ширхэг мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, экспортын хяналтаар давхардсан тоогоор 1950 аж ахуйн нэгжийн 13 улсад экспортлогдсон 53169.4 тн, , 3187021 ширхэг, 30 толгой мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийгдсэн. Гүний хяналтын бүсээр нэвтрүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио цээрийн хяналт шалгалт хийж, импортын 386, экспортын 1950 гэрчилгээг баталгаажуулж, хяналт шалгалтын явцад хөрш зэргэлдээ болон бусад оронтой хийсэн гэрээ хэлэлцээр, протокол, санамж бичгийг хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус зорилтын хүрээнд 4 төрлийн зөвлөмжийг 184 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.Тус зорилтын хүрээнд салбарын сургалт зохион байгуулж 26 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулж, сургалтын үр дүнг санал асуулгын хуудсаар дүгнэж ажилласан.</p> <p>Импортын хяналт шалгалтаар 462, экспортын хяналт шалгалтаар 1894, нийт 2025 дээж бараа бүтээгдэхүүнээс авч, лабораторийн шинжилгээнд хамруулан хорио цээр, аюулгүй байдлын шаардлагыг хангуулж, шинжилгээний төлбөр 265.905.700 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.</p> <p>Монгол улсын хилээр нэвтрүүлэх гэрийн тэжээвэр амьтан, хувийн хэрэгцээний зориулалтаар авч гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн экспортын гэрчилгээг 1037 иргэнд олгож, нийт 10.370.000 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, гэрчилгээ олголтын тооцоог сар бүр Санхүү аж ахуйн хэлтэстэй хийж ажиллаж байна.</p> <p>Хяналт шалгалтын явцад нийт 14 зөрчил илрүүлэн, хяналт шалгалтаас зайлсхийсэн 15 ААН-дЗөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын дагуу нийт 14700 нэгжийн шийтгэл ногдуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж ажилласан.</p>	<p>оновчтой төлөвлөн ажилласан, эерэг сорьц гараагүй.</p> <p>2. Импортын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт 1.5 хувиар дээшилсэн.</p>
2.2	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 2.2;</i></p> <p>Хилээр нэвтрүүлж буй ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, ургамал хамгаалах бодист хорио цээр, аюулгүй байдлын хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p>	<p>Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 1110 аж ахуйн нэгжийн 104445 тн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд байнгын хяналт шалгалт хийж ажилласан. Үүнээс ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт шалгалтад давхардсан тоогоор 961 аж ахуйн нэгжийн 97621.89 тн 13 улсаас импортолсон хүнсний улаан буудай, сонгино, олон наст ургамлын үр, буурцагт ургамлын үр, мал, амьтаны тэжээл, арвайн соёолж, тэжээлийн эрдэнэшиш, цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, элсэн чихэр, жимс, жимсгэнэ, нарийн ногоо, газрын самар, кофены буурцаг, элсэн чихэр, хөвдөн хөрс, зэрэг түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийж ажиллалаа.</p>	<p>1. Тус зорилтын хүрээнд гүний хяналтын бүсээр гадаад хорио цээртэй ургамлын өвчин, хортон шавж, хог ургамал хил дамнан тархах эрсдэл гараагүй, импортын ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал бүрэн хангагдаж хилээр нэвтэрсэн болно.</p> <p>2. Импортын ургамал, ургамлын гаралтай түүхий эд,</p>

		<p>Экспортын хяналтыг 149 аж ахуйн нэгжийн 6822.8 тн түүхий эд, бүтээгдэхүүнд хийж, экспортын гэрчилгээ 181-ыг баталгаажуулж ажиллалаа.</p> <p>Их болон дунд эрсдэлтэй бүтээгдэхүүнээс 492 дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг үндэслэн импортын гэрчилгээ 322-ыг олгосон.</p> <p>Лабораторийн шинжилгээний орлого 24,351.300 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Хяналт шалгалтын явцад 29 зөрчил илрүүлэн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын дагуу хяналт шалгалтаас зайлсхийсэн 4 ААН, 2 иргэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн 1 ААН-д нийт 14000 нэгжийн шийтгэл ногдуулж, хялбаршуулсан журмаар бүрэн шийдвэрлэсэн.</p>	<p>бүтээгдэхүүний хорио цээр, аюулгүй байдлын чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь 1.5 хувиар дээшилсэн.</p>
2.3	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 2.2;</i></p> <p>Импортын хүнсний болон бусад бараанд хүнсний чанар, стандартын болон эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p>	<p>1. Тайлант хугацаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр батлагдсан хяналтын хуудсуудаар давхардсан тоогоор 6314 аж ахуйн нэгж, 121 иргэний импортолсон 155952 тн их, дунд эрсдэлтэй бодис бараа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийж гүний хяналтаас чөлөөлж ажиллалаа. Нийт 1354 аж ахуйн нэгж, 78 иргэний 5016 нэрийн бараа, бүтээгдэхүүнийг 3972 үзүүлэлтээр лабораторийн шинжилгээнд хамруулж улсын /ахлах/ байцаагчийн нийт 1354 дүгнэлт гаргасан байна.</p> <p>Лабораторийн шинжилгээний төлбөр 260.225.606 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний эрсдлийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор гүний хяналтын бүсээр импортлогдож буй түүхий эд, бүтээгдэхүүний хяналтын хуудасны санг тухай бүр бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <p>1. 9.3.1. кодтой “Боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас”-аар их эрсдэлтэй 1062 аж ахуйн нэгжийн 24299.68 тн, дунд эрсдэлтэй 3964 аж ахуйн нэгжийн 107639.34 тн, нийт 5024 аж ахуйн нэгжийн 113934.48 тн бүтээгдэхүүн,</p> <p>2. 9.3.2. кодтой “Нялх, балчир хүүхдийн хүнс импортлох үеийн хяналтын хуудас”-аар 57 аж ахуйн нэгжийн 629.27 тн бүтээгдэхүүн,</p> <p>3. 9.3.3. кодтой “Хүнсний сав, баглаа боодол импортлох үеийн хяналтын хуудас”-аар 135 аж ахуйн нэгжийн 889.1 тн бүтээгдэхүүн,</p> <p>4. 9.3.5. кодтой “Янжуур, дүнсэн тамхи импортлох үеийн хяналтын хуудас”-аар 79 аж ахуйн нэгжийн 1417.1 тн бүтээгдэхүүн,</p> <p>5. 9.3.6. кодтой “Хүүхдийн тоглоом импортлох үеийн хяналтын хуудас”-аар 38 аж ахуйн нэгжийн 123 тн бүтээгдэхүүн,</p> <p>6. 9.3.10. кодтой “Хуучин хувцас, эдлэл импортлох үеийн хяналтын хуудас”-аар 73 иргэн, 34 аж ахуйн нэгжийн 2052.9 тн бүтээгдэхүүн,</p> <p>7. 9.3.12. кодтой “Гоо сайхан, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас”-аар 898 аж ахуйн нэгж, 48 иргэний 13785.66 тн бүтээгдэхүүнд</p>	<p>1. Гүний хяналтын бүсээр нэвтрүүлж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар дээшилсэн, лабораторийн шинжилгээрээр эерэг сорьц илрээгүй. Гүний хяналтын талбайгаас чөлөөлөгдөж, гүнээс нэвтэрсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн чанар, аюулгүй байдлын шаардлага хангагдсан. 2. Гүний хяналтын бүсээр тайлант хугацаанд давхардсан тоогоор эрүүл ахуй, халдвар хамгааллын болон хүнсний чанар, стандартын хяналтаар нийт 9270 аж ахуйн нэгжийн импортолсон 257066 тн хүнсний бүтээгдэхүүнийг гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгжийн тоо 2515-аар, бүтээгдэхүүний хэмжээ 47841 тн-оор буюу 18.6 хувиар тус тус өссөн, хилээр нэвтрүүлсэн чанар, аюулгүй байдлын баталгаажилттай</p>

		<p>8. 9.3.7. кодтой “Хүнсний бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас”-аар 12 аж ахуйн нэгжийн 83.15 тн бүтээгдэхүүнд тус тус хяналт шалгалт хийж, мэдээллийн санд бүртгэж ажиллалаа.</p> <p>Хяналт шалгалтын явцад нийт 21 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын дагуу боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн импортлоходоо бичиг баримтын бүрдэл дутуу, хяналт шалгалтаас зайлсхийсэн, хүнсний бүтээгдэхүүн импортлоход тавигдах шаардлагыг зөрчсөн, 13 ААН, 8 иргэнд нийт 17.900 нэгжийн шийтгэл ногдуулж хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ажиллалаа.</p> <p>Хяналт шалгалтын явцад 1 ААН-ийн Казахстан улсаас импортолсон “Mevius option revo blue, Mevius option white” нэрийн 540 хайрцаг, 810 сая төгрөгний хугацаа дууссан янжуур тамхийг гаалийн горимоор устгаж, дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байна.</p> <p>2. Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр нийт 25 улсаас 4140 бүтээгдэхүүнд 9.3.1 кодтой хяналтын хуудсаар хяналт шалгалт хийж гүний гаалийн хяналтын бүсээс чөлөөлж, хяналтын хуудасны санг бүрдүүлэн ажилласан. Байнгын хяналт шалгалтын явцад нийт 20 зөрчил илрүүлэн, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын дагуу боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн импортлоходоо бичиг баримтын бүрдэл дутуу, хяналт шалгалтаас зайлсхийсэн, хүнсний бүтээгдэхүүн импортлоход тавигдах шаардлагыг зөрчсөн 13 ААН, 4 иргэнд нийт 17900 нэгжийн шийтгэл ногдуулж, бүрэн шийдвэрлэж ажилласан байна.</p> <p>Хяналт шалгалтын явцад 1 ААН-ийн Туушин дахь гүний гаалийн хяналтын бүсээр импортолсон 2 нэрийн шар айраг техникийн ерөнхий шаардлагыг хангаагүй тул улсын ахлах байцаагчийн 02-09-09-170/01 тоот дүгнэлтээр ГЕГ-ын даргын батласан журмын дагуу хөлдсөн 3440 хайрцаг, 72880 ширхэг шар айргийг устгасан.</p>	<p>хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн байна. Илрүүлж арилгуулсан зөрчлийн хувьд баримт бичгийн болон чанар аюулгүй байдлын зөрчил 3-4 пункт, тээвэрлэлт, хаяг шошгын зөрчил 5 пунктээр тус тус буурсан.</p> <p>3. Хүүхдийн тоглоом, гоо сайхан, ахуйн хэрэглээний барааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт 7 пунктээр нэмэгдэж сайжирсан.</p>
2.4	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 2.2;</i></p> <p>Импортын эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хийх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p>	<p>Тайлант хугацаанд давхардсан тоогоор импортын хяналтаар 1649 аж ахуйн нэгжийн 18974 тн эм биобэлдмэл, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, урвалж оношлуурын чанар аюулгүй байдалд биет болон бичиг баримтын, лабораторийн шинжилгээт хяналт шалгалт хийж, эрсдэлийг үнэлэн хилээс чөлөөлж ажиллалаа.</p> <p>Хяналт шалгалтаар 2759.62 тн эм, эмийн түүхий эд, 504 ширхэг, 2214.5 тн эмнэлгийн хэрэгсэл, 368.5 тн биологийн идэвхт бүтээгдэхүүн, 0.5 кг вакцин, 1524.14 тн оношлуур, 25,2 тн туслах материалын чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, гүний хяналтын бүсээс чөлөөлж, 1649 ширхэг 9.3.4 кодтой “Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас”-аар эрсдлийг тооцож, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан.</p> <p>Нийт 17 зөрчлийг илрүүлэн арилгуулж, 40 аж ахуйн нэгжийн 119 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнээс дээж авч, МХЕГ-ын эмийн хяналтын лабораторит шинжлүүлж, сорилын дүнг үндэслэн шаардлага</p>	<p>Гүний хяналтын бүсэд импортын эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хууль тогтоомжийн хэрэгжилт 79 хувьтай, өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлсэн байна.</p> <p>Гүний хяналтын бүсээр нэвтрүүлж буй импортын эм биобэлдмэл, эмийн түүхий эд, лабораторийн урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлагыг хангуулж ажиллалаа.</p>

		<p>хангаагүй тухай улсын байцаагчийн 4 дүгнэлт, бүтээгдэхүүн хурааж устгах тухай улсын /ахлах/ байцаагчийн 4 акт үйлдсэн. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан нийт 6 аж ахуйн нэгж, 11 иргэнд 6900 нэгжийн шийтгэл ногдуулан, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж ажиллалаа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг холбогдох заалтыг үндэслэн 1 аж ахуйн нэгжийн “Аменорм” нэрийн 50400 ширхэг, 62.7 кг, 12960000 төгрөгийн үнэ бүхий биологийн идэвхт бүтээгдэхүүнийг ХАБҮЛЛабораторид шинжлүүлэхэд хөгц мөөгөнцөр, агаартан бактерийн тоо хэвийн хэмжээнээс их гарсан, 2 иргэн тусгай зөвшөөрөлгүйгээр БНСУ-аас 39 ширхэг, 1.020.000 төгрөгийн тарилгын уусмал, нүдний линз импортолсон тул улсын байцаагчийн актаар тус тус хурааж, нийт 50439 ш, 13.980.000 төгрөгийн бүтээгдэхүүнийг “Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохиролд нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн зөвлөл”-д шилжүүлсэн.</p> <p>“Энто” ХХК-ийн БНСУ-аас импортолсон “Уранитин” нэрийн 3.7 тн, 202185 ш, 140.056.200 төгрөгийн уусмал эм тээвэрлэлтийн горим алдагдсанаас хөлдсөн тул гаалийн горимоор устгаж, хууль бус орлого болох 360.000 төгрөгийн улсын төсөвт оруулсан.</p> <p>Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагуудын эмийн мэргэжилтэн, менежер, удирдлагуудад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Зөрчлийн тухай хуулиуд, болон холбогдох дүрэм журам тушаалыг мөрдөж ажиллах, эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл импортлоход тавигдах шаардлагыг хангаж ажиллах талаар зөвлөн тусалсан.</p>	
2.5	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөөлөгөөний 2.2;</i> Импортын химийн хорт болон аюултай бодист хяналт хийх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p>	<p>Байгаль орчны хяналтын чиглэлээр импортын хяналт шалгалтад 293 аж ахуйн нэгжийн 40452.7 тн химийн хорт болон аюултай бодис, 34 аж ахуйн нэгжийн 1765 тн тос тосолгооны материал, нийт 327 аж ахуйн нэгжийн 42217.7 тн бодис, бүтээгдэхүүн хамрагдаж, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлсэн байна.</p> <p>Экспортын хяналтаар давхардсан тоогоор нийт 7 аж ахуйн нэгжийн 465 тн баяжмалд хяналт шалгалт хийж, хилээр нэвтрүүлж, хяналтын хуудасны мэдээллийн санг бүрдүүлж ажиллалаа. Химийн хорт болон аюултай бодист тавих хяналт шалгалтыг чангатгах ажлын хүрээнд химийн хорт болон аюултай бодис импортлогч аж ахуйн нэгжийн мэдээллийн сан, хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал халдваргүйтгэлийн бодис болон ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицид импортлогч аж ахуйн нэгжийн мэдээллийн санг тус тус бүрдүүлж ажиллалаа. Лабораторид 583 дээж шинжлүүлж, 11.660.000 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.</p>	<p>Гүний хяналтын бүсээр нэвтэрч буй импортын химийн хорт болон аюултай бодист аюулгүй шаардлагыг хангуулж ажиллалаа.</p> <p>Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, тээвэрлэх үеийн шаардлагын хэрэгжилт 89 хувьтай, өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдүүлсэн байна.</p>

		Монгол Улсын хилээр химийн хорт болон аюултай бодис импортлож буй аж ахуйн нэгжид хууль эрх зүйн, аюулгүй ажиллагааны талаар мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор нийт 80 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлж, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.	
Гурав. “Хяналтын байгууллагын хүнс болон орчны аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагааг хараат бус, үнэн бодит шинжилгээний дүнгээр баталгаажуулж, дэмжлэг үзүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:			
3.1	MNS/ISO IEC 17025:2018 шинэ стандартын дагуу итгэмжлэлд орж, итгэмжлэлийн хугацаагаа сунгуулах, итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг өргөжүүлэх	<p>Стандарт Хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05-р сарын 22-ны өдрийн А/151 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг тус лабораторид 2019 оны 05-р сарын 23-наас 05-р сарын 24-ны өдрүүдэд ажиллаж, итгэмжлэлийн шалгуурыг хангаж буй эсэхэд MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу тус лабораторид үнэлгээ явуулж, дүгнэлт гаргаж ажилласан. Үнэлгээний дүнд 5 жижиг үл тохирол, 17 зөвлөмж өгөгдсөн. Үнэлгээний тайланг авснаас хойш тус лаборатори нь үл тохирлыг залруулах ажлын төлөвлөгөө, зөвлөмжийн дагуу хийгдэх хугацаатай ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргаж, лабораторийн эрхлэгчээр батлуулан ажиллаж, 05-р сарын 24-нээс 06-р сарын 12-ны өдрүүдэд гарсан үл тохирлуудыг залруулж ажиллалаа.</p> <p>Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг хими, хор судлалын лабораторид нийт 54 ангиллын сорилтын шинжилгээг 667 үзүүлэлтээр, үүнээс хүнсний 6, орчны шинжилгээний 5 үзүүлэлтээр итгэмжлэлийн хүрээгээ өргөтгөсөн, нян судлал, ургамал хорио цээрийн лабораторид 59 нэр төрлийн бүтээгдэхүүнээр 293 үзүүлэлт, ургамал хорио цээрийн 5-н нэр төрлийн бүтээгдэхүүнд 19 үзүүлэлт, ВИТЕК 374 үзүүлэлтээр итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг тодорхойлсон. Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт болон үл тохирлуудыг залруулсан ажлын тайлангаа Итгэмжлэлийн газарт 06-р сарын 12-нд хүргүүлж, СХЗГ-ын техникийн хорооны хурлаар 6-р сарын 27-нд орж, 4-н жилээр итгэмжлэлийн эрхээ сунгуулж ажиллалаа.</p>	Итгэмжлэлийн үнэлгээнд амжилттай хамрагдаж, орж, 4-н жилээр итгэмжлэлийн эрхээ сунгуулж ажиллалаа. Сорилт шинжилгээний итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг хими, хор судлал, нян судлал, ургамал хорио цээрийн нийт 1194 үзүүлэлтүүдээр итгэмжлэгдэж, 11%-иар өргөжүүлсэн.
3.2	Лабораторийн шинжилгээний аргын үндэсний стандартуудад үзлэг хийж, 1 стандарт шинээр батлуулах, 5-н стандартыг хянаж, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх	<p>Лабораторийн шинжилгээний аргын үндэсний стандартуудад үзлэг хийж ажилласнаар “Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нян шинжилгээний арга” стандартыг ХАБҮЛЛ-тай хамтран шинжээч Д.Энхтуяа шинээр батлуулахаар эхний техникийн хорооны хуралд орсон. Харин 5-н стандартуудад өөрчлөлт оруулахаар шинжээч нар стандартын төслийг боловсруулж СХЗГ-т хүргүүлсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Campylobacter</i> илрүүлэх шинжилгээний арга MNS ISO10272-99, 2. Халдваргүйтгэлийн бодисын нянд үйлчлэх идэвхийг тодорхойлох нян судлалын арга MNS 6236-2011, 3. Элсэн чихрийн шинжилгээний арга MNS 1752:1973, 4. Хэвийн боов. Техникийн ерөнхий шаардлага MNS 0461:1981, 5. Ахуйн хэрэглээний цаас. Техникийн шаардлага MNS 4273:1995-ын чийглэг тодорхойлох аргын 2,4,3-ын томъёонд өөрчлөлт оруулах зэрэг 	Лабораторид мөрдөж буй шинжилгээний аргын стандартуудыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж, лабораторийн норматив техникийн баримт бичгүүдийн хүчин төгөлдөр байдлыг сайжруулсан.

		стандартуудыг батлуулахаар СХЗГ-ын техникийн хорооны хурлыг хүлээж байна.	
3.3	Лабораторийн хүнсний шинжилгээний хэсэгт мэдээллийн удирдлагын тогтолцоонд хамрагдаж, НМХГ-ын Төв лабораторид нэвтрүүлэх	ХАБҮЛЛ-оос энэ онд хяналтын сүлжээ лабораториуд болох Нийслэл, аймгуудын Мэргэжлийн хяналтын байгууллагын лабораториудад үе шаттайгаар нэвтрүүлсэн. ХАБҮЛЛ-ийн Ерөнхий захирлын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/48 тоот тушаалын хавсралт болох Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх түр журмыг мөрдөж ажиллаж байна. Төв лабораторид Мэдээллийн удирдлагын тогтолцооны системийн /LIMS/ программыг тус лаборатори нь 2019 оны 03-р сарын 27–ноос эхлэн туршиж эхэлсэн. Журмын дагуу уг системийг 8-р сараас бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. 11-р сарын 29-ны өдрийн байдлаар НМХГ-ын Төв лаборатори 9791 иргэн, ААН байгууллага, 3280 сорьцыг тус системд бүртгэсэн.	Төв лабораторид мэдээллийн удирдлагын тогтолцооны систем /LIMS/-ийг үе шаттайгаар туршин нэвтрүүлж чадсан.
3.4	Хүнсний лабораториудын шинжилгээний үр чадварыг сорих хөтөлбөрт жилд 2 удаа хамрагдах	ХАБҮЛЛ-ийн ЭШСЭҮТ-ийн Үр чадварын сорилтын лабораториос илрүүлсэн 2019 оны 1-р ээлжийн үр чадварын тестэнд манай лабораторийн 7 шинжээч 04.10-05.10-ны хооронд тестийг хийж гүйцэтгэлээ. Тестэнд хамрагдсан шинжээч нар үр чадварыг үнэлэх үнэлгээнд ХАНГАЛТТАЙ САЙН үнэлгээ авч, оролцогчийн гэрчилгээ авлаа. 2-р ээлжийн үр чадварыг тестэнд 9 шинжээч, 4 үзүүлэлтээр оролцсон, тестний хариу одоогоор ирээгүй байна. Мөн энэ онд манай лаборатори нь хүнсний микробиологийн шинжилгээ хийх чадвартайгаа харуулах зорилготойгоор АРЕС-ын олон улсын үр чадварын тестэнд 3-н үзүүлэлтээр шинжилгээ хийж, амжилттай хамрагдсан. Тестний үр дүнгээ Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АПЕК) дэмжлэгтэйгээр Хятадын Хяналт, хорио цээрийн академийн шинжилгээний чадавхийг үнэлэх систем (ACAS)-д явуулаад байна. Үр дүнгийн хариу 12-р сард ирэх болно.	Лабораториудын сорилтын үр чадварыг үнэлэх хөтөлбөрт 2 удаа хамрагдаж, <i>хангалттай сайн</i> үнэлгээ авч, лабораторийн шинжээчдийн шинжилгээ хийх үр чадвар сайн байгааг илтгэн харуулсан.
3.5	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээг 2–оос доошгүй чиглэлээр хийх	Төв лабораторийн гүйцэтгэлийн төлөвлөөнд тусгагдсаны дагуу бууз, банш, пестицид, сүү, хэрчсэн гурил, гоймон, бүхэл үрийн гурил, дүфү, кимчи, архи гэх мэт 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний сүүлийн 3 жилийн тандалт судалгааг хийж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж ажиллалаа. Мөн 1-р сард худалдаанд ашиглагдаж байгаа гялгар уутны зузаан тархалтын хэмжээг тодорхойлох судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар үйлдвэр үйлчилгээ болон худалдаанд ашиглагдаж байгаа 240 уутны хэмжилтийг хийж гүйцэтгэлээ. 2019 онд эрүүл ахуйн шаардлага хангаагүй сорьцын судалгааг ХАБҮЛЛ-ийн орон нутгийн лабораториудыг хариуцсан менежерт сард 2 удаа хүснэгтээр хүргүүлж байна. 2019 оны байдлаар нийт 20-н удаа хүнсний эрүүл ахуйн шаардлага хангаагүй 1769 сорьцыг шивж, мэдээллийн санг эрүүл ахуйн шаардлага хангаагүй сорьцын тандалт судалгаагаар бүрдүүлж ажилласан.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний лабораторийн үр дүнд аюулгүй байдлын 4-н тандалт судалгаа, 5-н хяналт шинжилгээний судалгаа хийж, мэдээллийн сантай болсон. Судалгааг ХАБҮЛЛ-ийн орон нутгийн лабораториудыг хариуцсан менежерт сард 2 удаа хүргүүлж ажиллалаа.

Дөрөв. “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, шударга, шуурхай, ил тод байдлыг дээшлүүлэн, цахим системийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:

4.1. Хэрэглэгч, бизнес эрхлэгч, улсын байцаагчдын аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлого, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ.

<p>4.1.1</p>	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилго, Эрсдэлийн удирдлагын стратегийн 2.1.2 заалтын хүрээнд: Хэрэглэгч, бизнес эрхлэгчид хуулийг сайн дураар сахин биелүүлэх соёлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх</i></p>	<p>1. Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г боловсруулан МХЕГ-тай хамтран Сүхбаатарын талбайд Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах нээлттэй өдөрлөгийн үеэр “Хэрэглэгчийн хуудас”, “Шилэн хяналтын цахим систем”-ийг ашиглах, Шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгж, байгууллагын порталыг олон нийтэд сурталчлан, нийт 200 гаруй гарын авлага, тараах материалыг тарааж, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>2. Хэрэглэгч нь худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийж байгаа эсэхэд тандалт судалгаа хийх ажлын удирдамжын хүрээнд иргэн, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдээс 428 судалгааг авч spss програмд нэгтгэсэн.</p> <p>3. Өвөрхангай аймаг болон Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт хэрэглэгчийн хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор тандалт судалгааг хийж, “Хэрэглэгч нь худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа аюул, эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийж байгаа эсэхийг тодорхойлох асуулга”-ын хүрээнд МХЕГ-ын ЭУСТГ-тай хамтран нийт 200 судалгааг авч, SPSS программд нэгтгэн, дүн шинжилгээг хийж, 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр МХЕГ-ын ЭУСТГ-т цахимаар /Able/ хүргүүлсэн.</p> <p>4. МХЕГ-ын ЭУСТГ нь түшиц 6 аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон, санамж бичгийн хүрээнд дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажиллан, бусад бизнесийн байгууллагатай хамтран туршлага хуваалцан, мөн НМХГ-аас Монфа эмийн сан, Удвал дент шүдний эмнэлэг, Жунсон констракшн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, нийт 10 түшиц байгууллагад туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>5. “2018 ны хяналт шалгалтын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудал”, “2013-2018 оны эрсдэлийн төлөв байдал, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудал”, “Шилэн хяналтын цахим системд хяналт шалгалтын мэдээлэл бүртгэхэд анхаарах асуудал” зэрэг сэдвээр нийт 133 улсын /ахлах/ байцаагчдад сургалт зохион байгуулсан.</p> <p>6. 2019 онд 5175 ажахуйннэгж, байгууллага, 12714 иргэнд 369 сургалтыг зохион байгуулсан байна.</p> <p>7. Баянзүрх дүүргийн 2-р хороонд үйл ажиллагаа эрхлэдэг түшиц Траст трейд ХХК-тай хамтран “Ахуйн байрны бүтэц, эрүүл ахуйн шаардлага”</p>	<p>Хэрэглэгчийн хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор судалгааны үр дүнг тооцох, олон нийтэд сурталчилж, хэрэглэгчийг соён гэгээрүүлэх 2 ажлыг зохион байгуулсан.</p> <p>Түшиц 10 байгууллагыг сонгон, санамж бичгийн хүрээнд дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажиллан, бусад 100 бизнесийн байгууллагад туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулсан.</p>
--------------	--	---	--

		сэдэвт үзүүлэх сургалтыг Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай, Нийгмийн хамгааллын тухай багц хуулиудын хүрээнд зохион байгуулж, нийт 68 аж ахуйн нэгж байгууллагын 125 эрүүл ахуйч, технологчидыг хамрууллаа.	
4.1.2	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилгын хүрээнд:</i></p> <p><i>Лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг нэвтрүүлэх</i></p>	<p>1.МХЕГ-аас зохион байгуулсан Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын арга хэрэгслийг сайжруулах” төслийн лабораторийн чиглэлийн олон улсын экспертээр удирдуулсан 2 удаагийн онлайн сургалтанд хамрагдсан. Лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг судалсан.</p> <p>2. МХЕГ-ын ЭУСТГ-тай хамтран “Бизнес эрхлэгчдэд лабораторийн шинжилгээтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлох тандалт судалгааны асуулга”-ыг боловсруулж, Улаанбаатар, Дундговь, Дорнод аймгийн 174 бизнес эрхлэгчид, Улаанбаатар, Дундговь, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 136 лабораторийн ажилтан, улсын байцаагчдаас нийт 310 судалгааг авч SPSS программд оруулан нэгтгэж, дүн шинжилгээ хийн МХЕГ-ын ЭУСТГ-т 12 дугаар сарын 04-ний өдөр цахимаар хүргүүлсэн.</p> <p>3. Лабораториудын ажилтнуудыг эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг МХЕГ-ын ЭУСТГ олон улсын экспертүүдтэй хамтран зохион байгуулахад НМХГ-ын төв лабораторийн эрхлэгч албан хаагчид онлайнаар хамрагдсан.</p>	<p>Лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг судалж, нийцлийн талаар дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулсан.</p> <p>Лабораториудын ажилтнуудыг эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудыг олон улсын экспертүүдтэй хамтран зохион байгуулж хамруулсан.</p>
4.1.3	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилгын хүрээнд:</i></p> <p>Улсын байцаагчийн хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</p>	<p>1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг гарган эмхэтгэл хэлбэрээр хэвлүүлж, Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-үүдийн нийт улсын /ахлах/байцаагдын албан хэрэгцээнд хүргүүлсэн.</p> <p>2. “2014-2018 оны Эрсдэлийн үнэлгээ”, 2018 оныхяналтшалгалтын төлөвлөлт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт, бусад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл”, “Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын гүйцэтгэл”-д тус тус дүн шинжилгээнүүдийг хийж цаашид анхаарах асуудал, зөвлөмжийг боловсруулан эмхэтгэл гаргаж, улсын байцаагч, удирдах ажилтнуудын албан хэрэгцээнд хүргүүлсэн.</p> <p>3. 2019 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-үүдэд цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p> <p>4. 2019 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын гүйцэтгэл, анхаарах асуудлуудын талаах зөвлөмжийг гарын авлага хэлбэрээр хэвлүүлж Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-үүдийн нийт улсын /ахлах/ байцаагдын албан хэрэгцээнд хүргүүлсэн.</p> <p>5. 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтын шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж хэлтсүүдэд хүргүүлнэ.</p>	<p>Хяналт шалгалтын үр дүнд улирал бүр дүн шинжилгээ хийж, оновчтой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэн, аюул, эрсдэлийг бууруулсан эсэх, эрсдэл буурахгүй байгаа шалтгааныг тодорхойлсон.</p>

		6.2019 онд дүүрэг, чиглэлийн хэлтсээр нэг байцаагчид ноогдох ачаалал, хяналт шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийсэн.	
4.1.4	<p>“Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилгын хүрээнд:</p> <p>Эрсдэлийн үнэлгээ болон хяналт шалгалтыг оновчтой, үр дүнтэй гүйцэтгэх баримт бичгүүдийг боловсронгуй болгох</p>	<p>МХГ-аас 2019 оны эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглагдах эрсдэлийн шалгуур, үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах 87, шинээр боловсруулах 10 саналыг нэгтгэн МХЕГ-ын ЭУСТГ-т 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр цахимаар /risk@inspection.gov.mn/ хүргүүлсэн.</p> <p>2019 онд 1.8.Үр тарианы нөөцийг бүрдүүлэн, хадгалж, худалдаалах үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах, 2.2. Ил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах, 2.3. Далд уурхайн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах, 2.4. Баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах, 4.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг ажилтны нийгмийн хамгааллын үйл ажиллагаагаар эрсдэлийн ангилалд хамааруулах, 5.9.Хэмжүүр, хэмжих хэрэгсэл ашиглагч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах, Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтүүд буюу нийт 7 эрсдэлийн шалгуур, үзүүлэлтэд нэмэлт орж, улсын /ахлах/ байцаагчид 2019 оны эрсдэлийн үнэлгээг нийт 40 шалгуур, үзүүлэлтээр үнэлсэн.</p> <p>2019 онд хяналт шалгалтад ашиглагдах хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахад НМХГ-аас 45 хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах 282 санал, шинээр боловсруулах 30 саналыг нэгтгэн МХЕГ-ын ЭУСТГ-т 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдөр цахимаар /risk@inspection.gov.mn/ хүргүүлсэн. Саналыг үндэслэн МХЕГ-ын даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/25 тушаалаар шинээр 17, шинэчлэн 100 хяналтын хуудас батлагдсан. 2019 онд нийт 266 төрлийн хяналтын хуудас хяналт шалгалтад ашиглагдаж байна.</p> <p>2020 онд хяналт шалгалтад ашиглах хяналтын хуудас, хуудасны зөвлөмжийг боловсронгуй болгох саналыг нийт улсын байцаагчдаас авч нэгтгэн МХЕГ-ын ЭУСТГ-т батлагдсан хөтөлбөрийн дагуу 12-р сарын 05-ны өдөр хүргүүлсэн.</p>	Хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулж хяналт шалгалтыг илүү оновчтой, үр дүнтэй хийх нөхцөлийг бүрдүүлсэн.
4.1.5	<p>ТХШТХ-ийн 5⁴, Эрсдэлийн удирдлагын стратегийн “Ил тод байдал ба тайлагналт” 5-р хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд:</p> <p>Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн төлөв байдлын талаар холбогдох төрийн,</p>	<p>НМХГ-ын хэмжээнд 2019 онд нийт 266 улсын /ахлах/ байцаагч 40 эрсдэлийн шалгуур, үзүүлэлтээр 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийлээ. Өмнөх оноос 747 объект буюу 1.7%-иар объектын тоо өссөн. Их 5681 (12.6%), дунд 32766 (73.1%), бага эрсдэлтэй 6404 (14.3%) үнэлэгдсэн. Нийт объектод их эрсдэлтэй объектын эзлэх хувь өмнөх оноос 0.3%-иар, бага эрсдэл 0.2%-иар тус тус буурсан бол дунд эрсдэл 0.5%-иар өссөн.</p> <p>Дүнг НМХГ-ын удирдах ажилтны шуурхай хурлаар хэлэлцүүлж, хурлын протоколын хамт МХЕГ-ын ЭУСТГ-т 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар /risk@inspection.gov.mn/ хүргүүлсэн.</p>	Шинэчлэн боловсруулсан шалгуур, үзүүлэлтээр хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийсэн.

	<p>төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах</p>	<p>МХБ-ын эрсдэлийн үнэлгээний мэдээллийн санд үндэслэн “Эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээний эмхтгэл”-ийг МХЕГ-тай хамтран боловсруулахаар хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлүүдээр дүн шинжилгээг хийж, МХЕГ-ын ЭУСТГ-т цахимаар /able/ хүргүүлсэн.</p> <p>МХБ-ын эрсдэлийн үнэлгээний мэдээллийн санд үндэслэн “Эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээний эмхтгэл”-ийг МХЕГ-тай хамтран боловсруулахаар хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлүүдээр дүн шинжилгээг хийж, МХЕГ-ын ЭУСТГ-т цахимаар /able/ хүргүүлсэн</p> <p>“2014-2018 оны эрсдэлийн үнэлгээ, 2018 оны хяналтын шалгалтын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ” номыг 25 ширхэгийг хэвлүүлэн МХЕГ болон НМХГ-ын нийт удирдлагууд, хэлтсүүдэд 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлж тараасан.</p> <p>2019 оны эрсдэлийн үнэлгээний дүн шинжилгээг дараа оны 1-р сард хийхээр төлөвлөсөн.</p>	
4.1.6	<p>Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - НМХГ-аас 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний эмхэтгэл, - НМХГ-аас 2019 онд хийх хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө, - НМХГ-аас Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, төрийн бусад байгууллагуудад мэдээ, тайлан, төлөвлөгөөний биелэлт хүргүүлэх хуваарь, - НМХГ-ын 2019 оны ширээний календерийг тус тус хэвлүүлэн удирдлагууд болон Чиглэл, Дүүрэг дэх МХХ-үүдэд хүргүүлсэн - НМХГ-ын хяналт шалгалтын объектын судалгааг 2019 оны байдлаар шинэчлэн гаргасан. - НМХГ-аас 2019 онд хийх хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөөний явцыг 14 хоног тутам гаргаж, НМХГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэх төлөвлөгөөт хяналт шалгалтын нэрсийг хууль эрх зүйн хэлтэст 15 удаа гаргаж хүргүүлсэн. - 2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний явцын мэдээллийг ШХЦС-ээс нийт 12 удаа гарган Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-ийн дарга , улсын /ахлах/ байцаагчдад 9 удаа албан бичгээр хүргүүлсэн.- Төлөвлөсөн хугацаандаа хяналт шалгалтын мэдээллийг ШХЦС-д бүрэн бүртгээгүй 38 улсын /ахлах/ байцаагчдад анхааруулах хуудас хүргүүлсэн. - 2019 оны Төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний явцын мэдээг 5 удаа байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн. - 2020 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг хийх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар ханган, НМХГ-ын чиглэлийн болон дүүрэг 	<p>Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан.</p>

		дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагчдын төлөвлөгтийн ажлын гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллаж, ШХЦС-д бүрэн оруулсан эсэхийг хянасан.	
4.1.7	Эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн, дүн шинжилгээ хийж, холбогдох нэгж, байгууллагыг мэдээллээр хангах	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн үнэлгээний нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хяналтын чиглэл, хяналтын нэгж /аймаг, нийслэл, дүүрэг/-ийн 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд МХЕГ-ын ЭУСТГ-тай хамтран дүн шинжилгээ хийсэн.</p> <p>Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт болон хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах 5, шинээр боловсруулж буй 3 хяналтын хуудсанд 3 саналыг тус тус хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 2019 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын гүйцэтгэл, анхаарах асуудлуудын талаах зөвлөмжийг гарын авлага хэлбэрээр хэвлүүлж Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-үүдийн нийт улсын /ахлах/ байцаагчдын албан хэрэгцээнд хүргүүлсэн. - НМХГ-ын хяналт шалгалтын объектын судалгааг 2019 оны байдлаар шинэчлэн гаргасан. - НМХГ-ын 2019 оны хяналт шалгалтын объектын статистик мэдээг өврийн дэвтэр хэлбэрээр хэвлүүлэн Чиглэл болон Дүүрэг дэх МХХ-үүдийн улсын /ахлах/ байцаагчдын албан хэрэгцээнд хүргүүлсэн. 	Алдаагүй, бүрэн, үнэн зөв мэдээлэл бүхий нэгдсэн санг бүрдүүлсэн. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлийг сайжруулж, холбогдох нэгж, байгууллагад мэдээллээр үйлчилж, дэмжлэг үзүүлсэн.
4.2. Мэргэжлийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.			
4.2.1	<i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 10.2 дугаар зорилтын хүрээнд:</i> Аж ахуйн нэгж, байгууллагын порталын ашиглалтыг нэмэгдүүлэх	<p>Байгууллагын вэб хуудаст шилэн хяналтын цахим системийн ААН, байгууллага нэвтрэх Олон нийтийн вебпорталын үйлдлийг /товч/ нэмж байршуулсан.</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллагын порталын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор Дэд бүтцийн хяналтын хэлтэстэй хамтран Алтжин бөмбөгөр худалдааны төвд үйлчлүүлж байгаа иргэд, түрээслэгч нарт, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтэстэй хамтран “Эрүүл аюулгүй орчин–таны оролцоо”сарын аяны хүрээнд хөнгөн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 72 аж ахуйн нэгжид Шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, нийт 330 гаруй гарын авлага брошур тараасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г боловсруулан МХЕГ-тай хамтран Сүхбаатарын талбайд иргэд, олон нийтэд “Шилэн хяналтын цахим систем”-ийг ашиглах талаар 200 ш брошур тарааж, зөвлөгөө өгсөн.</p> <p>Шилэн хяналтын цахим системийн бүртгэлтэй холбоотой саналыг МХЕГ-т хүргүүлсэн.</p>	Аж ахуйн нэгж, байгууллагын портал ашиглалтыг хяналтын байгууллагын 17 нэгж бүр 200-д хүргэж, ашиглалтыг нэмэгдүүлсэн.
4.2.2	<i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 5.3;</i>	Гүний хяналт шалгалтын мэдээллийн санг чиглэл бүрээр бүрдүүлэн, сар бүрийн мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу Мэргэжлийн хяналтын	Хилийн хорио цээрийн хяналт шалгалтын цахим систем

	Хил, хорио цээрийн хяналт шалгалтын удирдлагын цахим системийг байгуулах ажлыг гүйцэтгэх	Ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Цаашид хил хорио цээрийн хяналт шалгалтын удирдлагын цахим системийг боловсронгуй болгох үе шаттай хэрэгжүүлэхэд улсын байцаагчдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр МХЕГ-аас зохион байгуулсан 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 56 улсын /ахлах/ байцаагчдыг хамруулсан.	боловсруулах ажлын даалгавар батлагдсан. Цахим программ боловсруулах компанийг сонгон шалгаруулж холбогдох ажлыг эхлүүлсэн байна.
4.3 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтийг мэдээллээр хангах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.			
4.3.1	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 9 дүгээр зорилгын хүрээнд:</i> Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнг сурталчлан таниулах</p>	<p>Хэвлэл, мэдээлэл: - 2019 онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр 410 сэдвийн мэдээ мэдээллийг 2036 удаа сурталчилж, олон нийтэд хүргэсэн байна. Үүнээс телевизэд 1197, FM радиогоор 89, өдөр тутмын сонин хэвлэлээр 191, байгууллагын вэб сайтаас бусад мэдээллийн сайтуудад 559 мэдээ мэдээлэл байршуулсан. Үүнд: : Хэвлэлийн бага хурал-25, Мэдээ -286, Нийтлэл-21, Ярилцлагын болон зочны цагт -45, Нэвтрүүлэг -9, Шууд сурвалжилга -24-ийг хийлээ. - Тайлант хугацаанд 25 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, 521 хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл авсан. - НМХГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн 6 удаагийн хурлыг 135 хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй түгээлээ. Байгууллагын цахим болон пэйж хуудас: - Байгууллагын цахим хуудсанд зөрчлийн мэдээ 917, зөвлөмж 2168, сэрэмжлүүлэг 73, сургалтын мэдээ 233, бусад мэдээлэл 118, нийт 3610 мэдээ мэдээлэл байршуулсан - “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар” пэйж хуудасны дагагчийн тоо 43302-т хүрч, 19958-аар нэмэгдлээ. Зөвлөмж, мэдэгдэл: - Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 626 зөвлөмжийг 84403 аж ахуй нэгж, иргэнд, 831 мэдэгдлийг 32675 аж ахуй нэгж иргэнд хүргүүлэв.</p>	Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг байгууллагын вебсайтад – 4000, Facebook хуудсанд –3500 контент нийтэлнэ гэсэн зорилт 100 хувь хангагдсан..
4.3.2	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 9 дүгээр зорилгын хүрээнд:</i> Мэргэжлийн хяналтын байгууллагын вебсайтыг шинэчлэх</p>	<p>-Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын цахим хуудас болох www.ub.inspection.gov.mn нь агуулга удирдлагын систем болох Wordpress 4.6 хувилбар дээр хийгдсэн. Тухайн цахим хуудсанд тогтмол update хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. 2019 оны 3 дугаар улиралд Wordpress 5.3.1 шинэчлэгдсэн хувилбар гарч системийн шинэчлэлт хамгаалалт хийгдсэн. -Цахим хуудсанд тогтмол шинэчлэл хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар нийт 3610 мэдээ мэдээлэл байршуулснаас зөрчлийн мэдээ 917, зөвлөмж 2168, сэрэмжлүүлэг 73, сургалтын мэдээ 233, бусад 118 мэдээлэл байршсан.</p>	Мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн веб сайттай болж, иргэд мэдээ, мэдээллийг нэг дороос авах боломж бүрдсэн.

		<p>-Байгууллагын ил тод байдлыг хангаж Тамгын газраас 101 мэдээ байршлаа.</p> <p>-Засгийн газрын 2009 оны 143 дүгээр тогтоол, ЗГ-ын 411 тогтоолын хүрээнд гарсан журам, Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/606 захирамжийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын “Ил тод” байдлын төлөвлөгөө батлуулан хагас, бүтэн жилээр биелэлт гарган ажиллаж байна. Байгууллагын цахим хуудсанд “Мэдээллийн ил тод байдал” цэс үүсгэн, Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн бодлогын ил тод байдал, Төсөв санхүүгийн ил тод байдал цэс үүсгэн тогтмол мэдээ, мэдээллээр ханган олон нийтэд нээлттэй хүргэлээ.</p>	
4.3.3	<p><i>Эрсдэл аюулаас урьдчилан сэргийлэх, иргэд, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, зөвлөн туслах зорилгоор “Сарын аян”-ыг зохион байгуулах</i></p>	<p>Эрсдэл аюулаас урьдчилан сэргийлэх, иргэд, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, зөвлөн туслах чиглэлээр:</p> <p>Хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах ажлын хүрээнд Алтжин бөмбөгөр худалдааны төвд үйлчлүүлж байгаа иргэд, түрээслэгч нарт Хэрэглэгчийн хяналтын хуудас, Шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, нийт 130 гаруй гарын авлага брошур тараан, 50 гаруй иргэд, худалдан авагчдаас 1.11 кодтой Худалдаалах үйл ажиллагаа, “Сав баглаа боодолтой савласан бүтээгдэхүүн /Хүнсний, Хүнсний бус/-ий тоон хэмжээг хэрэглэгч үнэлэх” хяналтын хуудсыг бөглүүлж, судалгаа авсан. Мөн “Эрүүлаюулгүйорчин-таныоролцоо”сарынааяныхүрээндхөнгөн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 72 аж ахуйн нэгжид хэрэглэгчийн хяналтын хуудас, Шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, 200 гаруй гарын авлага, танилцуулга тарааж ажиллалаа.</p> <p><i>Тайлант хугацаанд 4 сарын аяныг зохион байгуулж 32 хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. Үүнд:</i></p> <p>1.Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аяныг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс сарын хугацаанд зохион байгууллаа. Сарын аяны хүрээнд байгаль орчны багц хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчилах, хууль сахин мөрдөлтийг дээшлүүлж төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, ААНБ-ын үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, соён гэгээрүүлэх зорилгоор 30 ажилыг хийж гүйцэтгэн, 16 чиглэлээр 2335 гаруй тараах материал, гарын авлага зөвлөмж, сэрэмжлүүлэг, 4 чиглэлээр 1200 ширхэг боршур,1 чиглэлээр 300 ширхэг плакат хэвлүүлэн тараасан. Мөн давхардсан тоогоор телевизед 3 , үүнээс шууд нэвтрүүлэг 9, радио 6, сонин 8, байгууллагын сайт 93, бусад сайт 6, хэвлэлийн хурал 1, хэлэлцүүлэг 1, үзүүлэх сургалт 3 хийж сурталчиллаа.</p> <p>2.Хөдөлмөр нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтэс, Дэд бүтцийн хяналтын хэлтэс хамтран зохион байгуулсан “Эрүүл аюулгүй орчин-Таны оролцоо” сарын аяны хүрээнд өргөх байгууламжийн угсралт,</p>	<p>Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 3 сарын аяныг зохион байгуулж, хяналтын чиглэл бүрээр иргэд, аж ахуйн нэгжийг соён гэгээрүүлэх, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдлэг мэдээллээр хангаж, зөвлөх, сэрэмжлүүлэх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулсан.</p>

ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг 36 байгууллагын 57 удирдлага, инженер техникийн ажилтанд, авто замын салбарын захиалагч, барилга угсралт, засвар арчлалт, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй болон бусад тусгай зөвшөөрөл бүхий 61 аж ахуйн нэгж байгууллагын 104 инженер техникийн ажилчдад тус тус сургалт зохион байгуулж, зурагт хуудас, сэрэмжлүүлэг боловсруулж, 60 ширхэг хувилж, тараах материал бэлтгэв.

“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хууль бусаар тээвэрлэж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн дагуу 3 сургуулиудын хүүхэд тээвэрлэдэг 28 автобусны техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангасан байдлыг шалгаж, сургуулийн хүүхэд тээвэрлэгч жолооч нарт автобусны бүхээгт байрлуулах зөвлөмж тараав.

3. Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын хэлтэс хамтран “Иргэн таны төлөө - Мэргэжлийн хяналт” сэдэвт сарын аяныг 2019 оны 05 дугаар сарын 01-нээс 31-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сарын аяны хүрээнд нийт 120 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан 12 удаагийн сургалт зохион байгуулж, 138 байгууллагын 560 гаруй иргэнд хүнсний бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар 12 төрлийн зөвлөмж, 3 төрлийн шторк, 3 төрлийн гарын авлага тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгн, 58 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. “Импортын эмийн чанар, аюулгүй байдал, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, нийт 33 эм хангамжийн байгууллагын удирдлага, гаалийн менежер, эмийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Нэг цонхны үйлчилгээнээс олгож буй гэрийн жижиг тэжээвэр амьтан, ахуйн хэрэгцээний мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олголтын үйлчилгээний талаар санал асуулга авч, дүнг нэгтгэж, дүгнэлт хийсэн.

Импортын тахиа, шувууны маханд тандалт судалгаа хийж, . БНХАУ-аас нийт байгууллагын 15 байгууллагын импортолсон тахианы ястай, ясгүй түүхий махны 76 дээжийг авч, цацрагийн шинжилгээнд хамруулсан байна. Олон нийтийн цахим сүлжээгээр цацрагтай байж болзошгүй хэмээн тархсан мэдээллийн дагуу 3 төрлийн матрас, сэрүүн дэр болон триагерц, турмалин, гартаам, нил эрдэнэ, усан болор, ногоон ундром, анар зэрэг байгалийн чулуу, нанотехнологийн тусламжтайгаар бүтээсэн ээмэг, бугуйвч, хүзүүний зүүлтэд цацрагийн хэмжилт хийхэд байгалийн цацрагийн дэвсгэр түвшинд байсан.

Сарын аяны хүрээнд экспорт, импорт, хийлийн хорио цээрийн хяналт, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах, хууль, дүрэм, журмыг сурталчлах зорилгоор НМХГ-ын цахим хуудас, фэйсбүүкт нийт 178 зурагт хуудас мэдээллийг байрлуулан, 5 телевизид 6 удаагийн

		<p>ярилцлага зочны цаг нэвтрүүлэгт оролцон, сарын аяны талаар 3 телевиз, 1 радиод тус тус ярилцлага өгсөн.</p> <p>4.МХЕГ-ын Эрүүл мэнд боловсрол соёлын хяналтын хэлтсээс зохион байгуулж буй “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяны хүрээнд давсны хэрэглээг бууруулахаар бүртгүүлсэн Нийслэлийн оролцогч 39 аж ахуйн нэгж, байгууллагаас 8 буюу 20.5 хувь нь хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын объект байна. Үүнд мах боловсруулах үйлдвэрээс Хос гарьд ХХК, Мах маркет ХХК, Монгол фүүд ХХК, хоол үйлдвэрлэлээс АПУ ХК-ийн ажилчдын цайны газар, Номадс хоспиталити ХХК, Route ХХК, Бродвей сүлжээ зоогийн газрууд бүртгэгдсэн боловч Монгол фүүд ХХК, Макс хотелс ХХК-ийн Холидай айн сүлжээ зочид буудлын ресторан аянд х оролцохгүй болсон. Тус 6 газарт үйлдвэрлэсэн хоол, савласан бэлэн бүтээгдэхүүнд хуваарийн дагуу давсны агууламжийг шинжлүүлсэн.</p>	
<p>4.4. Хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангана.</p>			
4.4.1	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нийцүүлэх ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэвшүүлэх</p>	<p>НМХГ-ын даргын 2019 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаалыг боловсруулан баталгаажуулж, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/11 тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байгаа бөгөөд тус газрын албан хаагчдын 30 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр батуулахаар МХЕГ-т холбогдох эрх зүйн баримт бичгийг хүргүүлсэн.</p> <p><u>Хүний нөөцийн асуудлаар:</u></p> <p>1. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдлийн өнөөгийн байдлыг тодорхойлох, санхүүгийн тооцоолол болон албан хаагчдын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэрт үзлэг хийх, ажилласан жилийг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг НМХГ-ын даргын 2019 оны А/26 дугаар тушаалаар баталсан.</p> <p>2. Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн, Газрын даргын А/08 дугаар тушаалаар нийт албан хаагчдын цалин, төрийн алба хаасан хугацааны, ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.</p> <p>3. Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 99 дүгээр тушаал, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны Б/451 дүгээр тушаалаар нийт 187 албан хаагчдад зэрэг дэвийг шинээр болон хувийг нэмэгдүүлэн олголоо.</p> <p>Шинээр ажилд томилогдох, сэлгэн, шилжүүлэн ажиллах 62 /давхардсан тоогоор/ албан хаагчийн Ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг,</p>	<p>1. Мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж батлуулсан.</p> <p>2. Мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалын жагсаалт гаргаж, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн гаргасан.</p> <p>3. Хүний нөөцийн үйл ажиллагааг шинээр батлагдсан хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>4. Шинээр батлагдах холбогдох журмуудыг Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулсан.</p> <p>5. Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн үйл ажиллагааг шинээр батлагдсан хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулсан.</p>

холбогдох бусад баримт бичгийг Авилгатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан.

4. 2019 онд 40 улсын /ахлах/ байцаачгийн эрх цуцлах, 50 улсын байцаагчийн эрх олгуулах, 211 улсын /ахлах/ байцаагчийн эрх сунгуулах саналуудыг МХЕГ-т хүргүүлэн шийдвэрлүүлээ.

5.Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” 2019 оны Б/01, Б/215 дугаар тушаалын дагуу 509 ажилтан, албан хаагчийн ээлжийн амралтын мэдэгдлийг өгөн, 492 албан хаагчдын ээлжийн амралтыг эдлүүлсэн.

6.Ажилд шинээр томилогдсон 66, ажлаас чөлөөлөгдсөн 57 албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтэрт, 323 албан хаагчийн эмнэлгийн хуудсанд бичилт хийж, шинээр ажилд томилогдсон албан хаагчдыг Тамгын газрын даргад танилцуулан ажлыг хүлээлцүүлэн, хувийн хэрэг нээж, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ажил хүлээлцэх акт үйлдэж, тойрох хуудас болон холбогдох материалыг хүлээж авсан.

7.Хүний нөөцийн асуудлаар ирүүлсэн 426 өргөдөл, 186 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 473 албан бичиг боловсруулан иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлсэн.

8.НМХГ-ын даргын 2019 оны А/26 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэрт үзлэг хийж, ажилласан жилийн судалгааг Нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчаар баталгаажуулсан.

9.Төрийн жинхэнэ албан тушаалын сул гарсан ажлын байрны саналыг Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд сул орон тооны захиалгыг албан бичгээр тус тус хүргүүлсэн.

10. Тус газрын албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албан зөвлөлд 02-01/395 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

11. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолд заасны дагуу түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон бүсэд агаар, орчны бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх болон хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Агаарын чанарын хяналтын хэлтэст 24 цагаар шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгт жижүүрлэн ажиллах Эргүүл хяналтын 24 ажилтаныг томилон ажиллуулж байна.

12.Ерөнхий менежер, нэгжийн менежерийн 2019 оны үр дүнгийн гэрээг боловсруулж, 396 албан хаагчид ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ, Нууцын баталгааны батламж, ашиг сонирхлын гэрээ, 110 төрийн үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ, нийт албан хаагчидтай ёс зүйн болон хариуцлагын гэрээг тус тус байгуулсан.

13.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 29 заалтын дагуу төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:

		<p>1. 2019 онд 389 ажилтан, албан хаагчдыг Төрийн болон МХЕГ, НМХГ, нутгийн захиргааны болон салбарын бусад шагналаар шагнаж урамшууллаа.</p> <p>2.Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд буцалтгүй тэтгэмж 31 албан хаагчдад 4650000, 1 улсын байцаагч өвчний улмаас нас барсан тул 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгож, 2019 онд 14 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах бөгөөд 12-36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг нь төсөвт суулган өгсөн.</p> <p>3.Тус газар Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран Тамгын газар, Чиглэлийн хэлтэс, төв лабораторийн нийт 230 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Эх үрсийн баярыг тохиолдуулан тамгын газрын 73 албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулсан.</p> <p>4.Тус байгууллагад ажиллаж байсан үе, үеийн ахмадуудаа Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.</p> <p><u>Улсын /ахлах/ байцаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлэх зорилгоор:</u></p> <p>1. Улсын байцаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлэх зорилгоор дотооддоо 315 сургалтанд давхардсан тоогоор 2405 улсын байцаагчийг хамруулсан.</p> <p>2. 2017 оноос эхлэн Түшээ дээд сургуультай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд 2019 онд 2 дугаар ангид 27, 1 дүгээр ангид 16, Удирдлагын академи, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУИС, Билиг дээд сургуулиудад давхардсан тоогоор нийт 80, ОХУ, Япон, Украин, Испани, Франц, Израйл, Австри, Чех, Герман, Хятад, Солонгос, Вьетнам гадаад улсад урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан 38, нийт давхардсан тоогоор 118 албан хаагчдад цалинтай чөлөө олгосон байна.</p> <p>3.Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг Тамгын газар болон чиглэл дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн удирдлагуудад болон албан хаагчдад танилцуулж, баталгаажуулсан.</p> <p>4.“Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ыг Дотоод хяналт шалгалт мониторингийн хэлтэстэй хамтран Тамгын газар болон чиглэл дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга болон албан хаагчдад танилцуулан батлагдсан хувиарын дагуу сургалт зохион байгуулсан.</p>	
4.4.2	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	1. НМХГ-ын 370 албан хаагчдын ХАСХОМэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргаж, хянан баталгаажуулж, ХАСХОМ-1 тайланг 02-01/620 дугаартай албан бичгээр МХЕГ-т хүргүүлсэн.	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

	сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах	<p>2. 2019 онд шинээр томилогдсон 38, их хэмжээний өөрчлөлтөөр 3 албан хаагчийн ХАСХОМэдүүлгийг хянан баталгаажуулсан.</p> <p>3. НМХГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.</p> <p>4. НМХГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг А/39 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулсан.</p>	урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулсан.
4.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.			
4.5.1	<p><i>Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 9 дүгээр зорилгын хүрээнд:</i></p> <p>Хамтран ажилладаг гадаадын байгууллага болон холбогдох салбарын чиглэлээр зохион байгуулагдаж буй Олон улсын хурал, семинар, сургалтад Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудыг хамруулах.</p>	<p>2019 онд НМХГ-аас хэрэгжүүлэх Гадаад харилцааны төлөвлөгөөг батлуулж, жилийн эцсийн байдлаар 31 сургалтад 35 албан хаагч оролцоод байна.</p> <p>Үүнд:</p> <p>Сургалт:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Япон улсын Токио хотноо “Аюулгүй байдлыг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалт, ✓ Испани улсад “Аюулгүй ажиллагааны үндсэн асуудлууд болон NPP-ийн үйл ажиллагааны хяналт зохицуулалт” сэдэвт сургалт, ✓ Израйль улсын Тель-Авив хотноо “Цацрагийн эмчилгээний үеийн ослийн бэлэн байдал” сэдэвт сургалт, ✓ БНЧУ-ын Праг хотноо “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төсөл” сургалт, ✓ Франц улсын Парис хотноо “Фукушиша Дайги цөмийн цахилгаан станцын ослын сургалт ба Европын холбооны эрсдлийг давах хүчин зүйл” сэдэвт сургалт, ✓ Солонгос улсын Сөүл хотноо “Үндэсний оношлогоо, эмчилгээний төв байгуулах бодлогын түвшинд шийдвэр гаргагчдад зориулсан сургалт” мөн Эмийн үйлдвэрийн GMP сургалт, ✓ АНУ-ын Иллинойс мужийн Аргонне хотноо “Цөмийн болон цацраг идэвхит материалын хууль бус шилжилт хөдөлгөөн ба цөмийн аюулгүй байдлын талаарх үндсэн элементүүд” сэдэвт сургалт, ✓ БНХАУ-ын ӨМТИС-д “Монгол улсын мал амьтаны өвчнөөс урьдчилан сэргийлэх мэргэжлийн сургалт- 2019” сэдэвт сургалтанд тус тус хамрагдсан. <p>Хурал, семинар:</p> <ul style="list-style-type: none"> ✓ БНБУ-ын Софи хотноо хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үйл ажиллагаатай танилцаж, ажлын туршлага судлах ✓ БНХАУ, БНТУ, Солонгос, ОХУ-дад Экспорт, импортын эрсдэлийн хянан магадлагаа 4 удаа, 	Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд 35 албан хаагч гадаад орны сургалт хөтөлбөрт хамруулах зорилтоос 50%-ийг биелүүлэн ажилласан байна.

		Байгууллагын вэб сайтын “Гадаад харилцаа” буланд сургалтанд хамрагдсан албан хаагчдын илтгэх хуудас, тайланг байршуулан ажиллаж байна.	
4.6 Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.			
4.6.1	“Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” хөтөлбөрийн хүрээнд: Мэргэжлийн хяналтын байгууллагын 2020 оны төсвийн төслийг батлуулах, 2021-2022 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлэх	НМХГ-ын 2020 оны төсвийн төсөл, 2021 төсвийн төсөөллийг 2019 оны 3 дугаар сард Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн. Байгууллагын 2020 оны төсвийг төсөөллийг 2019 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 3,091,883,000 төгрөг буюу 14%-иар нэмэгдсэн дүнгээр төсвийн төслийг хүргүүлсэн байна.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдсан. Төсвийн төслийг нэгж бүрээс авч боловсруулан бодитой төлөвлөж, өнгөрсөн оны тодотгосон төсвөөс 14%-иар нэмэгдүүлж батлуулах төслийг хүргүүлсэн.
4.6.2	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр хэрэгжүүлэх	2019 оны батлагдсан төсвийн хүрээнд Бичгийн цаас, Принтерийн хор, Хэвлэмэл хуудас, Шатахуун, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Монголын мэдээ сонин болон www.tender.gov.mn цахим сайтаар зарлан худалдан авах ажиллагааг зохион байгууллаа. Цахимаар зарлагдсан 5 тендер нь амжилттай зохион байгуулагдан гэрээ байгуулан нийлүүлэлт хийгдсэн. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/460 дугаар захирамжаар Мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх бэхжүүлэх ажлын хүрээнд 400,000,000 төгрөгийн санхүүжилт орж ирснээс 357,040,000 төгрөгийн автомашин 8 ширхэг, улсын байцаагч нарт хэрэглэгдэх хяналтын багаж хэрэгсэл 7 ширхэг, компьютер 70 ширхэг, принтер 15 ширхэг, тавилга эд хогшил 182 ширхэг /Бичгийн ширээ -90 ширхэг, сандал 91 ширхэг, шкаф -1 ширхэг/-г тус тус худалдан авах тендер зарлаж гэрээ хийгдэн тус багаж, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, тээврийн хэрэгслүүдийг хүлээн авч албан хаагчдыг ажилллах нөхцөлөөр ханган ажиллалаа. Байгаль Орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/107 дугаар тушаалаар 154,980,000 төгрөгийн эрх шилжиж ирсэний дагуу худалдан авах ажиллагааг нээлттэйгээр зохион байгуулан явуулын ажлын байр 4 ширхгийг 148 924 496 төгрөгөөр худалдан авсан..	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангах, материаллаг баазыг бэхжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил, урсгал зардлын төсвөөс санхүүжих 5 ажлын худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан.
4.6.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Байгууллагын батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад сар бүр байршуулан ажилласан.	Төсөв, санхүүгийн ил тод байдал хангагдсан.
4.6.4	Системийн хэмжээнд шаардлагатай материалын хангалтыг цаг хугацаанд нь хийх, хуваарилалт болон	1. 2019 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны А/68 тоот тушаалаар тооллого хийх графикайн дагуу хэлтсүүдийн эд хөрөнгийн картыг	Шаардлагатай материалын

	<p>зарцуулалт, хөрөнгийн хөдөлгөөн, мөнгөн хөрөнгийн эргэлтэд өдөр тутам хяналт тавин нөөцийг зохицуулж тайлагнах</p>	<p>шинэчлэн бэлтгэж, эд хөрөнгийн бүртгэлийг коджуулан Чиглэл болон Дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн нийт 1 907 367 153,1 төгрөгийн үндсэн хөрөнгө, 135 820 033,84 төгрөгийн хангамжийн материал тус тус тоолж баталгаажуулан ажилласан.</p> <p>2. Төв лабораторийн сар бүрийн эм, урвалжийн захиалга , нэхэмжлэхийг хүлээн авч нийт 39 ш төлбөрийн хүсэлтээр 56,127,200 төгрөгийн гүйлгээг Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулан хийлгэсэн.</p> <p>3. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай сар, улирлын эцэст тооцоо нийлж, тооцооны үлдэгдлийн баталгаа байгуулан ажиллаж байна.</p> <p>4-р улирлын байдлаар өр, авлага үүсгэлгүй ажиллаж байна.</p> <p>4. 2019 оны 01-11 дүгээр саруудын хүү, торгуулийн орлогын 3,205,656,214 төгрөгийн сар бүрийн мэдээг боловсруулан Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогчтой тооцоо нийлж, мэдээг байгууллагын вэб сайтад байршуулан ажиллаж байна.</p> <p>5. 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 16 хэлтсийн давхардсан тоогоор 3570 улсын байцаагчтай 3,131,097,921 төгрөгийн торгууль шийтгэврийн тооцоо нийлсэн. Үүнээс: Шийтгэлийн хуудсаар :</p> <ul style="list-style-type: none"> • 2033 аж ахуйн нэгж –2,432,184,000 төгрөг • 2383 иргэн – 560,070,000 төгрөг <p>Нөхөн төлбөрөөр: 83 аж ахуйн нэгж, иргэнийг- 138,213,921 төгрөгийн тооцоо тус тус нийлсэн.</p> <p>2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1800 ширхэг үнэт цаасыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас үнэгүй авч маягт-1 нь 1170 ширхэг, маягт-2 нь 2010 ширхэг тус тус зарцуулагдсан бөгөөд тус дүнгээр хуулийн хугацаанд багтаан Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт үнэт цаасны тайланг хэлтэс тус бүрээр гарган тайлагнан ажилласан.</p>	<p>хангалтыг цаг хугацаанд нь хийж, хуваарилсан.</p>
--	---	---	--

4.7 Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашдын зорилтыг тодорхойлно.

<p>4.7.1</p>	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагад хамааралтай бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт болон байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгч, гүйцэтгэл, үр дүнг хангуулах</p>	<p>Бодлогын баримт бичиг:</p> <p>1 “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилт, холбогдох арга хэмжээг тусгасан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г гарган Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж, Дотоод хяналт шалгалт мониторингийн хэлтсээс хяналт шинжилгээ хийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан</p>	<p>1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөний тусгагдсан зүйл, заалтын хэрэгжилтийг үнэн зөв нэгтгэсэн.</p> <p>2. Эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан зорилт, арга</p>
--------------	--	--	---

	<p>хэрэгжүүлэхээр тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг гаргаж, 02-03/1975 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>3. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>4. “Монгол улсын Шадар сайд нийслэлийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээ”-ний холбогдох заалтын биелэлтийг 2019 оны жилийнэцсийн гарган байдлаар гарган 02-01/5045 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>5. “Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-ний холбогдох заалтын биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>6. “Нийслэлийн Засаг даргатай бөгөөд Улаанбаатар хотын захирагч”-ийн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн эхний 100 хоногт зохион байгуулж, хэрэгжүүлсэн томоохон ажлуудын жагсаалтыг гарган 02-01/2306 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>7. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээнүүдийн сүүлийн 3-н жилийн биелэлтийг нэгтгэн гаргаж, НЗДТГ-т тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p><u>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, санал хүргүүлсэн байдал:</u></p> <p>1. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр 2018 оны жилийн эцсийн байдлаар Мэргэжлийн хяналтын байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үүрэгжүүлэн өгсөн нийт 55 шийдвэрийн 13 заалттай арга хэмжээний биелэлт эхний хагас жилд 41%-тай байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар нэгтгэж байна.</p> <p>2. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтод 18 ажлын хүрээнд биелэлтийн дундаж 100 хувьтай үнэлэгдэв. НЗДТГ-т биелэлтийг цахим болон бичгээр хүргүүлсэн.</p> <p>3. “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт”-ын шинэчлэн батлагдахтай холбогдуулан МХЕГ-аас ирүүлсэн төсөлд чиглэл дүүргийн МХХ-үүдээс санал авч нэгтгэн 02-03/851 дугаар албан бичгээр МХЕГ- хүргүүлсэн.</p> <p>4. “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журам”-ын төсөлд оруулах саналыг дэд даргад танилцуулсан.</p>	<p>хэмжээний биелэлт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.</p> <p>3. Үнэлгээний дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, ажлын явц, үр дүнг сайжруулахад нөлөөлсөн.</p> <p>4. Хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлсэн.</p>
--	---	--

		<p>5. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.1-д заасан Улаанбаатар хотын хөгжлийн чиг хандлага, бодлого, үйл ажиллагаанд нийцүүлэн нийслэлийн эрх зүйн орчныг сайжруулах зорилт”-ын хүрээнд тус газраас холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн 02-01/1351 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>6. “Зөрчлийн тухай хууль”-ийн хэрэглээнд гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлын талаар чиглэл дүүргийн МХХ-үүдээс ирүүлсэн нэмэлт өөрчлөлт оруулах саналыг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>7. НМХГ-аас сар бүр хийж томоохон ажлын тайланг МХЕГ, НЗДТГ-т, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хавсралтуудын хамт эхний 3-р улирлын байдлаар гарган МХЕГ-т тус тус хүргүүлсэн, жилийн эцсийн байдлаар хүргүүлнэ.</p> <p>8.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн тайланг НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>9. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 143, Улаанбаатар хотын Ерөнхий Менежерийн 32, МХЕГ-ын цахим шуурхай хуралдааны 92, НМХГ-ын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 269, нийт 536 үүрэг даалгаврын биелэлтийг 100% биелүүлэн ажилласан.</p> <p>10. Чиглэлийн болон дүүрэг дэх МХХ-үүдээс 14 хоног тутам Шадар сайдад танилцуулах мэдээг 23 удаа хүлээн авч нэгтгэн МХЕГ-т хүргүүлэн ажилласан. 7 хоногийн тоон болон бичмэл мэдээг 46 удаа нэгтгэж холбогдох газруудад хүргүүлсэн. Мөн чиглэл болон дүүрэг дэх МХХ-үүдээс сар тутмын хяналт шалгалтын төлөвлөгөө, биелэлтийг хүлээн авч нэгтгэн НЗДТГ-т 11 удаа хүргүүллээ.</p> <p>11.Удирдах ажилтан, улсын /ахлах/ байцаагч, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг сар, улирал бүрээр нэгтгэн гаргаж удирдлагуудад танилцуулж ажиллалаа.</p>	
4.7.2	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд болон улсын байцаагчдын хяналт шалгалтын баримт бичгийн стандартын хэрэгжилтийн байдалд дотоод хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх</p>	<p><u>Дотоод хяналт шалгалт:</u></p> <p>Дотоод хяналт шалгалт мониторингийн хэлтэст нийт 132 /албан бичиг 82, өргөдөл, гомдол 50/ албан бичиг, өргөдөл гомдол ирсэн. Удирдлагаас 22 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүнээс улсын /ахлах/ байцаагчдын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдөл, гомдол 78, хариутай албан бичиг 54 байна. Шийдвэрлэх шатандаа 2, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байхгүй. Улсын /ахлах/ байцаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн 78 өргөдөл, гомдлын 18% нь зөрчлийн хэрэгтэй холбоотой, 33% нь гаргасан эрх зүйн баримт бичгийг хүлээн зөвшөөрөөгүй, 49% нь улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаа болон ёс зүйтэй холбоотой байна. Өргөдөл гомдол, удирдлагаас өгсөн шийдвэрээр хяналт хийж нийт 28 улсын /ахлах/ байцаагчид хөдөлмөрийн дотоод журмын дагуу</p>	<p>ДБХХ, СБД, Багануур дүүрэг дэх МХХ, ХАБХААХХ-т тус тус дотоод хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Хяналт шалгалтын баримт бичгийн стандартын хэрэгжилтийг 2 хувиар нэмэгдүүлсэн.</p>

анхааруулж, 11 улсын /ахлах/ байцаагчид сануулах, 1 улсын /ахлах/ байцаагчид цалингийн 20% 6 сар хүртэл сахилгын шийтгэлийг тус тус ногдуулж, 22 улсын /ахлах/ байцаагч ёс зүйн зөрчлийг гаргасныг тогтоон Ёс зүйн зөвлөлд, 2 улсын /ахлах/ байцаагчийг шалгуулахаар АТГ-т тус тус шилжүүлэн ажилласан байна.

1. Дэд бүтцийн хяналтын хэлтэст хийсэн хяналт шалгалт:

1.1. НМХГ-ын даргын02-01/216 тоот удирдамжийндагуу ДБХХ-ийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийлээ. Зөвлөмжөөр өгсөн 16 үүрэг даалгаврын хэрэгжилт 70% тодорхой үр дүнд хүрсэн гэсэн үнэлгээтэй боловч хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.Байцаагчид хяналт шалгалтын төлөвлөлт хийхдээ ажлын норматив баримтлаагүй, объект дутуу төлөвлөсөн, ажлын ачаалал тэгш бус, ажлын цагаас хоцрох, цаг бүртгүүлээгүй, иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлт өргөдөлд үндэслэл бүхий хариу өгөөгүй, албан үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн зэрэг шалтгаанаар байцаагчдын 45% нь энэ оны эхний 4 сарын хугацаанд сахилгын “сануулах” шийтгэл, анхааруулах хуудас авсан байна. Зарим улсын /ахлах/ байцаагчид прокурорын тогтоол гараагүй байхад иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох, илэрсэн зөрчилд тохирсон арга хэмжээг оногдуулахгүйгээр албан шаардлага өгч холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зэрэг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил бүрэн арилаагүй байна.Шалгалтын дүнг газрын дарга, дэд дарга нарыг байлцуулан хэлэлцүүлж 2 байцаагчид цалингийн 20%, 1 байцаагчид сануулах сахилгын шийтгэл, “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу 10 байцаагчид “Анхааруулга” өгч ажилласан.

2. Сүхбаатар дүүрэг дэх МХХ-т хийсэн хяналт шалгалт:

2.1. “Сүхбаатар дүүрэг дэх МХХ-ийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу ажлын 10 өдөрт Сүхбаатар дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн дотоод ажлын зохион байгуулалт, улсын /ахлах/ байцаагчдын хяналт шалгалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүллээ. Тус хэлтсийн дарга нь хуулиар олгогдсон эрхээ хэтрүүлэн урьдчилан сэргийлэх шалгалт, тандалт судалгааны удирдамжийг баталж шалгалт хийлгэсэн, зарим улсын /ахлах/ байцаагчид нь прокурорын тогтоол гараагүй байхад иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох актыг үйлдсэн, чиг үүрэгт хамааралгүй асуудлаар дүгнэлт гаргасан, илэрсэн зөрчилд тохирсон арга хэмжээг оногдуулахгүйгээр албан шаардлага өгч холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн албан бичиг, өргөдөл гомдлын нэгдсэн системээр ирсэн бичгийг даргаар дамжуулахгүйгээр шууд холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн, хяналт шалгалтын хянагдаагүй баримт бичигт нэгдсэн дугаар олгож архивласан, шаардлагатай материалыг бүрэн хавсаргаагүй зэрэг нь

хэлтсийн удирдлагын дотоод үйл ажиллагаандаа тавих хяналт хангалтгүй байсан. Шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлтсийн даргыг албан тушаал бууруулан, байцаагчдын зөрчлийн байдалд тохируулан 2 улсын байцаагчид сахилгын “сануулах” шийтгэл ногдуулан, мэргэжлийн хяналтын шалгалтын ерөнхий шаардлага стандарт холбогдох дүрэм журам хэрэгжүүлж ажиллаагүй 16 улсын /ахлах/ байцаагчдад “анхааруулга” өгч хариуцлага тооцов.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтэст хийсэн хяналт шалгалт:

3.1. НМХГ-ын даргаас өгсөн үүрэг даалгавар, мэдээллийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн хяналтын 2 улсын байцаагчийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2011 оны 301 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Шуурхай мэдээ, мэдээллийн журам”, Нийслэлийн мэргэжлийн газрын даргын А/49 тоот тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Шуурхай багийн ажиллах журам”, “Шуурхай багийн мэдээ, мэдээлэл дамжуулах схем”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчилд сахилгын шийтгэл ногдуулан үндэслэл байгаа эсэхийг шалгахад тус байцаагчид зөрчлийг анх удаа үйлдсэн, гаргасан зөрчлөө бүрэн ойлгосон зэргийг нь харгалзан үзэж Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-д заасны дагуу сахилгын /сануулах/ шийтгэл ногдуулах саналыг хүргүүлж ажилласан.

4. Багануур дүүрэг дэх МХХ-т хийсэн хяналт шалгалт:

4.1. 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн үйл ажиллагаанд 02-01/386 тоот удирдамжийн дагуу 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс ажлын 8 өдөр гүйцэтгэлийн шалгалт хийлээ. Шалгалтаар улсын байцаагчийн ёс зүй, сахилга хариуцлага сэдвээр сургалт зохион байгуулж, санал асуулга авч ажилласан. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар өгссөн 7 заалт бүхий зөвлөмжийн гүйцэтгэлд шалгалт хийхэд албан хэрэг хөтлөлтийн зөрчил өмнөх оны мөн үеэс 23%, Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” CS11-0223:2013 стандартын зөрчил “Д” норматив 32 %, “О” норматив 23%, “Ё” норматив 39% тус тус буурсан боловч улсын байцаагчид жилийн ажлын төлөвлөлтөө дутуу хийсэн зөрчил арилаагүй байна. Шалгалтын дүнг тус хэлтсийн хурлаар хэлэлцүүлэн Улсын /ахлах/ байцаагчдын ажил үүргийн ачааллыг тэнцвэржүүлэх, хяналт шалгалтыг төлөвлөлтийг нормативын дагуу хийхэд арга зүйгээр хангаж ажиллах талаар удирдлагад болон, улсын /ахлах/ байцаагч нарт анхааруулж ажиллалаа.

5. ХАБХААХХ-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт

5.1 НМХГ-ын даргын 02-01/366 тоот удирдамжаар Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн дотоод ажил, хяналт

		<p>шалгалтын үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан тухайн хэлтэст хамааралтай зорилт арга хэмжээ, үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнд шалгалт хийсэн.</p> <p>Шалгалтаар батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаж байгаа боловч төлөвлөгөөт хяналт шалгалтыг байвал зохих нормативын 45%-д төлөвлөсөн, ажлын ачааллыг тооцоход байцаагчдын 93% нь дутуу гүйцэтгэлтэй, улсын /ахлах/ байцаагчдын үйлдэж буй баримт бичигт хянасан тэмдэглэгээ бүрэн хийгдсэн боловч актны 81%, дүгнэлтийн 42 %, албан шаардлагын 36%, зөвлөмжийн 62%-д зөрчил илэрсэн.</p> <p>Шалгалтын дүнг дэд даргыг байлцуулан хэлтсийн хурлаар оруулан тус хэлтсийн дарга, ахлах болон нийт 13 улсын /ахлах/ байцаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу анхааруулга өгч хариуцлага тооцсон.</p> <p>Илэрсэн зөрчилтэй нь холбогдуулан тус хэлтсийн удирдлагад 5, улсын /ахлах/ байцаагчдад 6 буюу нийт 11 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн.</p>	
4.7.3	<p><i>Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн стандарт, архивын үндсэн зааврын хүрээнд:</i></p> <p>Мэргэжлийн хяналтын байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн явуулж, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх</p>	<p><u>Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлт:</u></p> <p>1. 2019 онд НМХГ-ын хэмжээнд нийт 16103 албан бичиг ирснээс хариутай 8880 албан бичгийн 7601(85,6%) хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа 1125(12,7%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 148(1,6%) хугацаа хэтэрсэн 6 (0.1%) байна.</p> <p>2. Нийт 7864 өргөдөл, гомдол ирснээс 7385(94%) хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа 285(3,6%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 149 (2,5%) байна. Албан бичиг өргөдөл гомдол хуулийн хугацаанд шийдвэрлээгүй давхардсан тоогоор 121 албан хаагчдад Хууль, эрх зүйн хэлтсээс анхааруулга хуудас өгч арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>3. Хагас жилийн байдлаар 7577 гадагш явуулсан албан бичиг, 549 улсын байцаагчийн акт, 2227 улсын байцаагчийн албан шаардлага, 3590 улсын байцаагчийн дүгнэлт, 625 удирдамж, 2910 зөвлөмж, 381 хяналт шалгалтын танилцуулгад нэгдсэн дугаар олгогдсон байна.</p> <p><u>Шуурхай алба:</u></p> <p>1. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, шуурхай үйлчлэх зорилгоор Шуурхай албыг 24 цагаар ажиллуулж нийт 4191 өргөдөл, гомдлыг хүлээн авч 4023 /95.99%/-ийн өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 168 /4.01%/ гомдол шийдвэрлэх шатандаа байна. Тайлант хугацаанд ослын 39 дуудлагаас 20 иргэн нас барж, 22 иргэн гэмтэл авсан байна. Үүнээс: Налайх дүүрэгт 4 осол гарч 7 хүн гэмтсэн. Баянзүрх дүүрэгт 8 осол гарч 2 хүн нас барж, 7 хүн гэмтсэн. Хан-Уул дүүрэгт 13 осол гарч 4 хүн нас барж, 10 хүн гэмтсэн. Сүхбаатар дүүрэгт 4 осол гарч, 1 хүн гэмтсэн. Сонгинохайрхан дүүрэгт 5 осол гарч, 4 хүн нас барж, 3 хүн гэмтсэн. Баянгол дүүрэгт 4 осол гарч 2 хүн нас барж, 2 хүн гэмтсэн. Багануур дүүрэгт 1 осол гарч 1 хүн нар барсан байна. Үйлдвэрийн осол гаргасан 26 аж ахуй нэгж байгууллагад харьяалах дүүргийн Цагдаагийн хэлтэс эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.</p>	<p>НМХГ-ын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль журам, зааврын дагуу явуулж, иргэд байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл хүсэлтийг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг холбогдох дээд байгууллагад тайлагнасан.</p>

2. Хордлогын 16 тохиодол бүртгэгдэж 92 хүн хөнгөн, хүнд хэлбэрээр хордлогод орж ХӨСҮТ-д хэвтэж эмчлүүлсэн байна. Тухайлбал: Сонгинохайрхан дүүрэгт 4 удаагийн хордлого гарч 16 иргэн хордсон, Хан-Уул дүүрэгт 1 удаа хордлого гарч 3 иргэн хордсон, Баянзүрх дүүрэгт 5 удаагийн хордлого гарч 52 иргэн хордсон, Чингэлтэй дүүрэгт 3 удаагийн хордлого гарч 11 иргэн хордсон, Сүхбаатар дүүрэгт 2 удаагийн хордлого гарч 5 иргэн хордсон, Баянгол дүүрэгт 1 удаагийн хордлого гарч 5 иргэн хордсон байна. Шуурхай албаны бэлэн байдалыг тогтмол хангаж, осол хордлогын үед холбогдох арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлж байна.

Архив, албан хэрэг хөтлөлт:

1. Тамгын болон чиглэл, дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдээс Хэрэг хөтлөх нийтлэг журмын дагуу 14117 баримтыг хүлээн авсан.
2. Хадгалах хугацаа /3-5/ жил дууссан 2003-2012 оны 39 хэргийн 1215 хадгаламжийн нэгжийн данс бүртгэлд бүртгэлжүүлж 812 устгах хэргийн жагсаалт үйлдэж, Нийслэлийн Архивын газрын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас лавлагаа мэдээлэл хүссэн 99 албан бичиг, 31 өргөдлийг шийдвэрлэн 426 баримтын хуулбарыг баталгаажуулж олгосон.
4. МУ-ын ЗГ-ын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, НЗД-ын 2017 оны А/252 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, НЗД-ын 2015 оны А/177 дугаар захирамжаар батлагдсан “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам”-уудын биелэлт болон судалгааг гарган Нийслэлийн Архивын газарт албан бичгээр хүргүүлсэн.
5. Дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн 133 албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг зохион байгуулж ажилласан.
6. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 150 дугаар тогтоолын дагуу “Төрийн байгууллагын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-тэй холбогдуулан НМХГ-ын даргын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулан гүйцэтгэлийг хангуулан ажилласан.
7. 2019 оны 10 дугаар сарын 24-өөс 28-ны өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан үзүүлэлт, аргачлалын дагуу “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”, “Байгууллагын архив”, “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа”, “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим

		<p>сан” бүрдүүлж буй байдал гэсэн 4 үндсэн үзүүлэлтээр дүгнүүлж 91.5 хувьтай "МАШ САЙН" үнэлэгдлээ.</p> <p>8. Албан хаагчдын сахилга бат, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдын цагийн бүртгэл, гадуур ажлын дэвтэрт хяналт тавин ажиллаж байна.</p>	
--	--	--	--